

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 10 дугаар сарын 24-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-78

-
- 1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./* 5-40
 - 2. Өвөлжилтийн бэлтгэл ажил, ургац хураалтын явц байдлын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох* 40-57
 - 3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, салбарын үйл ажиллагааны талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээлэл сонсох* 57-78

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
10 дугаар сарын 24-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 06 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Р.Сэддорж;
Чөлөөтэй: С.Ганбаатар, С.Лүндэг.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Довчинсүрэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Нямхүү, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Хуулийн хэлтсийн дарга М.Солонго, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Д.Рэнцэнмядаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх

Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, Б.Уянга, Ж.Батжаргал, М.Мандхай, Ц.Идэрбат, М.Ганхүлэг, Л.Мөнхбаясгалан, Н.Наранбаатар, Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ, З.Мэндсайхан нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Өвөлжилтийн бэлтгэл ажил, ургац хураалтын явц байдлын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Довчинсүрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал эмнэлгийн хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар нар байлцав.

Өвөлжилтийн бэлтгэл ажил, ургац хураалтын явц байдлын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, П.Батчимэг, Ц.Идэрбат, Г.Ганбаатар, Б.Бейсен нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал эмнэлгийн хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүх нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Замира, Г.Ганбаатар, Б.Бейсен нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Өвөлжилтийн бэлтгэл ажил, ургац хураалтын явц байдлын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, салбарын үйл ажиллагааны талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Нямхүү, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Хуулийн хэлтсийн дарга М.Солонго, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын ахлах зөвлөх С.Ламбаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох, Хяналт шалгалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт С.Тэгшжаргал нар байлцав.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, салбарын үйл ажиллагааны талаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, Б.Уянга, Л.Мөнхбаясгалан, С.Замира, П.Батчимэг, А.Ундраа, Б.Бейсен нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, С.Замира нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, салбарын үйл ажиллагааны талаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 14 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 54 минут үргэлжилж, 21 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 81.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон
“Жанжсин Д.Сүхбаатар” танхим,
10 цаг 06 минут

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Б.Бейсен: Эрхэм Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж ирц 57 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдааны ирцийг танилцуулъя. Жигжидийн Батжаргал гишүүн 5 дугаар тойрог ирсэн байна. Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн. Сонгойбайн Замира гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Загджавын Мэндсайхан гишүүн ирсэн. Ухнаагийн Отгонбаяр ирсэн байна. Сэддорж гишүүн орон нутагт томилолттой, чөлөөтэй явж байгаа. Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна.

Хэлэлцэх асуудалд оръё. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай /Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг хийгээд санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

2 дугаарт, Өвөлжилтийн бэлтгэл ажил, ургац хураалтын явцын байдлын талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох,

3-д Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, салбарын үйл ажиллагааны талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу. Байхгүй байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Сангийн сайд ирсэн үү. Сангийн сайд орж ирж байгаа юм байна. Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Сангийн сайд Жавхлан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Одонтуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Золбоо, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Батмөнх, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Сангийн яамны Санхүү, зээл, даатгалын хэлтсийн дарга Амарбаясгалан, Сангийн

яамны Санхүү, хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Тулга, Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Монгол Улсын Ерөнхий аудитор Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүүнийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг ирээгүй байна уу. Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд ирээгүй байна уу. Аудитын газрынхан яагаад ирэхгүй байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Төрийн нарийн бичгийн дарга Баттулга, Усны газрын дарга Батбаяр ирсэн үү, ирээгүй байна уу. Ойн газрын дарга Оюунсанаа ирээгүй байна уу. Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Оюунжаргал, Одонтуяа дарга танай яамныхан ирээгүй байгаа юм уу. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын зөвлөх Уртнасан, Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Уранчимэг, Ирж амжаагүй байгаа юм уу. Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Энхмөнх байна. Тусгай хамгаалалттай газрын бодлогын хэрэгжилтийн газрын дарга Батцогт. Ирээгүй байна даа. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Нямхүү. Байна уу, ирээгүй байна уу. Салбарын хяналтын газрын дарга Мөнхтогтох, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн. Ирээгүй байгаа юм уу. Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ ирсэн байна. Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Наранчулуун байна уу. Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Дондогдорж, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Нарантуяа. Орж ирээгүй байна. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Тулга байна. Жижиг, дунд үйлдвэрийн газрын

дарга Эрдэнэсайхан ирээгүй байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч Рэнцэнмядаг байна. Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогын газрын Инновацын бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Энхжаргал ирээгүй байна. Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Даваадалай ирээгүй байна уу. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Энхжин ирээгүй байна.

Сангийн сайд ирээгүй байна уу. Энхбаяр сайд танилцуулах юм уу.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр танилцуулна.

Ж.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Ирэх 2025 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны бүтэн жил учраас төсвийн бодлогыг бүсчилсэн хөгжилд зайлиггүй шаардлагатай суурь дэд бүтцийг шийдэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, нийслэлийн тулгамдсан

асуудлыг шийдэхэд чиглүүлснээрээ өмнөх жилүүдээсээ ялгаатай юм.

Шинэ 30 жилийн хөгжлийн суурийг тавих томоохон төрийн оролцоог багасгаж хувийн хэвшлийг дэмжихэд чиглэсэн 2025 оны төсөвт Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих чиглэлээр тусгасан онцлох арга хэмжээг дурдвал:

1. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт шинжлэх ухаан, үйлдвэрлэл, хүний нөөцийн цогц бодлого хэрэгжүүлнэ. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт төвийн бүсийг эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэржилт эрчим хүчний дэд бүсээр тодорхойлж, энэ хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан судалгаа хөгжлийн төв байгуулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг үе шаттай нүүлгэх зорилт тусгагдсан. Үүний дагуу хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг харьяа байгууллагуудын хамт Дархан хот руу 2025 онд нүүлгэх ажлыг зохион байгуулах бөгөөд шаардагдах зардлыг төсвийн төсөлд тусгалаа.

2. Өсөн нэмэгдэх хүнсний хэрэгцээг хангах зорилгоор Атрын 4 дүгээр аяныг хэрэгжүүлж, хүнсний хангамж, аюулгүй байдал, цагаан алт, шинэ хоршоо, чинээлэг малчин зэрэг үндэсний хэмжээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж хөдөө аж ахуйн салбарын хөнгөлөлттэй зээлийн хүүгийн дэмжлэгийг үргэлжлүүлнэ.

3. Засгийн газраас хэрэгжүүлж буй ногоон хөгжлийн бодлогыг эрчимжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг байгальд ээлтэй хөгжлийг дэмжсэн хэлбэрээр зохион байгуулж, агаар орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй

санхүүгийн бүтээгдэхүүний төрөл хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглүүлэх болно. Энэ хүрээнд банкаар дамжуулан айл өрхийг эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцад хамрагдах боломжоор хангах, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, байгальд ээлтэй хэрэглээ, үйлдвэрлэл, тогтвортой хөгжлийг дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд чиглүүлнэ.

Монгол Улсын 2025 оны төсвийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлснээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 33,9 их наяд төгрөг, суурь зарлага 32 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,9 их наяд төгрөгийн ашигтай байхаар гарч байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Бейсен: Энхбаяр сайдад баярлалаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн Аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. 5 номер.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өглөөний мэнд өргөн дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг хянаж үнэлэхэд чиглэсэн.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засаг, нийгмийн тулгамдсан болон хугацаа шаардсан суурь асуудлуудыг шийдвэрлэж эхлэх, бүсчилсэн хөгжлийн цогц реформын эхний шат болон нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэх зорилт тавьсан байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тэнцвэржүүлсэн орлого 33 их наяд 864,7 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35,6 хувь, нийт зарлага 35 их наяд 795,2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37,7 хувь, төсвийн суурь тэнцэл 1 их наяд 909,5 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 930,5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын

төсвийн багцыг дараах байдалтай төлөвлөжээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд 904,7 тэрбум, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд 337,8 тэрбум. Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2025 оны төсвийн төслийг 2024 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын харьяа байгууллагын төсөвт төвлөрүүлэх орлогыг 0,4 тэрбум төгрөгөөр бууруулж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын харьяа байгууллагуудын төсөвт төвлөрүүлэх орлогыг 0,8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөснөөс шалтгаалж нийт орлогын дүн 0,4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 2024 оны тодотгосон төсвөөс 286,2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын урсгал зардлын төсвийг 221,9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн, 777,5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 7,2 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 6,4 тэрбум төгрөг, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг 217,4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 17 төсөл, арга хэмжээний нийт 44,9 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 7 төсөл, арга хэмжээнд 27,6 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын урсгал зардлын төсвийг 26,6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн, 246,3 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэлт урамшууллын зардлыг 7,6 тэрбум төгрөг,

байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 1,1 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамжийг 17,3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой.

Хөрөнгө оруулалтын төсвийг 13 төсөл, арга хэмжээ нийт 91,5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 2 төсөл арга хэмжээнд 36,3 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан шалгуурыг хангасан гэж дүгнэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Загджав даргад баярлалаа. Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүн байна уу. Нэрсээ өгье. Мөнхбаясгалан гишүүнээр тасалъя. Сангийн сайдыг дуудъя. Хуралдаан давхацсан гэсэн. Сангийн сайдыг иртэл Отгонбаяр гишүүн асуулт асууя. Холбогдох хүмүүс нь хариулаарай. Төрийн нарийн байгаа юм байна. Сангийн сайдаа дуудаарай.

У.Отгонбаяр: Энэ өглөөний мэндийг хүргэе. Хөдөө аж ахуйн салбарын төсөвтэй холбогдуулж бас асуулт байна. Хөдөө аж ахуйн салбарын төсөв 2024 оны тодотголоор батлагдсан төсвөөс даруй 26,4 хувиар нэмэгдэж орж ирж байгаа. Тэгэхээр би бол ер нь энэ хөдөө аж ахуйн салбарын

төсвийг нэлээн бас чамбай, оновчтой хүрэх ёстой газраа хүрэх ийм боломжтой төсөв орж ирж байна гэж үндсэндээ үзэж байгаа. Яах вэ, ер нь аливаа юмны хүсэл бол хэзээ ч дуусашигүй. Нэмэгдээд байвал нэмэгдээд байх боломж бас байгаа. Энэ дээр энэ татаас дээр бас тодруулга байна. 2024 оны тодотголоор 337 тэрбум төгрөгийн татаас 2024 оны тодотголоор, 2025 оны улсын төсөвт 554 тэрбум. Тэгээд энэ нь хувийн хэвилийн байгууллагад олгох татаас гэж байгаа юм. Энэ яг одоо миний ойлгож байгаагаар бол Шинэ хоршоо, Чинээлэг малчин, Цагаан алт гэх мэтчилэн хөдөө аж ахуйг дэмжих, малчдыг дэмжих зорилготой хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрт олгох зээлийн татаас гэж ойлгогдож байгаа. Энэ татаасаар 2025 онд жишээ нь хоршооны зээл хэчнээн төгрөгийн зээл олгогдох боломжтой татаас энэ улсын төсөвт сууж байгаа юм бэ. Үүний цаана хэдэн малчин өрх энд хамрагдаж зээл авч, ахуй амьжиргаагаа дээшлүүлэх боломж, бололцоо бүрдэж байгаа вэ. Энэ талаар бас нэлээн тодорхой мэдээлэл өгөөч.

Б.Бейсен: Хэн хариулах вэ. 6 номер. Хөдөө аж ахуйн сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Хүнс, хөдөө аж ахуйн салбарын төсөв нэмэгдсэн байгаа. Нэг зүйлд гишүүдийг анхаарал хандуулаасай гэж хүсэж байна. Хөрөнгө оруулалт буюу шинээр нэмэгдэж байгаа ийм хөрөнгө оруулалт үндсэндээ байхгүй. Нийт салбарын хэмжээнд 5,9 тэрбум төгрөгийн л хөрөнгө оруулалт байгаа. 1,6 тэрбумаар худаг гаргана. 1,6 тэрбумаар нийт 21 аймгийнхаа Хөдөө аж ахуйн газрын тоног төхөөрөмж, шаардлагатай багажийг авна. 1,6 тэрбумаар нийт 21 хөдөө аж ахуйн газрынхаа их засварт тодорхой хэмжээний үйлчилгээ хийнэ буюу сайдын захиран зарцуулах хөрөнгө 5,9. Бусад тэр өндөр өсөлттэй гарсан 777 тэрбум төгрөг буюу энэ урсгал зардал юу вэ гэж. 1 дүгээрт Хүнсний хувьсгал 196,1

тэрбум, Цагаан алт хөтөлбөрт 113,2 тэрбум, Атрын 4 дүгээр аян 98,7 тэрбум, Шинэ хоршоо хөдөлгөөнд 193,4 тэрбум төгрөгийн арилжааны банкнаас олгосон зээлийн хүүгийн татаасанд зарцуулагдаж байгаа. Нөгөө талаар бодлогын том өөрчлөлт нь өмнө нь яам, агентлаг шийдвэр гаргаад зээл олголт, хөрөнгө оруулалтыг шийддэг байсан зүйлээс татгалзсан. Зөвхөн арилжааны банкаар дамжсан, арилжааны банканд шалгагдсан төслүүдийг санхүүжүүлнэ. Тэр санхүүжүүлсэн арилжааны банк нь санхүүжүүлсэн зээлийн 10-12 хувийн хүүгийн дэмжлэгийг л яамны төсвөөр урсгал зардлаар дамжуулж олгож байгаа зүйл.

Мөн салбарт 5 төрлийн урамшуулал байгаа. Үйлдвэрт тушаасан 1 литр сүү тутамд 1 мянган төгрөг, борлуулсан ногооны 1 тонн тутамд 100 мянган төгрөг, гурилын үйлдвэрт тушаасан улаан буудайн 1 тонн тутамд 85 мянган төгрөг, ноосон дээр үйлдвэрт тушаасан ноос тутамд 2 мянган төгрөг, нэхий дээр үйлдвэрт тушаасан нэхий тутамд 3 мянган төгрөг, үйлдвэрт тушаасан сарлагийн хөөврийн 1 килограмм тутамд 10 мянган төгрөг гэх мэтийн үйлдвэрлэлээ дэмжсэн ийм санхүүжилтийн бодлого байгаа. Ингээд та бүхэн Хүнсний хувьсгал, Цагаан алт, Шинэ хоршоо, Атраа харвал бүгд нэг цогц. Шинэ хоршоогоороо малчдаа зохион байгуулалтад оруулаад, үйлдвэрээрээ хорших, нөгөө талдаа үйлдвэрлэлийн түүхий эдийг бэлтгэх анхан шатын шаардлагыг хангах ийм зохион байгуулалт хэлбэрээр оруулаад үйлдвэртэй нь холбож байгаа юм. Үйлдвэр лүү түүхий эдийг нийлүүлэх. Ингээд Цагаан алтаараа тэр тосож авсан түүхий эдээ боловсруулах, боловсруулсан түвшинээ сайжруулах бодлого нь бол үйлдвэрлэлийн бодлогоороо, Атрын 4 дүгээр аянаараа энэ тариа ногоо хөрс хамгаалал буюу энэ тарих ургуулах талыг нь идэвхжүүлээд, Хүнсний хувьсгалаараа хүнсний үйлдвэрүүдээ дэмжээд гаргах буюу энэ

өөрөө ингээд цогц. Үндсэндээ энэ 4 том бодлогыг нийлүүлбэл ерөөсөө хөрс, малын эрүүл мэнд, мал эмнэлэг гэсэн гол суурь дээр л явж байгаа бодлого.

Уул уурхайгаас хэт хамааралтай Монгол Улсын эдийн засаг 95, 96 хувь гэж гарч байгаа. Уул уурхайн экспортын таатай үеийг ашиглаад хүн амын ажиллах хүчний 600 мянга буюу 2 хүний 1 нь энэ салбарт ажиллаж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний 30,6 хувь энэ салбарт үйлдвэрлэгдэж байгаа. Нийт экспортын 6,4 хувийг эзэлж байгаа. Орон нутгийн эдийн засгийн 85 хувийг хөдөө аж ахуйн салбар ноогдож байгаа. Энэ салбараа энэ уул уурхайн таатай үеийг ашиглаад бодит жсоохон бодлогын хөрөнгө оруулалт үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээд нэг бэхжүүлээд нэг шатны түвшинд гаргая гэсэн бодлого л хэрэгжиж байгаа. Энэ бодлого өмнөх Их Хурлаас эхэлсэн. Ихэнх нь.../минут дуусав/

Б.Бейсен: 1 минут гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ бодлогуудын 4 том бодлогын 3 нь үндсэндээ өмнөх Их Хурлуудаар батлагдаад хэрэгжиж байгаа. Жишээлбэл, Хүнсний хувьсгал хөтөлбөр бол хэрэгжээд 2,5 жил болоод явж байна. Энэ нь бүх хөтөлбөрүүд 2028 онд эцэслэн дүн гаргах ийм зорилготой явж байгаа. 5-6 жилийн хөтөлбөрүүд байгаа. Цагаан алт хөтөлбөр гэхэд л энэ 2024 он хавраас эхэлсэн. Одоо 2 дахь жилдээ орж байна. Шинэ хөтөлбөр буюу энэ шинэ Засгийн газрын оруулж байгаа хөтөлбөр бол Атрын 4 дүгээр аян буюу 98,7 тэрбум төгрөгөөр Атрын 4 дүгээр аяныг бодлого болгож оруулж ирж байгаа юм. Ингээд хэлбэл энэ 4 цогц бодлого хэрэгжсэнээр Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар тогтвортой байдлыг хангах, экспортыг нэмэгдүүлэх, одоо байгаа 600 мянган хүний ажлын байрыг тогтвортой барих, нөгөө талаас экспортын бодитой ийм боломж байна. Нийт 980 орчим сая долларын экспорт

салбар хийж байгаад 2 тэрбум долларт хүргэх ийм зорилт тавиад.../минут дуусав/

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Миний сая голлож асуусан зүйл бол энэ 554 тэрбум төгрөг хэчнээн төгрөгийн зээлийн хүүгийн татаасанд явах юм бэ. Энэ нь жишээ нь хоршоо, цагаан алт хөтөлбөрийн ер нь хэчнээн малчин өрхөд хүрэх боломжтой тэр зээлийн дүн ийм тооцоо судалгаа байна уу. Энэ дээр бас нэг тодорхой тоо хэлж өгөөч.

Б.Бейсен: Хэн хариулах вэ. Хөдөө аж ахуйн сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ түрүүн Шинэ хоршоо хөдөлгөөн дээр 193,4 тэрбум төгрөг гэж байгаа. Энэ өөрөө 100 хувь татаас. Нөгөө зээлийн хүүгийн 10-12 хувийн зээлийн хүүгийн дэмжлэг нь ингэж харагдаж байгаа. Энэ нь цаанаа өөрөө энэ чинь бараг 5 их наядын мал аж ахуйн салбарт өгөх санхүүжилт байхгүй юу. Үүнээс 2024 онд бид нар 1 их наядыг гаргаж явна. 2025 онд 500 тэрбум нэмэгдэж байгаа. Ингээд 1,5 их наяд төгрөг манай 300 мянган малчид буюу хоршсон тэр хоршоолол дээр очно. Хоршоод малчдаа хоршоожуулахыг л бид нар шахаад идэвхжүүлээд байна гэсэн үг. Хоршоолсон, хамтран ажиллаж байгаа энэ бүлэгт л энэ зээлүүд олгогдоно. Тэр олгосон зээлийг 1 төгрөгийг л бид нар 5 төгрөг, 10 төгрөг болгоод байна л гэсэн үг. Тэгэхээрээ зөвхөн яг бизнесийн зарчмаар арилжааны банкаар эрсдэлээ хүлээгээд шалгуураа аваад явж байгаа юм.

Б.Бейсен: Отгонбаяр гишүүн тодруулъя.

У.Отгонбаяр: Энхбаяр сайдын хэлснээр бол тэгвэл зөвхөн 2025 онд хоршоонд зориулсан 5 их наяд төгрөгийн

татаас энэ 550 тэрбум төгрөгт суусан гэж ойлгож байна. Зөв биз дээ.

Б.Бейсен: Сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ юу юм байгаа юм шүү. Шинэ хоршоо хөдөлгөөн маань өөрөө нийт 5 их наяд төгрөгийн эх үүсвэр зээл малчдад, хоршоод очно. Энийгээ 5 жилийн хугацаанд явуулна. 2024 онд 1 их наяд төгрөг зээл олгогдож байгаа, 2025 оны төсөв дээр нэмэгдээд 500 тэрбум төгрөгийн зээл олгогдож байгаа. Тэрний хүүнийх нь татаас нь 150 орчим тэрбум төгрөг байгаа. Үлдээд байгаа 50 орчим тэрбум нь тэр зээлийг батлан дааж байгаа зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж байгаа. Тэгэхээр энд ахиад энэ тоо нэмэгдээд л явна гэсэн үг. 5 их наяд хүртэл явна. 2028 он хүртэл. Тэгэхээр энэ бүрэн эрхийн хугацаанд малчин өрхөд хоршоолсон малчдад 5 их наядын зээл санхүүжилт очно. Гол нь малчдаа зохион байгуулалтад оруулъя. Байгаль цаг уурын бэрхшээлийг даван туулдаг чадавхыг бий болгоё.../минут дуусав/

Б.Бейсен: Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Өглөөний мэнд хүргэе.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр асуучихсан учраас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны төсвийн төсөлтэй холбоотой асуултыг асууя.

Одонтуяа сайд нөгөө түрүү 7 хоногийн 5 дахид чуулган дээр сайдын багц буурсан. Төсөв нь ер нь танагдсан гэсэн тайлбар өгсөн. Одоо энэ төсвийн төслийг харахад 2023, 2024, 2025 оныхтой харьцуулаад харахад 2024 онд нийт зарлага, цэвэр зээлийн дүн нь 240 тэрбум байсан бол өнөөдөр 337 тэрбум байгаа харагдаж байна. Тэгэхээр өссөн байгаад байх юм. Дотоод задаргааг нь

харахаар бараа үйлчилгээний бусад зардал нь 90 сая төгрөгөөр буурсан байна уу даа. Тэгэхдээ бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр бол өссөн байгаад байна. Энд нь нөгөө бид нарт хэрэгтэй байгаа төсөл хөтөлбөрүүд байгаа болов уу гэж бодож байна. Хөрөнгийн зардал бас даруй 71 тэрбум төгрөгөөр өссөн юм байна. Зарим хөрөнгө оруулалтууд нь бас тэнчээнээ орж байгаа байлгүй. Тэгээд энэ дээр тайлбар хэлээд өгөөч сайд аа.

2 дугаар асуулт нь болохоороо Байгаль орчин, уур амьсгалын сан гээд байдаг байна. Тэгэхээр энэ сангийн үйл ажиллагаа хэрхэн төлөвлөгдөж байгаа вэ 2025 онд. Ер нь энэ санд мөнгө хэрхэн төвлөрдөг юм. Яаж зарцуулагддаг юм. Тэгээд 2025 оныхоо төлөвлөгөөг энэ сантай холбоотойгоор хэлээд өгөөрэй.

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Уянга гишүүний асуултад хариулъя. Байгаль орчны сантай холбоотойг төрийн нарийн бэлдэж байгаарай. Манай салбарын хувьд бол ер нь байгаль орчны салбарт хэрэгцээтэй хөрөнгө оруулалтыг ингээд ерөнхийд нь нийт дүнгээр гаргаж үзэхэд 11 тэрбум доллар шаардлагатай гэсэн ийм тооцоо судалгаа байдаг. Гэхдээ манай улсын боломжийн хувьд бол туйлын бид нар бас бага зүйлийг эндээ зарцуулдаг. Яах вэ нөгөө талаас сайн тал нь гэвэл гадаадын буцалтгүй тусламж, төсөл хөтөлбөрүүд бол энэ салбарт бас нэлээдгүй орж ирдгээрээ энэ асуудлыг нөхөөд байдаг. Ер нь олон улсын байгууллагуудын дүгнэлтээр зөвхөн төсөвт найдах нь бол буруу юм гэдэг ийм зүйл гарч байгаа. Энэ жилийн хувьд бол хэд хэдэн гол зүйл дээр танагдсан нь юу гэхээр манай нөгөө радарын системүүд байгаа. Гамшигийн үед хэрэгцээтэй маш олон зүйлүүд бол бас тоног төхөөрөмжүүд суугдаж чадаагүй.

Нөгөө талаараа ойн нөгөө хортон шавж устгал дээр бид нар мод тарих

гэж маш их мөнгө зардаг хэр нь ой эргээд шавж, хортон шавжид идэгдэж байгаа. Тэгэхээр энэ дээр бол жишээлэхэд зөвхөн Архангай аймгийг аваад үзэхэд л зөвхөн 1/3 нь л бид нар өнгөрсөн жил устгал хийж чадаж, ой модоо сэргээсэн байх жишээтэй. Тэгэхээр энд бол ер нь байгаль орчны салбарын хөрөнгө оруулалт бол асар их байх шаардлагатай байдаг. Тийм учраас энэ дээр бол энэ жил бол бас нэг нэлээдгүй танагдсан байгаа.

2 дугаарт бид нар зэрлэг амьтдаа хамгаалъя, байгалиа хамгаалъя гээд байдаг. Гэтэл байгаль хамгаалагчдаа ерөөсөө хамгаалж ирдэггүй. Нөгөө хүмүүс нь хэдэн аймаг дамжсан ямар ч унаа байхгүй, дулаахан хувцас байхгүй, олигтой байр сав байхгүй байдаг учраас би бас энэ жилийн төсөвт энэ байгаль хамгаалагчид, тэнд ажиллаж байгаа хүмүүсийнхээ бас эрх ашгийг хамгаалсан тэр асуудлуудыг нь шийдье гэж оруулж ирсэн байгаа. Тэгээд нэг үгээр тайлбарлахад манайд бол төсөв бол хэзээ ч хүрдэггүй л гэж хэлж болно. Нийт гаргасан тооцоо бол 11 тэрбум доллар шаардлагатай байдаг ийм салбар байгаа. Тэгээд биднээс хамаарахгүйгээр уур амьсгалын өөрчлөлт бол маш хурдацтай явагдаж байна. Газрын гүний усны судалгаа хийе гэхэд л жилд ядаж 10 тэрбум төгрөг байх ёстой гэхэд л энэ нь бид нар энэ жил бас тавигдаж чадахгүй байх жишээтэй. Тэгэхээр энэ салбарт бол маш их хөрөнгө оруулалт хэрэгтэй. Хэзээ ч хангалттай байдаггүй. Гэхдээ бид бол яах вэ бас энэ төсөл хөтөлбөрүүдийг босгож уулзсан. Гадаадын байгууллагуудад төсөл хөтөлбөрөө илгээж, хөрөнгө босгох ажил дээр бол энэ өнгөрсөн 2 сард бол маш идэвхтэй ажилласан байгаа. Сангийн талаар тайлбарлачих уу.

Б.Бейсен: 2 номерт Төрийн нарийн хариулъя.

Э.Баттулга: Уянга гишүүний асуултад хариулъя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн санд 3,4 тэрбум

төгрөг төсөвлөсөн байгаа. Энэ сангийн орлого бол 2 эх үүсвэртэй. Эхнийх нь бол Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу байгалийн нөөцийн тодорхой төрлүүдэд нөхөн төлбөр тооцсоны орлогоос төвлөрдөг. Ой, ус, ургамал, амьтан, нөгөөх нь бол Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу ус бохирдуулсны төлбөрийн орлогын 50 хувиас бүрдэж байгаа. Энэ сангийн зарцуулалтыг бол харьяа байгууллагуудынхаа саналыг аваад сангийн төсөв зарцуулах, төлөвлөх журмын дагуу сайдын тушаалаар баталж байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Хэд хэдэн тодруулах зүйлүүд байгаад байгаа юм. Бид хэд энэ хүнсний хангамж, аюулгүй байдлын хүрээнд олон том зорилтууд дэвшүүлсэн. Тэр дотор энэ үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс тодорхой нөөц бүрдүүлэлтийн асуудлууд яригдсан юм. Тийм учраас тэр стратегийн нөөц буюу 100 мянгаас доошгүй тонн улаан буудай нөөцлөх хөрөнгийн чинь асуудал 2025 оны чинь төсөвт суув уу. Технологийн нөөц бүрдүүлэлт чинь ер нь ямархуу байдлаар тусгагдаж оров. Нэг ийм зүйл.

2 дугаарт энэ газар тариаланг жоохон шинжлэх ухааны үндэслэлтэй, үр өгөөж тал руу нь явуулъя гэвэл бид энийг дэргэдэх хүрээлэнгүүдийнхээ үйл ажиллагааг авч үзэхээс өөр арга байхгүй. Тэр хэний харьяалалд явахаас үл хамаараад энэ төр өөрөө захиалгат ажлынхаа хөрөнгийг тавьж өгөх ёстой. Тийм учраас энэ хүрээлэнгүүдээр юу хийлгэх гээд байгаа юм гэдэг тэр захиалгат ажлын чинь төсөв гэж ер нь юу тусаж оров. Түүний сорилт, туршилт үйлдвэрлэлд нэвтрүүлэх үйл ажиллагаатай холбоотой ер нь ямар зардлууд хэрхэн, яаж оров гэдэг асуудал байгаад байна. Энэ дээр нэг тодорхой хариулт авмаар байна гэж.

2 дугаарт хэдүүлээ малаа эрүүлжжүүлбэ. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэрэглэгч буюу импортлогч тал нь эргэлзээгүй байх үүднээс эрүүлжүүлэх асуудал яригдсан. Мал эрүүлжүүлэх ажил дээр тодорхой хөрөнгүүд үе шаттай тавигдаад явсан. Энэ 2025 онд ямархуу байдлаар тавигдав. Био үйлдвэрийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудал яригдсан. Улсын төсөвт суугаагүй байж магадгүй. Ямар эх үүсвэрээр үүний шинэчлэл өргөтгөлийн ажлыг хийх гээд байна. Энэ чинь жилийн хөгжлийн төлөвлөгөөнд нэр усаараа заагдаад орчихсон шүү дээ. Тэгэхээр энэ ямар юм хийгдэх гээд байна гэдэг нэг ийм асуудлыг тодорхой хариулт авмаар байна гэж.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд бас нэг хэдэн асуудлууд байгаад байгаа юм. Бид энэ усны хайгуул судалгааны ажлыг ер нь ямархуу байдлаар хийх юм бэ. Ер нь энэ улсын чинь нийт нутаг дэвсгэрийн хэдэн хувьд нь энэ хайгуул судалгааны ажил нь хийгдчихсэн тайлан архив нь та бүгд дээр байдаг юм. Энэ ажил явахгүй байгааатай холбогдуулаад иргэд гэдэг юм уу хуулийн этгээдүүд ер нь үндсэндээ таамаг байдлын өрөмдлөг хийгээд нэлээн эрсдэл хүлээгээд байгаа ийм зүйлүүд гарч ирээд болохгүй байгаа. Үүнийг та хэд юу гэж харж, энэ чиглэлийн ажлын төсөв төсөл юунд тусав гэж.

Говийн бүсийг усжуулах тухай 2 том төсөл 2 талаасаа яригдаад байгаа. Аль нэгийг нь сонгож хэрэгжүүлнэ гээд байгаа. Улсын төсөвт суугаагүй байж магадгүй. Гэхдээ ямар эх үүсвэрээр тэр Хэрлэн-Тооныг гэдэг юм уу, Орхон-Онгийг гэдэг юм уу, Говь руу чиглүүлэх ажлыг эхлүүлэх гээд байна. Энэ өөрөө.../минут дуусав/

Б.Бейсен: Батжаргал гишүүнд 1 минут нэмж өгье.

Ж.Батжаргал: Энэ 4 жилийн Мега 14 төслийн чинь 1. Энэ дээр ямар чиглэл

юмнууд байна вэ гэдэг нэг ийм зүйл байна. Байгаль орчныг хамгаалах юм ярихаар дэндүү өргөн юм яригдах гээд байгаа юм. Тэгээд одоо бол бид нар дандаа зохион байгуулалт гэдэг юм уу нөхцөл байдлаа тодорхойлсон материал дээрээ тулгуурлаж л юм яриад байгаа л даа. Нийт хортон шавжид тархсан ойн талбайнхаа хэдэн хувьд ирэх жил бид нар хамгааллын арга хэмжээ авч хэрэгжүүлэх гээд байна. Тавигдсан төсөв хөрөнгө юу байна. Энэ байгаль хамгааллын чиглэлээр тодорхой хөрөнгө нэмэгдүүлэх бололцоо байна уу гэж хараад байдаг юм. Та хэд ямархуу судалгаатай байгаад байгаа юм. Энэ хүлэмжийн хий ялгаруулаад байгаа томоохон үйлдвэр гэдэг юм уу аж ахуйн байгууллагууд, гадаад улс орнуудын энэ чинь дүйцүүлэн хамгаалалтын чиглэлээр бас бусад улс орнууд руу тодорхой хөрөнгө чиглүүлээд, тодорхой төсөл арга хэмжээнүүд хэрэгжүүлээд байна. Үүнийг бид нар ямархуу байдлаар татаж ашиглах ийм яриа хэлцэл байна уу.

Б.Бейсен: Эхлээд Энхбаяр сайд, дараа Одонтуяа сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Био комбинатаас эхэлье. 1972 оноос хойш Био комбинатад ямар нэгэн бодитой хөрөнгө оруулалтууд олигтой ороогүй байгаа. Хуучин технологи дээр суурилж байгаа гэсэн хэдий ч бас тодорхой нэр төрлийн вакцин үйлдвэрлээд, улс орныхоо тодорхой хэмжээг хангаад явж байна. Яам 2 ийм шугамыг ашиглалтад оруулаад, энэ 10 сард үндсэндээ ингээд хэрэгжээд дуусаж байна. Автомат вакцины савлагаа, эсийн үүсгүүрийн шугамыг ашиглалтад оруулсан. Ер нь “Цагаан алт” гээд хөтөлбөрийн хүрээнд бид нар энэ үйлдвэрлэлийн боловсруулсан түвшнийг сайжруулахын зэрэгцээ бас биокамбинат буюу тэр малын түүхий эдийнхээ чанарыг сайжруулахын тулд мал эмнэлгийн асуудал, энэ дотроо тэр вакцины асуудал онцгой чухал, салгаж болохгүй нэг ойлголт. Тэгэхээр “Цагаан алт” хөтөлбөртөө сайхан суулгаад

ингээд явчихсан. Тэгээд бид олон улсын хөтөлбөрт хамруулахаар хөөцөлдөж, төсөл төлөвлөгөөг нь бэлдээд ингээд явж байна.

Мал эрүүлжүүлэх асуудал ерөөсөө хөдөө аж ахуйн үйлдвэрийн гол суурь нь мал эмнэлэг, мал эрүүл байх асуудал. Нийтдээ нэг вакцин болон мал эмчилгээний үйлчилгээний төлбөр гээд нийтдээ 41 тэрбум төгрөг төсөв сууж байгаа. Энэ бол мэдээж Монгол Улсын 70 сая малыг бүрэн эрүүлжүүлэхэд хүрэлцээгүй байгаа. Иймд Мал эмнэлгийн ерөнхий газар стратеги тактикаа боловсруулаад гол эрсдэлтэй гол голомттой бүс нутгаа хүрээг хумих маягаар ингэж сонголттойгоор ингэж вакцинжуулалтыг хэрэгжүүлж байгаа. Нэг салбарт нэг онцлог дэвшил гарсан зүйл бол мал эмнэлгийн үйлчилгээ хувийн хэвшилд бүрэн шилжсэн байгаа. Бүх сумын мал эмнэлэг хувийн байгаа. Нөгөө талаас хүнсний аюулгүй байдлын нөөц бүрдүүлэх нь онцгой чухал. Хүнсний аюулгүй байдал үндэсний хөтөлбөрт жил бүр 100 мянган тонн улаан буудайн нөөц заавал бүрдүүлнэ гэж туссан боловч 20 мянган тонн, 20-25 мянган тонноос илүүг бүрдүүлэх бололцоог төсвийн хувьд хязгаарлагдаж байгаа. 2025 онд бид нар 25 мянга хүртэлх улаан буудай нөөцлөх ийм төсөв батлагдсан байгаа. Нийтдээ 25 тэрбум төгрөг батлагдсан гэсэн үг.

Захиалгат ажил, төсөв, хүрээлэн гэж байна. Нэг энэ салбарт бодитой бий болсон нэг айхтар гажуудал байгаа юм. Хөдөө аж ахуй, мал эмнэлгийн, газар тариалангийн буюу яг салбарын дэргэд байх ёстой хүрээлэнгүүд бүгд салбараас гараад явчихсан. Боловсролын яамны харьяанд байдаг. Сая Боловсролын яамнаасаа гараад бүр Хөгжлийн яамны харьяанд оччихсон. Боловсон хүчин, мэргэжилтэй боловсон хүчин яамны захиалгаар бэлдэх ёстой Хөдөө Аж Ахуйн Их Сургууль нь Боловсролын яамны харьяа. Цагтаа 15 мянган оюутан бэлдэж байсан бол ХААИС одоо 3 мянга

гаруй мэргэжилтэн дөнгөж бэлдэж байна. Салбар өөрөө боловсон хүчний маш гүнзгий дутагдалд орж эхэлж байгаа. Насжилт өндөр байгаа. Тэгэхээр энэ гажуудлын засахад мэргэжлийн Байнгын хороо бас анхаарал тавьж өгөөсэй гэж хүсэж байна.

Бодлого, хүний нөөц, үйлдвэрлэл энэ салбар цогц байж байж үр дүн гарна. Ямар санаа зорилготой хийсэн юм бүү мэд. Бүгдийг нь задалсан. Тус тусад нь салгасан. Шинжлэх ухаан нь бодлоготойгоо нийлцдэггүй. Хүний нөөцийн бодлого нь салбарын бодлоготойгоо нийцдэггүй, үйлдвэрлэлээсээ салчихсан. Үндсэндээ хувийн хэвшлийн нуруун дээр л энэ бүх ажил явж байна. Судалгаа, шинжилгээ, туршишлтууд. Нэгэнт өөрөө хөдөө аж ахуйн салбарын хүрээлэн гэдэг хүрээ дотор суурь шинжлэх ухааны байгууллагаасаа арай өөр түвшинд гарчихдаг. Тэгээд төсөв санхүүжилт нь бас хязгаарлагдмал. Байгаа хөдөө аж ахуйн хүрээлэнгийн тоног төхөөрөмж, лабораториуд маш хоцрогдсон ийм л байдалтай болчихоод байгаа юм. Болдог бол ингээд нэгтгээд энэ яамных нь доор өгөөд, хүний нөөцтэй нь, шинжлэх ухаантай нь өгвөл бодлого үйл ажиллагаа нь цогц болох л юм болов уу. Нэгэнт ийм том улсын хэмжээний 4 том хөтөлбөр гаргаад ингээд хөдлөөд эхэллээ. Ингээд шинжлэх ухаанаар хүний нөөцөөрөө.../минут дуусав/

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудлын 3 дугаарт манай байгаль орчны салбарт хийгдэхээр төлөвлөгдөж байгаа ажлуудын талаар маш дэлгэрэнгүй мэдээлэл өгөх юм байгаа юм гишүүдэд. Тэгэхээр тэр дээр бас би нэлээд мэдээлэл өгье. Одоо бол яг төсөвтэй холбоотой сая Батжаргал гишүүний асуултад хариулъя.

Ойжуулалт дээр бол манайх энэ жил бас нэлээдгүй хөрөнгө гайгүй тавиулж чадсан байгаа. Яагаад бид нар ой дээр их анхаараад байна гэхээр нөгөө хүлэмжийн хийг бууруулах олон улсын амлалтад Net Zero буюу тэглэнэ гэсэн ийм амлалтууд бүх улс орнууд авсан. Тэглэнэ гэдэг нь огт хүлэмжийн хий ялгаруулахгүй гэсэн үг биш. Бид нар эсрэг талд нь шингээлтийг хийдэг энэ зүйлүүдийг олноор бий болгох ёстой. Тэгэхээр ойжуулалт мод тарилт нь өөрөө энэ хүлэмжийн хийн шингээлтийг маш сайн шингээж өгдөг учраас энэ дээр бас нэлээд анхаараад ингээд явж байгаа юм.

Энэ жил бол ой хөнөөлт.../минут дуусав/

Б.Бейсен: Одонтуяа сайд гүйцээж хариулъя.

С.Одонтуяа: Товчхон хариулчихъя. Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт дээр мод үржүүлгийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлэх, ойн хөнөөлт шавжийн тархалтын судалгаа тэмцлийн ажил хийх гээд тэмцлийн ажилд бол 10 тэрбум төгрөг тавьсан байгаа. Түймрээс урьдчилан сэргийлэх хамгаалах ажил дээр бас 1 тэрбум төгрөг, ой төлөв байдлыг сайжруулах арчилгаа цэвэрлэгээ дээр 2,3 ингээд тавигдсан байж байгаа.

Усны асуудал дээр бол би нөгөө 3 дахь асуудал дээр дэлгэрэнгүй мэдээлэл өгье. Энэ өөрөө бас нөгөө зөвхөн байгаль хамгаалах биш нөгөө манай бүр том дэд бүтцийн ажил учраас өчигдөр Засгийн газар дээр бид нар ажлын хэсэг байгуулсан байгаа. Энэ ажлын хэсэг дээр энэ Орхон-Онги, Хэрлэн-Тоонот гэсэн энэ 2 төслийг яаралтай эхлүүлэх, үүний тооцоо судалгааг нарийвчлах ажлууд хийгдээд явна. Гол нь бол Хэрлэн-Тоонын хийх ТЭЗҮ-г бол Оюутолгой компани санхүүжүүлээд, 3 сая доллароор одоо хийгдээд эхэлж байна. Энэ нь 2025 ондоо дуусах байх.../минут дуусав/

Б.Бейсен: Мандухай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Хөдөө аж ахуйн яамныхнаас асууя гэж бодож байна. Хөдөө аж ахуйн биржийн тухай хууль батлагдсан. Тэгээд Хөдөө аж ахуйн биржийг арилжаанд хоршоодыг оролцуулах ажил бол хангалтгүй явж ирсэн. Өнөөдрийг хүртэл Хөдөө аж ахуйн биржийн тодорхой хэмжээний эко систем бүрдээгүй. Гэтэл яг энэ төсөвт тусгагдсан суурь түвшинээр бол нийтдээ 26 мянган хоршоодын тоог нэмэгдүүлнэ гээд заачихсан байгаа. Гэхдээ энэ дээр холбоотой би дахиад тодруулга угаасаа авна. Тэгээд энэ Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт зааснаар бол хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийн мөшгөлт чанарын хяналтыг сайжруулж, биржээр дамжуулан экспортолно гээд ерөнхийдөө Хөдөө аж ахуйн биржийг бол бид нар цар хүрээг тэлэхгүй бол үндэсний энэ том хөдөлгөөнүүд Цагаан алт, Шинэ хоршоо, Хүнсний хувьсгал ч гэсэн ер нь хамгийн энэ эко систем өөрөө ил тод, зөв хяналтын тогтолцоотой явах арилжаалагдах платформ нь өөрөө Хөдөө аж ахуйн бирж гэж харж байгаа. Тэгэхээр цаашид Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг Шинэ хоршоо хөдөлгөөн, Цагаан алт хөтөлбөр, Цахим хөдөө аж ахуй и-баримтад суурилсан түүхий эдэд олгох урамшууллын бодлого зэрэг бодлогуудтай уялдуулах уу. Ер нь бол уялдуулах шаардлагатай байна гэж харж байна. Энэ дээр ямар төсөв би бол улсын төсвөөс яг энэ Хөдөө аж ахуйн биржийг цар хүрээг нь тэлэх, сайжруулахтай холбоотой нэг ч төсөв харсангүй. Энэ дээр хариулт авъя.

2-т нь болохоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны төсвийн санал дээр нийт төсвийн тодотголоос 188,7 тэрбум төгрөгөөр буюу 26,4 хувиар, 2023 оны гүйцэтгэлтэй харьцуулбал 541 тэрбум төгрөгөөр буюу 150 хувиар нэмэгдсэн байгаа. Тэгээд энэ зардал бол өсөх болсон шалтгааныг

харах юм бол урсгал зардал болон улсын төсвөөс хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас нэмэгдсэн байгаа. Хувийн хэвшлийн байгууллагад олгож байгаа 2023 онд 117,2 тэрбум, 2024 онд 337,4 тэрбум, 2025 оны төсөлд 554 буюу хагас их наяд төгрөгийн төсөв тавигдсан байна. Тэгээд энэ улсын төсвөөс олгож байгаа татаас жил бүр ингэж өсөн нэмэгдэж байгаа нь яг үнэнээ хэлэхэд бол байгаа олсон татаас болж чадаж байгаа юу. Иргэн, аж ахуйн нэгжийг бүрэн хамарч чадаж байна уу гэдэг дээр асуумаар байна. Тэгээд энэ өөрөө гол нь ингэж татаас олгосноороо эргээд хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн бодит, яг ямар бодитой өсөлт нэмэгдэх юм бэ. Энийг бол хавсралтад заасан тэр төсвийг үр ашигтай захиран зарцуулах зарчмын дагуу хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийг бол бодитой тооцож чадсан уу. Энэ дээр бас бас хариулт авмаар байна.

Тухайлбал, хоршоо эрхлэгчдийн тоог суурь тоо нь 25 мянга байгааг 26 мянга гээд түрүүн би дурдсан. Энэ дээр болохоор хөдөө аж ахуйн салбарт.../минут дуусав/

Б.Бейсен: Мандхай гишүүнд 1 минут өгье.

М.Мандхай: Энэ тоо болохоор алдаатай тоо байсан гэсэн. Энэ тоог засаж орж ирсэн үү. Энийг ингээд засуулахгүйгээр батлагдаад явчих юм биш биз дээ гэдэг дээр бас хариулт авмаар байна.

Урсгал зардал дотор анхаарал татах 3 бас ангилал байна. 1 дүгээр бүс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 98,7 тэрбум, бараа, үйлчилгээний бусад зардал 7,7, энэ норматив зардал гээд нэг тоо яваад байгаа 28,6 тэрбум. Энэ дээр бас ингээд яг энэ бодитой тоо яг нэмэгдсэн шалтгаан нь юу юм бэ. Норматив зардлын задаргааг энэ номоос ерөөсөө харах боломжгүй байгаа юм

байна. Монгол Улсын стандартын дагуу хэдэн хүнд ямар хоргүйжүүлэлт, зориулсан хувцас энэ тэр гээд норматив зардал гаргах тэр зардал олгож байгаа талаар бас бодитой тоо авмаар байна.

3 дугаарт болохоор арьс ширний татаас 10 тэрбум төгрөг тусдаа “Цагаан алт”-аас гадна тавьчихсан байна лээ. Энийг яагаад нэгтгэж болоогүй ингэж 2 өөр урамшууллын тус.../минут дуусав/

Б.Бейсен: Асуусан асуултад зөвхөн сайд биш, Төрийн нарийн, холбогдох газар, албадын дарга нар тодорхой хариулаарай. Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ арьс шир, нэхий татаас өмнө уламжлалаар нэлээн 10-аад жил явж байсан. Тэгээд тэр хүрээндээ л зүйл нь дуусахдаа ингээд явчихсан. Ямар нэгэн давхардсан зүйл байхгүй. Нэг ийм өөрчлөлт байгаа. Улс Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт төрийн оролцоог бүх хүрээнд хязгаарлаж байгаа. 100 хувь хувийн хэвшилээ л дэмжинэ. Энэ байгаа бүх мөнгө хувийн хэвшилд очно. Энэ ковидын нөхцөл байдлыг та бүхэн эргэж санаарай. Ковидыг бид 1 сар хугацаа ахиад алдахад Монгол Улс картын бараанд орох байсан. Хүнсний аюулгүй байдал тийм эмзэг, сул байсан. Хүнс дотоод үйлдвэрлэл байхгүй. 100 хувь импортод дулдуйдчихсан. Хэт бол уурхай дээрээ тулгуурлаад бид энэ тарьдаг, ургуулдаг, үйлдвэрлэдэг зүйлээ их орхигдуулсан. Энэ бол үнэхээр ноцтой байдлыг үүсгэх нь тодорхой болсон. Ингээд аюулгүйн зөвлөлөөр асуудал танилцуулагдсан. Улмаар энэ Хүнсний хувьсгал, Цагаан алт энэ хөтөлбөрүүд гарч байгаа учир шалтгаан нь энэ. Иймд энэ уул уурхайн таатай мөчлөгийг ашиглаад, энэ богино хугацаанд хувийн хэвшилдээ бүх талын дэмжлэгийг өргөн хүрээнд өгч байгаа. Мал аж ахуй, газар тариалан. Мал аж ахуй, газар тариалан 2-оос чинь л энэ хөнгөн үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэл чинь гол түүхий эдээ авч үйлдвэрлэл явуулж байгаа. Ингээд

цогцоор нь анх удаа нэгтгэсэн энэ цогц 4 бодлого гээд нийлээд явж байгаа зүйл.

Хөдөө аж ахуйн бирж бол онцгой чухал үүрэг гүйцэтгэнэ. Яагаад малчдаа хоршоолоод байна гэдэг чинь бид тэр Хөдөө аж ахуйн биржийн анхан шатны оролцогч нарыг бид нар малчдаа, хоршоолсон ногоочдоо, гэж үзэж байгаа. Хоршоолсон тэр фермчдийг үзэж байгаа. Тэнд үйлдвэрлэж байгаа түүхий эд, тэнд бэлтгэгдэж байгаа хөдөө аж ахуйн гаралтай тэр бүх түүхий эдийн мэдээлэл биржээр дамжаад, үйлдвэрлэлтэй холбох ажил. Та бүхэн санаж байгаа бол 1990-ээд он, 2000 оны эхээр бид түүхий ноолуураа хил ачаад л хилийн боомтоор л янз бүрийн түвшинд явдаг байсан. Өнөөдөр Хөдөө аж ахуйн бирж ноолуурын экспортыг 100 хувь бүрэн хяналттайгаар албан ёсны, баталгаа сертификаттайгаар экспортлох ийм түвшинд хүрчихсэн. Сая бид нар энэ үр тарианы арилжааг амжилттай хийлээ. Ургацаа хураалаа, баланс гаргалаа, үр тарианы арилжаа хийгдлээ, тэжээлийн үйлдвэрүүд, сүүний фермүүд, компаниуд үрээ авна, гурилын үйлдвэрүүд гурилаа авна. Ингээд арилжаалдаг зах зээл илүүдэл дутагдлаа тодорхойлдог. Ингээд бодлого нь хурдан бөгөөд түргэн явъя гэж. Цаашидаа бид ойрын үед тосны ургамал гэж томоохон ургамал экспортын бүтээгдэхүүн хөдөө аж ахуйн салбарт бий болсон байгаа. Тосны ургамлын экспортыг бид бас цэгцлэх, бүгдийг нь Хөдөө аж ахуйн биржээрээ дамжуулах, баталгаажуулах ийм зүйл хийж байж Монгол Улсын хөдөө аж ахуй өөрөө экспортын бас том боломж байна. Тэгэхээр энийг хийхийн тулд бид бүгд тэр ургамал хамгааллын, мал эмнэлгийн, олон улсын гэрээ эрх зүйг дагаж мөрддөг гэрээ сертификаттай олгодог ийм системээр явахад Хөдөө аж ахуйн бирж чухал үүрэг гүйцэтгэнэ. .../минут дуусав//

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Мэдээж хөдөө аж ахуйн төсвийн би та бүхэнд хэлсэн. Надад 5,9 тэрбум төгрөгийн л шинэ хөрөнгө оруулалт байгаа. 40-өөд тэрбум төгрөгийн өмнө байшин барилгын үргэлжилж байгаа төсөв байгаа. Тэгэхээр шинээр 5,9 тэрбум дотор хөдөө аж ахуйн шинэчлэлийн арга хэмжээ байхгүй. Бид мөн адилхан олон улсын байгууллагууд, хандивлагч байгууллагуудтай дэлхийн хүнсний байгууллагатай хамтраад энэ Цахим хөдөө аж ахуй гэсэн нэгдсэн том платформыг овоо хөгжүүлээд гарч байна. Цагаан сар гэхэд би гишүүддээ танилцуулж чадах байх гэж бодож байна. Малчны хотонд үйлдвэрлэж байгаа ноос, мах, сүү үйлдвэрлэлд нийлүүлж байгаа энэ бүх системд бүх оролцогч нарын тоо мэдээлэл ил тод, энэ мэдээлэл нээлттэй байна. Дундговь аймгийн Хулд сум Наран гэдэг хоршоо 100 хонь зарна гэдэг мэдээ ороход тэр нь минутын дотор л мэдээлэл дээр гардаг, тэнд үйлдвэрлэлүүд захиалгаа өгдөг.../минут дуусав

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя. Хэн нь хариулах юм. Өөр холбогдох төсвийн нэмэгдлээр хариулт авч чадаагүй гэж байна шүү дээ. Сангийн сайд хариулах юм уу.

Б.Жавхлан: Би зарим зүйлийг нь хариулъя. Гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Тэр урамшууллын давхцал гэж байгаа чинь эдийн засгийн ангиллаараа 2 өөр зүйл юм байгаа юм шүү. Тэр бүтээгдэхүүний урамшуулал, зээлийн хүүгийн урамшуулал 2 бол шал өөр. Бүтээгдэхүүн нь бол 5 төрлийн бүтээгдэхүүн дээр урамшуулал өгч байгаа. Ноос, арьс шир, хүнсний ногоо, сүү, улаан буудай гээд. Сүүлийн жилүүдэд энэ хүнсний бүтээгдэхүүний урамшуулал бол байгаа оносон маш сайн үр дүнтэй. Ер нь сүүлийн энэ олон жилүүдэд хөдөөгөөс Хүнс, хөдөө аж ахуй яамнаас хэрэгжүүлж байгаа олон үндэсний хөтөлбөрүүдээс ер нь яг газар дээрээ хамгийн оновчтой, хамгийн сайн

үр дүнгээ өгч байгаа хөтөлбөр бол энэ. Энэ 4 төрлийн бүтээгдэхүүн дээр өгснөөр үндсэндээ Хүнс, хөдөө аж ахуйн яам.../минут дуусав/

Б.Бейсен: Сангийн сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Стратегийн гэж үзсэн. Өөрөөр хэлбэл бид дотооддоо энийгээ үйлдвэрлэж, дотооддоо өөрсдөө хангах ёстой гэж ийм зорилго тавиад, ингээд энэ 5 бүтээгдэхүүнээс үндсэндээ улаан буудайнаас бусад нь сүүлийн 3-4 жилийн дотор дор хаяж 2 дахин нэмэгдсэн дотооддоо нийлүүлэлт нь. Тэгэхээр энэ бол маш сайн үр дүнгээ өгч байгаа ийм урамшуулал. Бусад нь зээлийн хүүгийн урамшуулал нь бол тусдаа шүү. Зээлийн хүүгийн урамшуулал бол тусдаа. Энхбаяр сайд бас нийт хэдэн төгрөгийн зээлийн багц гарсан, тэр нь хэдэн аж ахуйн нэгжид очсон талаар бас мэдээлэл өгчих болов уу гэж бодож байна. Тэгээд ер нь Хүнс, хөдөө аж ахуйн урсгал зардал гэхээр энэ яамны ажилчдын урсгал зардал гэж ойлгож болохгүй шүү. Энэ бол тус яамнаас үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байгаа 4 томоохон хөтөлбөрийн хүрээнд тэр нь илүү их далайцтай, хүртээмжтэй байдлаар өргөжиж тэлж, үр дүнгээ өгч байгаа ийм төслүүдийн санхүүжилт гэсэн үг. Тэр нь эдийн засгийн ангиллаараа сайдын урсгал зардал дотор ингэж шингэдэг байгаа.

Б.Бейсен: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Би гол нь тодорхой асуусан юм л даа. Норматив зардал, яг энэ бусдаар гүйцэтгүүлэх гэж байгаа зардал угаасаа нэмэгдээд бүх яамны төсөв дээр бол нэмэгдээд явсан байгаа. Тэгээд үүний задаргааг нь харж чадахгүй учраас тодруулж асууж байгаа нь тэр юм. Нэлээн өндөр хувийг эзэлж байгаа тоонууд учраас анхаарал татаж асууж байгаа шүү.

2 дугаарт энэ Цагаан алт хөтөлбөр гэж нэлээн том үндэсний хэмжээнд тууштай явах гэж байгаа хөдөлгөөн дээр нөгөө урамшууллыг тус тусад нь ангилал үзүүлээд явснаас ер нь ингээд арьс ширний урамшууллыгаа ер нь Цагаан алт хөтөлбөр дотроо ингээд зарим нэгэн багцыг нэгтгээд явах боломж байгаа юу. Нэгтгээд явах юм бол илүү үр дүнтэй, уялдаатай байх болов уу гэсэн санаа байна. Тэрнээс биш энэ татаасыг бол урамшууллыг бол дэмжиж байгаа. Хувийн хэвшлийн зүгээс ч гэсэн хувийн хэвшлийн татаасыг бол бас зөв гэдэгт итгээж байна. Гэхдээ эргээд гол нь энэ чинь өгөөж, үр дүнгээ яаж тооцож байгаа юм. Дотоодын нийт бүтээгдэхүүнд.../минут дуусав/

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Их Хурлын тогтоол нь 2 тусдаа эрх зүйн баримтаар зохицуулалтууд хийгдээд байгаа байхгүй юу даа. Эхнийх нь арьс ширний ийм урамшуулал гээд нэг тогтоол гарчихсан. Дараа нь цагаан алт гээд гарчихсан. Давхцуулаагүй юм. Ер нь агуулга бол нэг. Нийт Цагаан алт гэхэд л жишээлбэл ноосонд 25,4 тэрбум байгаа юм. Энэ тэмээний ноос, сарлагийн хөөвөр, хонины ноос. Арьс ширэнд 10 тэрбум байгаа. Ингээд энэ маань өөрөө нийт 77 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлнэ. Дотроо энэ нь өөрөө 1,5 их наядын зээлийг өдөөж байгаа байхгүй юу. Ахиад хэлье. 1 төгрөгөөр л 10-ыг өдөөж байна гэсэн үг. Үр дүн нэхээд байна. 2022-2023 оны үр дүн. Салбарын экспорт 1 их наядаар нэмэгдсэн. Импорт 260 тэрбумаар багассан буюу бид нар 260 тэрбумаар валютаар авдаг юм багасаад Монгол Улс 1 их наядын экспортын бүтээгдэхүүн хөдөө аж ахуйн салбараас гарч ирж байна гэсэн үг. Энэ тоо улам өсөж байна.../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр гишүүн гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Тэгэхээр энэ бодлого маань цогц. Үйлдвэрт тушаасан шингэн сүү болгон, гурилын үйлдвэрт тушаасан улаан буудай болгонд, үйлдвэрт тушаасан ноос, арьс шир болгонд л энэ үйлчилнэ. Тэрнээс хувийн болон бусад зохицуулалтаар хэрэглэсэн зүйлд очихгүй байгаа юм. Энэ маань өөрөө үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд л яваад байгаа байхгүй юу даа. Үүний үр дүнд хөнгөн үйлдвэрүүдээ босгоё. Хүнсний үйлдвэрүүдээ босгоё. Өгөөж өндөр гарч байна шүү. Нийтээрээ хөдөлчихсөн байна. Хэзээ ч өмнө нь ийм том цогц үндэсний хэмжээний бүтэн хөдөө аж ахуйн салбарыг хамарсан бодлого яваагүй. Малчдаасаа авхуулаад тариачин, ногоочид, үйлдвэрлэгчид, жимс, хүлэмжийнхэн, ерөөсөө сүүнийх нь гээд тэр чигээрээ ноос ноолуур, арьс ширнийх нь гээд бүгдээрээ хөдөлгөөнд орчихлоо. Бүгд идэвхэжчихлээ. Тэгээд гадаад нөхцөлөө хараарай. Амаргүй ийм цаг үед бид маш хурдтай л ажиллаад л амжих хэрэгтэй байна. Юм яагаа ч билээ. Амжаад дотоод үйлдвэрлэлээ нэг босгоод авъя. Тэгээд хүнснийхээ хэрэглээний тодорхой түвшин дотроо хангаад авъя. Нэг ийм л.../минут дуусав/

Б.Бейсен: Идэрбат гишүүн асуулт асууя. Жавхлан сайд хариулах юм байна. Тодруулга.

Б.Жавхлан: Мандхай гишүүний асуултад нэмж хариулъя. Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ гэдэг маань ер нь бол ангилал нь ийм. Одоо тухайн яамны төрийн албан хаагч нар заавал гүйцэтгээд байх шаардлага байхгүй ийм үйлчилгээ, бүтээгдэхүүнийг авч байгаа тэр зардлыг л оруулж явдаг юм байгаа юм шүү. Жишээ нь Хүнс, хөдөө аж ахуйн сайдын энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал 2024 онд 92 тэрбум 358 сая, 2025 онд 98 тэрбум 767 сая буюу зөрүү нь 6,4 гэхээр 9 тэрбум 7 хувь орчмоор нэмэгдсэн байна. Нэмэгдсэн гол том зардлууд нь гэх юм бол малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины үйлчилгээ.

Энийг бол бусдаар гүйцэтгүүлдэг. Мэдээлэл сурталчилгааны зардал гэж байна. Энэ 2 тэрбум байна. Өөр нүүлгэн шилжүүлэх зардал 1,4 тэрбум. Энэ нөгөө яам Дархан хот руу энэ шилжиж байгаа ийм зардлууд байна. Ингээд л яг 6,4 маань ийм л зардлуудаар нэмэгдсэн байна.

Б.Бейсен: Яамдын холбогдох яамдын мэргэжилтнүүд энэ асуусан асуултад тодорхой хариул даа. Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Өглөөний мэнд хүргэе. 2, 3 асуулт байгаа юм.

1 дүгээрт 2024 оны 8 сард Төсвийн тодотгол хийх үед би бас асууж байсан. Био комбинатын асуудал дээр би бол сая бас тийм гүйцэд хариулсангүй гэж бодож байна. Үе үеийн сайд нараас л асууж байгаа. Мэндсайхан сайд, Болорчулуун сайд, одоо Энхбаяр танаас асууж байгаа юм. Тэгээд Био комбинат дээр олигтойхон шиг эсвэл энэ 14 мега төсөлдөө оруулж болоогүй юм уу гэдэг асуултыг асуухад 2025 оны төсөв дээр бид Био комбинат дээр нэлээн том өөрчлөлт хийнэ гэж ийм хариултыг 2, 3 сарын өмнө хэлж байсан. Өнөөдөр яг энэ Био комбинат Монгол Улсын мал аж ахуйн салбар энэ тарилга юман дээрээ тийм онцгой өөрчлөлт оруулах ямар том төсөл хөтөлбөр бодож байгаа юм бэ. Та бол сая гаднын юм ярьж л байна. Тэгээд тэр дээрээ бас тодорхой хариулаарай гэж би хүсэх гээд байгаа юм.

Аль л Унгарын Засгийн газраас авхуулаад л ингээд л яригдаад л байдаг, яригдаад л байдаг. Тэгээд өнөөдөр энэ үүсээд байгаа нөхцөл байдал, энэ олон зүйлүүд чинь дотооддоо үйлдвэрлэж чаддаггүй вакцин энээ тэрээ гээд олон юмнаас шалтгаалаад байгаа шүү дээ. Тэгэхээр би 8 сард та хариулж байсан. 2025 онд заавал 14 мега төсөлд оруулах шаардлагагүйгээр бид зохицуулна гэсэн. Тэр дээрээ та нэг тодорхой хариулт өгөөч ээ гэж 1 дүгээрт.

2 дугаарт энэ мал эмнэлгийн лабораторийн хүчин чадал юмнууд чинь ер нь ямар байгаа юм бэ. Би тодорхой жишээ ярья. 2018 онд намайг сумын дарга байхад оготонд өгсөн будаанаас ямаа хордсон уу, үгүй юу гэдэг шинжилгээг гаргах гэж 2 сар болж байсан. Сумын даргыг бол тамлаж дуусдаг юм байна лээ шүү дээ. Өнөөдөр үүсээд байгаа нөхцөл байдлыг чинь харахад тэр үеэсээ ер нь дээрдсэн юм байгаа юм уу. Тэгээд энэ дээр салбарын яам энэ лабораторийн хүчин чадал юмнууд дээрээ ямархуу өөрчлөлт оруулах гээд байгаа юм. Тэгээд би яагаад энэ 2-ыг асуугаад байна гэвэл өнөөдрийн манай мах хямдхан байгаагийн, арьс ширийг ч авахгүй байгаагийн гол шалтгаан энэ малын өвчин юм биш үү. Дэлхийн мал эмнэлгийн ариун цэврийн байгууллагаар өвчтэй гээд л гарчихвал тэгээд гадаад зах зээл рүү үнэ нь бага. Одоо Дэнжийн мянгад ч өгсөн адилхан, дэлхий рүү ч гаргасан адилхан үнээр өгөөд байгаагийн шалтгаан чинь энэ шүү дээ. Тэгээд яг энэ рүүгээ яг дорвитой арга хэмжээ юу төлөвлөж байгаа юм бэ гэж би 2 асуулт маань ийшээ чиглэж байгаа юм.

3 дахь нь үйлдвэрлэлийн асуудлууд ярьж байгаа. Өнгөрсөн хаваржин л ярьсан. Энэ ноолуурын үйлдвэрлэл. Угаадаг болсон одоо самнана. Самнахаа болилоо. Ирэх намраас, хавраар самнана. Тэгээд саяхан бол танай яамны газрын дарга бол самнадаг болгоод гаргана гэдэг ийм зүйлийг бас ярьж байна лээ. Тэгэхээр энэ дээр яг яамны бодлого бас ямар байгаа юм бэ. Энэ олон аж ахуйн нэгжүүд чинь энэ гаальд тэр үйлдвэр Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд бас хамрагдаад үйлдвэрүүдээ байгуулчихсан юм байна лээ шүү дээ. Эд нар дээр би тодорхой хариулт авъя.

Дараагийн 4 дэх асуулт бол манай энэ арьс ширний үйлдвэрлэлийг бид хөгжүүлнэ гэж байгаа. Ер нь ирээдүйг нь яаж төлөвлөж байгаа юм бэ. Дэлхийн зах зээл дээр одоо яг бидний 2000 оны эхээр гаргадаг шиг манай арьс ширийг тэгээд аваад байна уу. Эсвэл бид илүү

гүн боловсруулалтын түвшинд юм хийж байж.../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Баярлалаа. Идэрбат гишүүн ээ, та их зөв юм хөндөж байна. Үнэхээр Био комбинатын чадавх сайн байж байж л Монголын мал аж ахуй эрүүл, экспортын өрсөлдөх чадвартай байна. Төсөв, тооцоо, ТЭЗҮ хийгдсэн. 40 сая орчим доллараар Био комбинат иж бүрэн шинэчлэх ийм тооцоо бэлэн. Одоо бид нар санхүүжилт, эх үүсвэрийг л хайж байна. Улсын төсвөөр энийг хийхэд боломжгүй гэсэн. Тэгэхээр бид нар олон улсын зээл тусламжид хамруулагдахаар 2, 3 чиглэлээр ажиллаж байгаа. Тодорхой хэмжээний гэрээ хэлэлцүүлэг хийгдсэн. Ойлгоцол их дөхөж байна. Одоо манай Био комбинат маань 20 гаруй төрлийн вакцин тарилгыг үйлдвэрлэдэг юм. 19 нэр төрлийн эм, урвалж бодисыг үйлдвэрлэж нийлүүлж байгаа юм. Бид нэг олон улсын гоц халдварт өвчин юу гэдэг юм шүлхий их том гол эрсдэлтэй байдаг. Үүний вакцин мэтийн хэдэн төрлийн бүтээгдэхүүнийг иж бүрэн үйлдвэрлэх зорилго тавиад байгаа байхгүй юу. Тэгэхээр зайлшгүй технологио шинэчлэх хэрэгтэй. Яах вэ зүгээр байгаагүй. Сая 2 шинэ шугам ашиглалтад оруулаад, одоо хүлээж авч байна.

Ноолуур дээр ахиад хэлье. Өмнө нь Эдийн засаг, хөгжлийн яам мэргэжлийн яамны саналын урдуур ороод нэг ийм шийдвэр гаргаад, самнасан угаасан ноолуур дээр нь шийдвэр гаргаад хойшлуулсан байсан. Энийг хэлье. Одоо Монгол улс ноолуураа 100 хувь угааж чадаж байна. Мөн 100 хувь самнах хүчин чадал бүрэн суурилсан. Угаагаагүй, самнаагүй 1кг ноолуурыг хилээр давуулахгүй. Цаашидаа бид ээрнэ. Утсаа үйлдвэрлэнэ. Дараа нь бид сүлжмэл буюу эцсийн бүтээгдэхүүнийхээ чадавхаа нэмнэ. Цагаан алт хөтөлбөр маань ноосны, ноолуурын, арьс ширний бүх үйлдвэрийн түвшинд нь үнэлгээ хийгдээд, ноолуураа энэ түвшинд нь сайжруулъя,

ноосоо энэ түвшинд сайжруулъя, нэхийгээ боловсруулалт, арьс ширний боловсруулалтаа энэ түвшинд сайжруулъя гэдгийгээ нөгөө мэргэжлийн холбоодтойгоо, аж ахуйн нэгжүүдтэйгээ хамтарч ажил гаргасан байхгүй юу. Энэ хүрээнд нэлээн томоохон хөдөлгөөн болно. Цагаан алт хөдөлгөөний маань зорилт нь энэ. Энэ Цагаан алт хөтөлбөрт туссан 113 тэрбум төгрөг маань хөрөнгө оруулалтын зээл болж очно. Эргэлтийн хөрөнгийн зээл болж очно. Энэ нь бид нар яамны тавих гол хяналт бол яг тэр самнах түвшний технологийн шинэчлэлт, ээрэх түвшний технологийн шинэчлэлт гэдэг маягаар хяналтаа тавигдана. Тэрнээс бид мөнгийг аваад өөр зориулалтаар ашиглахыг бол хатуу хяналт доор хэрэгжүүлнэ. Ингээд явж байгаа үйл ажиллагаа нэлээн ахиц гарна. Ноолуур дээр бол тийм байр сууриа эртхэн илэрхийлье. Ахиж самнаагүй ноолуур гаргана гэдэг зүйл байхгүй. Энэ бол зөвхөн энэ 2-ын хоорондын зөрүү нь бараг 100-аад сая долларын орлого Монгол Улсад орж ирж байгаа юм. Тэгээд л боловсруулалтын түвшин нэмэх тусам л валют нэмэгдээд, зардал багасаад байгаа ийм тоо байгаа юм.

Мал эмнэлгээ яах вэ зүтгүүлж л байна. Мал эмнэлгийн бие даасан агентлагтай болсон. Босоо тогтолцоотой болсон. Суурь мал эмнэлгийн үйлчилгээ бол хувийн хэвшилд 100 хувь шилжсэн. Энэ нь зөв байх. Түүрүүн гараад ирсэн яагаад ийм өндөр 40-өөд тэрбум маань өөрөө бүх сумын түвшинд байгаа мал эмнэлгийн үйлчилгээ, тарилга, вакцинжуулалт, угаалга, энэ түвшин дээр зарцуулаад хувийн хэвшил хийж байгаа. Ер нь хөдөө аж ахуйн салбарыг аль болох л хувийн хэвшил дээр тулгуурласан, хувийн хэвшлийн оролцоо, тэгээд биржийн арилжаан дээр суурилсан маягаар хөгжүүлэх нь зүйтэй.

Яамнаас олгож байгаа аливаа хүнд суртал тэр бусад тэр зөвшөөрөл, тусгай

зөвшөөрлийг бол байх доод түвшинд нь бүрэн чөлөөлж, хязгаарлалтыг бол багасгаж байгаа. Зөвхөн махан дээр байсан бүх зөвшөөрөл хязгаарлалтыг багасгасан. Махны экспорт 360 сая долларт огцом өсөж байгаа байхгүй юу. Энэ өсөлт хийгээд байгаа тэр 1 их наядын өсөлтийн чинь гол хувь нь махны экспорт нь гараад ирж байна. Манай мах дэлхийн нэлээн олон орон руу бодитой, амжилттай зах зээлд нэвтрээд байна. Тэгэхээр Мал эмнэлэг, Био комбинатаа л бид нар сайжруулж чадах юм бол энэ малчдын маань орлого сайтай байх. Экспорт байх тусам л орлого нэмэгдээд байна. Түүхий.../минут дуусав/

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Тийм ээ, бас энэ томоохон хөтөлбөрүүд үр дүнгээ өгч байгааг бол ойлгож байгаа. Тэр Цагаан алт, Хүнсний хувьсгал энэ чинь үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлууд явдаг учраас бол дэмжиж л байгаа юм. Гэхдээ бид яг сая таны хариултаас харахаар тэр мал эмнэлгийн энэ нөгөө мах үнэгүйдээд байгаагийн тэр учир шалтгааныг ердөө гол шалтгаан нь л ердөө л малын махны эрүүл мэндийн асуудал шүү дээ. Эрүүл байгаа, үгүйг нотолж чадах асуудал. Тэгэхээр мал эмнэлгийн энэ асуудал руугаа би бол онцгой анхаараач ээ. Лабораторийн хүчин чадал юмнууд чинь ер нь ямар байгаа юм бэ. Энэ үүсээд байгаа нөхцөл байдал чинь бол 2 сар өмнө үүссэн ийм л зүйлийг илрүүлж чадахгүй байсаар байгаад өнөөдөр ийм байдалд оруулж байгаа юм байна лээ шүү дээ. Тэгэхээр миний хэлээд байгаа 2018 оны тэр үеийн нөхцөл байдал дээрдээгүй юм байна гэж би хараад байгаа юм.

Кувейтэд манай мах зарагдаж байна лээ. Тэр Сэргэлэн сайдын юунаас би харсан. Тэнд ямар үнэтэй байгаа билээ. Эндээс авч байгаа нь юу билээ. Энэ 2-ын зөрүү чинь малын энэ эрүүл мэндийн асуудлаас болоод байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ дээр яг ямар зүйлүүд хийгдэх юм бэ гэж би асуугаад байгаа юм.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Яах вэ, яам өөрийн байгаа төсөв нөөц бололцооны хүрээнд л ажлаа зохион байгуулаад л явж байна. Үнэхээр салбарт тэр яг энэ тэргүүн эгнээнд байгаа мал эмнэлгийн эмч нарыг багаж тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгсэл, тэгээд бид нар ч сайн чанарын вакцин, тарилга гээд олон зүйл дутагдалтай байгаа. Тэгэхээр зайлиггүй л нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Тэгэхээр энэ чинь 70 сая малын вакцинжуулалт гээд л явах юм бол мөнгө нь 70, 80 тэрбум руу яваад л өгнө шүү дээ. Тэгэхээр бид нарт бол 1/3-ээр л ирж байгаа. Тэгэхээр аль болох л бид нар яг онилсон, голомтолсон, хүрээг хумьсан ийм олон тактик арга хэмжээг л хэрэгжүүлж байгаа шүү дээ.

Лабораториудын түвшин нэг үеэ бодвол боломжийн. Гэхдээ л дутуу байна. Яаралтай яг цогцоор нь л хандах хэрэгтэй. Яаманд ингээд бодлого тодорхойлоод үйл ажиллагаа эхэллээ гэхээр дараагийн шаардлага нь яг бодитой ингээд ургаж гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэ дээр Байнгын хорооныхоо гишүүд та бүгд, бүгдээрээ хамтраад л.../минут дуусав.

Б.Бейсен: Асууж байгаа асуулт дээр бас тодорхой хариулах шаардлагатай байна. Сая мал эмнэлгийн талын юмыг асууж байхад Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга нь байхгүй байх юм сайд аа. Сайд нь хариулъя.

Ж.Энхбаяр: Үнэхээр энэ анхан шатны мал эмнэлэг лабораторид үнэхээр төрийн бодлого дэмжихээр хөрөнгө оруулалт ердөө хийгдээгүй. Бодит байдал энэ. Анхан шатны орон нутгийн хүнсний аюулгүй байдал, мал эмнэлгийн аюулгүй байдлыг хангах лабораториуд нь чадавх муу байгаа. Тэгэхээр энд бол бодлогын мэргэжлийн Байнгын хороо энд

анхаарал тавиад, бүгдээрээ хамтдаа нэг ажил зохион байгуулъя. Яах вэ, энэ жилдээ 2025 ондоо энэ хүрээндээ нэг зүтгүүлээд ард нь гаръя. 2025 ондоо энэ манай салбартайгаа их сайн танилцахыг гишүүддээ урьж байна. Та бид чинь энэ асуудлыг л гаргаж шийдэх гэж байгаа хүмүүс шүү дээ. Сонгогдсон хүмүүс. Тэгэхээрээ ирэх онуудад мал эмнэлгийн анхан шатны лабораторийн түвшинд ахиц гарахын тулд газар дээр нь очих, танилцах, тэр асуудлыг нь шийдлийг нь олох ажлыг бол та бид хийх учиртай. Тэгэхээр бид бол яам бол хүлээж авахад бэлэн. Бүх танилцуулгыг бэлдээд байж байя. Ингээд хамтдаа энэ өвөл юу хийж байх вэ, яг энэ чиглэлээр л хамт ажиллая л гэж хүсэж байна.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэндийг хүргэе. Байгаль орчны яамтай холбогдолтой 2 асуулт байна. Монгол Улс Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Тэрбум мод хөдөлгөөнийг өрнүүлээд идэвхтэй ажиллаж байгаа. Энэ хөдөлгөөн бол бас ирээдүй хойчдоо зориулсан маш чухал хөдөлгөөн гэж ингэж боддог. Энэ хөдөлгөөний гүйцэтгэлүүд 2025 онд бас тодорхой ямар зорилтууд тавигдаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэлж байгаагаар бол бид нар хөрсөнд мод тарихаас гадна, бусдын ард иргэдийнхээ тархинд нь бас мод тарих хэрэгтэй гэдэг энэ агуулгыг бас энэ хөдөлгөөнөөр дамжуулж илэрхийлээд байгаа. Түүнтэй холбогдолтойгоор хашаандаа мод тарьсан , тариаланчид хамгаалалтын зурвас байгуулсан, иргэд энэ хөдөлгөөнд идэвхтэй оролцсон тохиолдолд 2025 онд яг тодорхой дэмжлэг тусгагдсан ийм зүйлүүд байна уу. Яаж энэ иргэдийн олон нийтийн дэмжлэгийг урамшуулдаг компаничилсан ажлыг бид бүхэн бас хийж болох вэ гэдэг чиглэлээр тодорхой хариулт авъя.

Олон улс бол энэ карбон кредитийн асуудлыг нэлээн ярьж, үүнээс тодорхой өрсөлдөөнийг бий болгож байна. Яг л бас нэг уралдаантай адилхан. Тэгэхээр яг энэ арга хэмжээ, ялангуяа зөвхөн улсын төсөв гэлгүйгээр тодорхой энэ зорилтууддаа хүрэхэд бусад олон улсын энэ боломжуудыг ашиглах чиглэл дээр ямар механизмуудыг бид бүхэн ашиглаж болох вэ. Мөн газар тариалан, хөдөө аж ахуйн салбарыг ч гэсэн дээ энэ дээр тодорхой оруулах боломжууд байгаа байгаа. Тэгэхээр энэ чиглэл дээр бас ямар байдлаар ажиллах вэ гэдэг энэ чиглэлийн асуултыг асууя.

Хөдөө аж ахуйн яамнаас сайд маань яг албан ёсоор нийгэмд энэ сар гаруй хугацаа бол боллоо. Хөдөө аж ахуйн яам маань Дархан хот руу нүүгээд. Нөхцөл байдал бас аль түвшинд байна. Манай бас ажилчдын нөхцөл байдал, нийгмийн хамгааллын асуудлууд бас ямаршуу байна. Зарим ажилчид маань бас оюутны байранд бас амьдарч байгаа гэсэн ийм мэдээллүүдийг бас авлаа. Тэгэхээр 2025 он цаашидаа бас ажилчдын нийгмийн асуудал дээр яаж анхаарах вэ. Ямар эерэг болон сөрөг үр дагаврууд нүүсэнтэй холбогдолтойгоор гарч байна вэ. Нийт төсөв бол 20 гар гаруй хувиар, урсгал зардал бол 40 орчим хувиар бас нэмэгдсэн байна. Тэгэхээр энэ 2, 3 байр ашиглах энэ байдлууд цаашидаа ямар байдлаар зохицуулах вэ. Хотод байгаа биржийн, корпорацын, бас хуучин яамны байрнуудыг бас ашиглалтыг яаж цаашидаа сайжруулах вэ гэдэг чиглэлээр бас нэг албан ёсны мэдээлэл бас өгчих нь зөв байх гэж бодож байна.

Татаастай холбогдолтой мэдээллүүдийг бас авлаа. Биржийн үйл ажиллагааг сайжруулах чиглэл дээр бас нэлээн анхаарал хандуулах чиглэл дээр бас ажиллах нь бол зөв. Энэ чиглэлийн юмнууд байна. Тэгээд сүүлд нөгөө ямааны годрон өвчинтэй холбогдолтой мэдээлэл бас нэлээн цацагдлаа. Манай мал эмнэлгийнхэн байвал бас энийг албан

ёсоор хариулаад, бас нэг ойлголт өгчих нь.../минут дуусав/

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя. Дараа нь Хөдөө аж ахуйн сайд хариулах юм байна.

С.Одонтуяа: Тэгэхээр Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн талаар саяхан бид дүгнэсэн. Маши нарийн мэдээлэлтэй 20-иод хуудас материал байгаа. Би энийг танд бас дараа нь хүргүүлье.

2 дугаарт Байнгын хорооны 3 дахь асуудал дээр бид нар энэ байгаль орчны асуудлаар нэлээд дэлгэрэнгүй мэдээлэл өгнө. Одоо бол би танд яг төсөвтэй холбоотой хэдэн тоонуудыг нь хэлэхгүй бол энэ цаг нь дороо дуусчхаад байх юм. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх асуудал дээр бол энэ онд чамлахааргүй бас төсвүүдийг тавиулсан байгаа. Энд бол ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хийх, мод үржүүлгийн газрын хүчин чадлуудыг нэмэгдүүлэх, ойн хөнөөлт шавжийн тархалт судалгаа тэмцлийн ажил хийнэ. Ой зохион байгуулалтын ажил хийнэ. Түймрээс урьдчилан сэргийлнэ, хамгаална. Ойн төлөв байдлыг сайжруулна. Арчилгаа, цэвэрлэгээ гээд үндсэндээ 6 үндсэн чиглэлээр төсвүүд тавигдсан байгаа. Өнгөрсөн хугацаанд би бас аймгуудаар яваад үзэхээр энэ шавж бол бас нэлээд олон ойг хамарсан байгаа. Энэ хортон шавж. Тэгэхээр зөвхөн Архангай аймгийн дүн гэхэд л зөвхөн 1/3-д нь бид нар хор цацаж, устгал хийж чадсан. Тэр нь бол маш сайхан сэргэчихсэн. Бусад 2/3-т нь мөнгө байхгүй бас хийж чадаагүй. Тэгэхээр бид нар энэ хортон шавж устгал дээрээ сайн ажиллах юм бол ойгоо бол хамгаалах ийм боломжтой болж байгаа юм.

Энэ гамшигаас ойн түймэрт мод бол нэлээд бас сүүлдэг. Энд харин техникийн дэвшилүүдийг судлаад байгаа ч бас төсөв хөрөнгөний байдлаас шалтгаалаад энэ дээр бол ямар нэгэн тоног

төхөөрөмжүүд бол тавигдаж бас чадаагүй байгаа.

Карбон кредитээр бол Эдийн засаг, хөгжлийн яаман дээр бас яг энэ асуудлыг хариуцсан ийм нэгж ажиллаж байгаа. Би бас саяхан яг англи карбон кредитээр төгссөн магистр төгссөн хүүхдийг бас зөвлөхөөрөө аваад, энэ дээр бас анхаараад ажиллаж байна. Ер нь байгаль орчны салбар дээр гаднынхантай ярихад л дандаа л ногоон эдийн эдийн засаг руу л маш хурдтай шилжиж, байгаль орчноо хамгаалдаг гэсэн ийм зүйл байгаа учраас бид нарын ногоон эдийн засаг руу хурдан чиглэхээр маш том бодлогуудыг бас бэлдээд хэрэгжүүлээд явж байгаа.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэр гарч Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг хөдөө аж ахуйн төрөлжин эрчимжүүлэн хөгжүүлэх аж үйлдвэрлэлийн төвийн бүсэд шилжих ийм үүрэг даалгавар өгчихсөн. Үүрэг хэрэгжиж байна. Үндсэндээ бүрэлдэхүүний тодорхой хувь шилжиж очоод үйл ажиллагаагаа явуулж байна. Хамгийн эхэнд харьяа байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газрууд, агентлагууд ажиллагаандаа ороод, үйл ажиллагаа нь жигдэрсэн. Шилжихэд мэдээж нийгмийн асуудал буюу орон сууцын асуудал гол асуудал байгаа. Сая өчигдрийн Засгийн газрын хурлаар орон сууцын асуудлыг шийдэхийг Сангийн яаманд Ерөнхий сайд үүрэг болгосон. Тэр хүрээнд бид ажиллаад, эх үүсвэр хувилбаруудыг гаргаад ингээд явж байна. Оndoо багтаад орон сууц нь шийдэгдсэн нөхцөлд шилжих маягаар ингээд зөөлөн шилжилтийг аажим аажим хийгээд ингээд дуусах байх.

Яг энэ гол 4 хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол бүс нутагтаа очсон нь үнэхээр ажил явуулахад.../минут дуусав/

Б.Бейсен: Тодруулъя гэж байна. Ганхулэг гишүүн.

М.Ганхулэг: Байгаль орчны сайдаас дахиад тодруулъя. Яг одоо энэ Тэрбум мод хөдөлгөөнийг бид бүхэн зөвхөн яамны ажил байдаг юм уу, байгаль орчны салбарт ажиллаж байгаа бас хүмүүсийн ажил гэж бас харахгүйгээр иргэд, олон нийтийг яаж оролцуулах вэ гэдэг ийм л агуулгаар нь би асуугаад байгаа юм. Тэгээд яг хашаандаа мод тарьсан хүнийг дэмжих ийм боломж байна уу. Тариаланчид хөрс хамгаалах зорилгоор мод тарьсан тохиолдолд тэрийг урамшуулах ийм боломж байна уу. Ангиараа, баг хамт олноороо энэ хөдөлгөөнд орсон тохиолдолд зөвхөн 1 удаагийн 2 өдрийн ч юм уу, 1 өдрийн арга хэмжээ олоод зогсохгүйгээр байнгын яг тэр модоо 4, 5 жилийн хугацаанд яг бие дааж ургах хүртэл нь арчлах энэ чиглэлийн ажлыг сургах, компанижуулах, тэгээд иргэдийнхээ тархинд мод тарья гэж байгаа энэ агуулгыг яах вэ гэдэг энэ дээр төсөв байна уу л гэж асуух гэж байгаа юм.

Б.Бейсен: 2 номерын хариулъя гэж байна. Байгаль орчны яамны Төрийн нарийн.

Э.Баттулга: Ганхулэг гишүүний асуултад хариулъя. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг бид нар ер нь яг таны хэлсэн чиглэл рүү явуулж байгаа. Үүний хамгийн том хөшүүрэг бол сая Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуульд орсон өөрчлөлт байгаа. Нөгөө нийгмийн хариуцлагын хүрээнд мод тарих, байгалийн нөөцийг хамгаалах тохиолдолд татвар ногдох орлогын 1 хувь хүртэлх хэмжээтэй татварын хөнгөлөлт эдлэх. Энэ бол маш том эдийн засгийн хөшүүрэг гэж харж байна.

2 дугаарт тариаланчдыг дэмжих ажлыг бол сая Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтайгаа хамтраад эхлүүлсэн. Жишээлбэл Дархан Сэлэнгийн бүс нутагт 42км хамгаалалтын зурвасын

ойг бий болгоод, агро ойжуулалтын жишиг төслийг явуулж байгаа юм. Энэ хамтын ажиллагааны хүрээнд яаж байна гэхээр тариаланчид маань өөрсдөө хамгаалалт, хашаа, усжуулалтаа хариуцуулаад, ойн мэргэжлийн байгууллагууд болохоор тарих тарьц, суулгацаа хариуцаад явж байгаа.

3-д нь энэ иргэдийг дэмжих асуудал бол ой дээр угаасаа Байгаль орчны тухай хуулиудад байгаа. Ойн тухай хууль дээр жишээлбэл өөрийн хөрөнгөөр эзэмшил газар дээрээ мод тарьсан хүнд.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж хариулъя гэж байна.

Э.Баттулга: Тухайн газраа өмчлөх давуу эрхийг олгож байгаа. Түүнчлэн энэ жил бол манай ойжуулалтын хөтөлбөр 77,6 тэрбум төгрөгийн хөрөнгө суусан. Энэ дотроос аж ахуйн нэгж, иргэний ургуулсан ойг улсын ойн санд худалдан авах тодорхой хэмжээний төсөв тавигдаж байгаа. Тэгээд энэ дээр шаардлага тавигддаг. Жишээлбэл 5 жил тогтвортой ургуулсан, ургалтын байдал нь 80-аас дээш хувь ч гэдэг юм уу энэ шаардлагуудыг хангасан иргэд бол улсын ойн санд ойгоо худалдах ийм боломж бас байгаа.

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүний асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Хүнсний хувьсгал хөтөлбөрийн хүрээнд асуулт асууя. Монгол Улс жилдээ хэдэн төгрөгийг импортын хүнсэнд гаргаж байгаа вэ. Жилд 3,8 их наядын хүнсний бүтээгдэхүүн импортолдог гэсэн тоо надаа байгаа. Өндөг, цөцгийн тос, тахианы мах гэх мэтчилэн. Бид энийг орлуулахын төлөө импортолдоггүй, эдгээр бүтээгдэхүүнүүдийг дотооддоо 100 хувь хангадаг болохын төлөө Хүнсний хувьсгал хөтөлбөрийн бас тодорхой агуулга чиглэл байдаг. Энэ дээр ямар арга хэмжээ авсан бэ. Жишээ нь

сүүнийхээ бид нар бараг 20-иод хувийг гаднаас импортлож байгаа. Литр тутамд 1 мянган төгрөгийн татаас өгдөг гэж байна шүү дээ. Энийг өгөөд ахиц гарсан уу.

Нөгөөдөх нь хүнсний аюулгүй байдал одоо бид нар 773 нэр төрлийн бүтээгдэхүүнээс 318 нэр төрлийн бүтээгдэхүүнд лабораторид шинжилгээ хийж чаддаггүй гэдэг дүн байдаг. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори урвалж бодис байхгүй, хүний нөөц байхгүй, техник, тоног төхөөрөмж дутуу учраас энэ гаднаас орж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүнүүдэд лабораторийн шинжилгээ хийж чаддаггүй гэсэн ийм мэдээ байсан. Энэ засагдаж янзалж импортоор орж ирж байгаа бүх бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийж чадаж байгаа юу.

Хүнсний ногоогоор дотооддоо 100 хувь хангадаг болохын тулд бид нарт зоорь хэрэгтэй тийм үү. Зоорь одоо яг хангагдсан уу. 40 хувийн хүнсний бүтээгдэхүүнээ бид зооринд хадгалж чаддаггүй гэдэг тийм дүн мэдээлэл байдаг. Тэгэхээр зоорь нэмж барих асуудал нь шийдэгдсэн үү. Хэрвээ шийдэгдээгүй бол энэ хөрөнгө оруулалтаар шийдэгдэх юм уу, хувийн хэвшилтэй хамтрах уу. Хувийн хэвшилтэй хамтрах юм бол ямар дэмжлэг өгч байгаа вэ.

Нөгөөдөх нь эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлнэ гэж бид нар ярьж, зорьж байгаа. Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэхийн тулд бид нар малын тэжээл тариалах ёстой. Малын тэжээл тариалахын тулд нэмж тариалангийн газар бий болгох ёстой. Энэ дээр судалгаа хийгдсэн. Танай яам дээр энд дорвитой яг хийсэн алхам байгаа юу. 2 мянга гаруй га талбайг нэмж малын тэжээлд зориулж тариалан тарина гэж байсан би санаад байх юм.

Нөгөөдөх нь махны экспорт гэж бид ярьж байгаа. Малаа, махаа экспортолно гэж дотооддоо 100 хувь хангаад. Тэгэхийн тулд тоонд биш чанарт суурилсан ашигтай арилжаанд ордог тийм мал аж ахуйг бид бий болгох ёстой. Эрчимжсэн мал аж ахуйг бий болгох ёстой. Энэ тал дээр олон мянган жил уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн мал аж ахуй эрхэлсэн ард түмэн учраас соён гэгээрүүлэх ажилд хэчнээн төгрөгийн төсөв зарцуулахаар.../минут дуусав/

Б.Бейсен: Дараа нь тодруулаарай. Сайд хариулъя.

Ж.Энхбаяр: 2023 оны эцсээр бид 1,3 тэрбум долларын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн импортолсон. Эсрэгээрээ бид 980,9 сая долларын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн экспортолсон. Хөдөө аж ахуйн гаралтай бүтэх бүтээгдэхүүн дотроо хүнс 1 тэрбум доллар байгаа. Үүний эсрэг нөгөө хөдөлгөөн хөтөлбөрүүд маань үргэлжлээд ирсэн. Үр дүн гарч эхэлж байна. Нийт 3,5 их наяд төгрөгийн үйлдвэрлэл хийгдээд, 4,7 их наядын борлуулалт хийж байна. Жилийн дотор 1,2 их наядар манай Монголын дотоодын үйлдвэрлэл босож эхэлж байна. Тэгэхээр их сайн үр дүнгүүд байна. Энэ дотор жишээлбэл сүүн дээр очсон литр тутам 1 мянган төгрөг. Энэ үнэхээр хөдөө гарч, фермийн аж ахуй эрхлэх ийм хүслийг нэлээн өдөөсөн. Та бүхэн мэдэж байгаа. Сүүний чиглэлийн фермүүд нэлээн сайжирч байна. Бараг 50 хувиар шингэн сүүний нийлүүлэлт нэмэгдлээ. Энийгээ дагаад энэ маш олон асуудал сүүн дээр бараг 70 хувийн импорт байгаа юм. 70 сая малтай гээд бэлчээрт яваа малынхаа дэлэнд байгаа сүүг тооцоод Монгол Улс сүүний хэрэглээ дэлхийгээс 3 дахин өндөр гэж бид нар статистик гардаг. Гэтэл бодит байдал дээр Монгол Улс сүү буюу сүүгээр дамжуулж байгаа амин дэм, кальцийн гүнзгий дутагдалтай. Ялангуяа хот суурин иргэд. Дөнгөж 30 хувийн хангалттай. Импорт бараг 70 хувь,

хуурай сүү 100 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, бяслаг, аарц, цөцгийн тосноос авхуулаад үндсэндээ 90 гаруй хувь импорт байгаа. Тэгэхээрээ эрчимжсэн ийм аж ахуйнуудыг олон 10-аар бий болгож байж явахаас цааш арга байхгүй. Эрчимжүүлэхийн тулд яах вэ, таны хэлдэг тэжээл тариалалт нэмэгдүүлэхээс арга байхгүй. Монгол Улсад өнөөдөр 1,1 сая га газар хөдөө аж ахуйн эргэлтэд байна. Үр тарианы. Энэ маань Атрын 1, 2 дугаар аяны хүрээнд бий болсон газар. Тэгэхэд Монголын хүн ам 1 сая дөнгөж хүрч байсан үед хүн амын хэрэглээнд тооцож гаргасан эдэлбэр газар байхгүй юу. Одоо хүн ам 3,5 сая, 2030 он гэхэд 4 сая болж байна. Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг хангахад энэ эрчимжсэн аж ахуй, гахай, тахиа, сүүний аж ахуйнуудыг өндөгний аж ахуй тэжээлээр хангахад одоо байгаа газар хүрэлцэхээ больсон. Иймд Атрын 4 дүгээр аян гэдэг энэ аяны хүрээнд бид нийт 200 мянган га талбайг шинээр эргэлтэд оруулахаар оруулж ирж байгаа. Үүний бараг 50 хувь нь нөгөө хоршоолсон малчдадаа очно. Орон нутагтаа нөгөө тэжээл тарих, нөгөө өвлийн эрсдэлийг даван туулах чадавхыг бий болгох чиглэлээр газар олголт, тэжээлийн чадавхжуулах ажил орж ирнэ. Энэ хүнсний хувьсгалын хүрээнд зоорины аж ахуй дээр 1 номерын эрэмбэтэйгээр нөгөө хөнгөлөлттэй зээлүүд явж байгаа. Та зоорины аж ахуйд зээл авах юм бол танд 10-12 хувийн хүүгийн татаас өгнө гэх мэтчилэн. Та сайн үүлдрийн мал оруулж ирвэл энэ мөнгө өгч өгнө. Нэг ийм жишээг хэлэхэд сүүн дээр гэхэд л манай энэ төвийн бүсийн хэд хэдэн сум байгаа юм. Батсүмбэр, Борнуур, Зүүнхараа гээд 100 хувь үндсэндээ сүүн дээр ажилладаг. Фермерүүд, аж ахуйнууд байдаг. Гэтэл тэндээс нэг саалийн үнээний жилийн норм дунджаар 2 мянган литр дээр л явж байна. Гэтэл дэлхийн дундаж 10-12 мянга руу оччихсон. Бүтээмж 4-5 дахин бага байна. Яагаад ийм байдал үүсэх вэ гэхээр таны хэлдэг тэжээлийн дутагдал, нөгөө талаас малын үүлдэр угсаа, үржил

селекцийн ажлыг хувийнх гээд хаячихсан. Төр үүнээс холдсонтой холбоотойгоор малын үйлдвэрлэг байдал алдагдчихсан. Үндсэндээ сүүлийн 30 жил энэ үржил селекцийн ажлыг бодлогоор хийгдээгүй. Тэгэхээр энэ үржил селекцийн ажлыг сайжруулах, сүүний гарц, махны гарц нэмэхийн тулд бид бас энэ Атрын 4 дүгээр аяны хүрээнд 200 мянган толгой мах, сүүний үхрээр үхэр сүргийнхээ бүтцийг сайжруулахаар бас зорьж байгаа. 200 мянган га-д таримал тэжээлийнхээ массыг нэмж байгаа. Тэжээлийн үйлдвэрүүдийг мөн энэ зээлийн бодлогын хүрээнд дэмжиж байгаа. Ерөөсөө л өвлийн улирлын бид давахын тулд сая өнгөрсөн зуны 8 өвөл.../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Өнгөрсөн өвөл бид нар 8,1 сая малаа алдаж байгаа юм. Үндсэндээ өлдөөд, хөлдөөд ингээд үхэж байгаа юм. Хохирол эдийн засгийн боломжоор нь тооцоход тэрбум долларын алдагдал. Хашаа саравчаа олигтой сайжруулаад, тэжээлийн жоохон нөөц байхад л явчих ийм хохирол гарахгүй ажил зүгээр байгаа юм шүү дээ. Тэгэхээр энэ чинь зайлиггүй дэлхийн глобал цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор манайд ийм огцом градусын хэлбэлзэл өндөр байна. Энийгээ дагаад хур тунадасны хэмжээ огцом эрс нэмэгдэж байна. Иймд мал маллах арга ухаандаа өөрчлөлт хийхгүй бол болохгүй нь ээ. Тэгээд хамгийн түрүүнд энэ төвийн бүс дээр бид нар гол анхаарал тавьж байгаа. Нөгөө тарьдаг ургуулдаг талбай маань хязгаартай. Монгол Улсын нийт газар нутгийн 0.6 хувь буюу 1.1 сая га газарт л үр тариа, тэжээл чинь боловсроод бий болж чадаж байгаа юм. Бусад газар үнэхээр хязгаартай. Их өндөрдөөд болц гүйцэхгүй, ургамлын тарилт нь үр ашиггүй гараад байдаг. Тэгэхээр энэ төвийн бүс дээрээ тулгуурлаж.../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Одоо нөгөө тоонд шүтэж олон малтай байх биш, чанартай мал өсгөх, тэр нь арилжаанд ордог байх ёстой шүү дээ. Тэгэхээр тэр дээр бид нар уламжлалт сэтгэхүйгээ эрчимжсэн мал аж ахуй руу чиглүүлэхэд зориулсан соён гэгээрүүлэх ажиллагаа явуулж байгаа юу. Дээрээс нь бид нар хүнсний ногоогоороо жилийн 4 улиралд өөрсдийгөө хангахын тулд нөгөө хүлэмж бид нар их хэмжээгээр хувийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих ёстой шүү дээ. Тэр 4 улирлын хүлэмж бол асар үнэтэй юм байна лээ. Тэгэхээр тэр дээр бас зээлийн хөнгөлөлт, ямар нэгэн тусгай тийм юу үзүүлж байгаа юу. Зээлийн хөнгөлөлт л үзүүлэх байх даа тийм үү.

Б.Бейсен: Сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Мэдээж махны экспорт нэмэгдэхэд ерөөсөө малын чанар, сүүний гарц нэмэхэд малын чанар. Тэгэхийн тулд энэ чиглэлийн ажлууд яг энэ хөтөлбөртөө суугаад бас дэмжлэг авна. Хүлэмж дээр тооцоо хийсэн. Одоо бас гишүүд ээ анхаараарай. Энэ гялгар уутан нимгэн ийм хүлэмжээр ахиж хөрөнгө зармааргүй байна. Хангалттай. 20 жил тараалаа. Үр дүн тун бага. 10-аад га-ийн иш 4 улирлын тэр үнэтэй гэж байгаа автомат удирдлагатай хүлэмжүүд орж ирсэн. Энэ бол төв суурин газрын ногоо дээр бодитой үр дүн гарч байна. Тасралтгүй байдлаа хангаж чадаж байна. Тэгэхээр бид 50 га-д өвлийн хүлэмжтэй болоход манай хэрэглээг бүрэн хангах юм байна лээ. 50 га. Тэгэхээр энэ рүү чиглэсэн тэр зээлийн хөнгөлөлтүүд явна.

Зоорь дээр 100 мянган м3 зоорь хэрэгтэй. Мөн адилхан орчин үеийн хөргүүртэй, халаалттай, махны, хүнсний ногооны гээд төрлөөр нь гэсэн ийм зоорины систем онцгой чухал. Үндсэндээ хүйтний улирал өндөр байгаа манайх ишг оронд бол зоорь ... /минут дуусав/

Б.Бейсен: Сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Хүнсний хувьсгалын хүрээнд орсон байгаа. Атрын 4 дүгээр аяны хүрээнд орсон байгаа. Цогцоор нь л ингээд оролдоод байгаа юм. Тэгээд аяндаа үр дүн гараад ирэхээр ойлголт их сайжрах байх гишүүд ээ. Бүгдээрээ 1 жил сайн ажиллаад, сайн танилцаад тэгээд мэдрээд ирэхээр энэ бодлого улам цаашидаа явах нь зүйтэй гэдэг итгэл үнэмшил бий болох байх. Тэгэхээр ахиад хэлье. Хамтдаа л бүгдээрээ энийг хийх ёстой. Ганц яам хийх ажил биш шүү дээ. Бидэнд хуулийн том өөрчлөлтүүд, эрх зүйн сайжралт хийх, бүр цогцоор нь авч үзэх ийм зайлигүй шаардлага хөдөө аж ахуйн салбарын багц хуулийг иж бүрнээр нь бид нар уялдуулах, шинэчлэх, 21 дүгээр зууныг хөдөө аж ахуйд нь чиглүүлэх маягаар ингээд өөрчлөх зайлигүй шаардлага бас байгаа.

Б.Бейсен: Наранбаатар гишүүд асуулт асууя.

Н.Наранбаатар: Сангийн яамнаас энэ бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулаад татварын уян хатан бодлого хэрэгжүүлнэ гээд 2025 онд тусгасан байгаа юм. Тэгээд энэ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор татварын ямар тодорхой бодлого, хөнгөлөлт, чөлөөлөлтүүд байдаг юм уу, ямар дэмжлэг энэ салбарыг дэмжихээр төлөвлөж байгаа юм бэ гэсэн асуулт байна.

Хөдөө аж ахуйн яамнаас өнгөрсөн б сард Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль батлагдсан. Тэгээд 2025 онд агентлаг байгуулагдаад ажиллах ёстой. Тэгээд энэ чиглэлээр хэдий хэмжээний төсөв тавьж, ямар ажлууд 2025 онд ургамал хамгааллын чиглэлээр хийхээр төлөвлөж байгаа вэ гэсэн ийм асуулт байна.

Түрүүн бас халти дурдаад өнгөрсөн. Энэ орон нутаг ялангуяа сумд хөдөө аж ахуйн тасагт ажиллах

боловсон хүчин байхгүй. Зөвхөн манай Өмнөговь аймгаас жишээ дурдахад л 15 сумын 10-д нь хөдөө аж ахуйн тасагт мал зүйч, мал аж ахуйн мэргэжлийн хүн байхгүй. Боловсон хүчний дутагдалд орчихсон. Тэгэхээр 2025 онд энэ салбарынхаа боловсон хүчнийг хангах чиглэлээр ер нь төсөв хөрөнгө юм тавигдсан юм байна уу. Тэгээд угаасаа дутагдалтай байдаг гээд ингээд цаашаа яваад байх юм уу. Ямар нэгэн арга хэмжээ авч боловсон хүчнийг бэлтгэх тал дээр хийх гэж байгаа, төлөвлөж байгаа ийм ажил байна уу гэсэн ийм асуулт байна.

Байгаль орчны яамнаас энэ газрын доорх усны түвшнийг хянахад 325 цэг хяналтын цооног ажилладаг гэж байгаа юм. Тэгэхээр үүний тайлан сүүлийн жилүүдэд гарсан тайлан нь ямар байгаа юм. Өөрчлөлт нь ямар байгаа юм. Тухайлбал, Өмнөговь, Ханбогд, Оюутолгой, Цогтцэций хавьд байгаа тэр Долоодойн сав газрын цооногуудын усны дундаж түвшин сүүлийн жилүүдэд яаж өөрчлөгдөж байгаа юм бол. Энэ талаар нэг мэдээлэл өгөөч.

Тэгээд мөн Байгаль орчны яамны мэдээлэлд усны нөөцийг зөв зохистой ашиглах зорилгоор хөв цөөрөм байгуулна гээд тавьсан байсан. Тэгээд хэдий хэмжээний төсөв хөрөнгө хуваарилсан юм. Хаана хаана, ямар хөв цөөрөм байгуулахаар судалгаа тооцоо хийж байгаа юм бол 2025 онд гэсэн ийм хэдэн асуулт байна.

Б.Бейсен: Эхлээд Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. 2019 онд бид багц татварын реформ хийснээс хойш ер нь татварынхаа суурь хувь хэмжээгээр бол ерөөсөө оролдоогүй байгаа. Ингээд ямар ч байсан дор хаяж 8 жил энэ реформынхоо үр дүнг харчихмаар байгаа юм. Дундуур нь их ярьж байгаа юм. Реформ хийнэ. Дахиад

бүгдийг нь өөрчилнө гээд. Уг нь тогтвортой байгаад, үр дүнгээ харчих нь их чухал байгаа юм. Гэсэн хэдий ч цаг хугацааны болоод эдийн засгийн өсөлт энэ бүх юмнууд дээрээ бид бас тооцоолоод, ямар ч байсан энэ Засгийн газрынхаа нүүрэн дээр татварын багц хуулиуд дээрээ юуг нь өөрчлөх шаардлагатай байна. Яах хэрэгтэй байна. Ялангуяа татварын суурийг тэлэх тал дээр нэлээдгүй өөрчлөлт хийе гэдэг ийм ажлуудаа бол эхэлж байгаа. Одоогоор бол судалгааны түвшинд байна. Ямар ч байсан 1 дүгээрт бүсчилсэн хөгжлийнхөө суурь үзэл баримтлалтайгаа уялдуулж бүс бүсээр тэргүүлэх чиглэлийн салбаруудаа тодорхойлсны үр дүнд ялгаатай байх, хоорондоо кластерлаж хөгжих энэ боломжуудыг бүрдүүлэх чиглэлээр татварын өөрчлөлтүүд хийнэ. Одоогоор нэг бүрчлэн зарлах бол арай эрт байна. Одоогоор зарлачихсан байгаа зүйл маань бол бүх төрлийн боловсруулах чиглэлийн үйлдвэр, боловсруулах шатыг ахиулах ийм шаардлагаар орж ирж байгаа технологийн тоног төхөөрөмжүүд дээр гаалийн албан татварыг бүрэн чөлөөлж байгаа. 1 сарын 1-ээс эхлээд. Гэхдээ сүүлийн одоо бараг 20-иод жилийн хугацаанд шүү. Энэ татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг хамгийн их эдэлдэг, хамгийн их хэрэглэдэг салбар бол хөдөө аж ахуйн салбар. Одоо 1 сарын 1-ээс боловсруулах чиглэлийн үйлдвэрүүдийг хөнгөлнө л гэж байна. Гэтэл хөдөө аж ахуйн салбарын хүнсний үйлдвэрийн болон бусад мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн гаалийн татвар технологийн өмнө нь ч явж ирсэн цаашидаа ч ингээд үргэлжилнэ гэсэн уг. Хамгийн өндөр чөлөөлөлттэй нь энэ салбар байсаар ирсэн. Одоо бол хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг жишээ нь 50 хувь хөнгөлөгдөж байгаа. Одоо ийм хууль үйлчилж байгаа. 900 км-ээс цааш байрлалтай бол бүр 90 хувь чөлөөлөгдөж байгаа. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар. Өөр салбар

байхгүй. Тэгэхээр тус салбар бол хамгийн хөнгөлөлт чөлөөлөлттэй татвар дээр хамгийн ээлтэй ийм орчинд явдаг ийм салбар юм гэж үзэж болно. Тэгээд цаашидаа энэ асуудал дээр гишүүд маань ч гэсэн яг бүс бүсээ төлөөлж бүсийн бодлогыг хэрэгжүүлэх гол төлөөллүүд учраас энэ асуудлууд дээр их түлхүү оролцоод явна гэж бодож байна.

Б.Бейсен: Байгаль орчны сайд хариулъя.

С.Одонтуяа: Мааш чухал асуулт асуулаа. Монгол Улсад бид нар гадаргын усыг ашиглах энэ асуудал руу нэлээд эрчтэй орох ёстой байгаа. Яагаад гэхээр уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж, манайд байгаа энэ мөстлөг, гол уудууд бол мааш хурдтай хайлж байгаа. Тийм учраас бид нар энэ үер усны асуудал бол байнга цаашидаа өсөн нэмэгдэх ийм төлөвтэй. Тэгэхээр энэ хөв цөөрөм байгуулах асуудалд бол манай яам онцгой анхаараад энэ жил үлгэрчилсэн ТЭЗҮ хийгдэж байгаа. Тэгэхээр энэ үлгэрчилсэн ТЭЗҮ-ийн дагуу аймаг, сумууд санаачилга өрнүүлээд бид 333 хөв цөөрөм гэдэг санаачилгыг энэ 2025 онд өрнүүлэх юм байгаа юм. Энэ дээрээ бид бол бас гадаадын төсөл хөтөлбөрүүд хандив мөнгийг бол бас нэлээдгүй босгоод ажиллаж байна. Яг улсын төсөвт манай Төрийн нарийн хэлчих. Энэ улсын төсөвт нэлээн хэд хэдэн задаргаагаар байгаа. Тэгээд тэр усны нөөцийнх нь нарийн судалгааг.

Б.Бейсен: 2 номер нэмж хариулъя. Төрийн нарийн.

Э.Баттулга: Баярлалаа. Манай энэ усны хяналт шинжилгээний сүлжээнд холбогдсон цооног одоогоор 325 байдаг юм. Энийг болохоор Мянганы сорилтын сангийн Усны компакт гэрээний хүрээнд 2024 онд шинэчилсэн. Энэ жил 25-ыг нэмж хийнэ. Ингээд хэлэхээр нийтдээ 350 орчим яг real time мониторинг хийдэг ийм төхөөрөмжүүдтэй болно.

Усны хөтөлбөрийн зардалд энэ жил 3 тэрбум 500 сая төгрөг тавьсан. Бид говийн бүсийн усан хангамжийг нэмэгдүүлэх, ялангуяа газрын доорх усны хайгуул судалгааны ажилд энэ мөнгөө ер нь зарцуулна гэж төлөвлөж байгаа. Нийтдээ манайд хайгуул судалгаа хийсэн 17,3 хувийн нутаг дэвсгэр байгаа. Энийгээ 23 орчим хувьд хүргэнэ гэж зорьж байгаа.

Хөв цөөрмийн тухайд гэвэл энэ жилд 13,1 тэрбум төгрөгийн төсөв тавигдсан. Яг гадаргын усыг хуримтлуулах дээр. Жишээлбэл, энэ дээр Хөлийн, Дэлгэр голын, Цагаан голын, Арвайн талын, Булган нуурын гээд ийм 5 зураг төсөл ТЭЗҮ-тэй.../минут дуусав/

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулъя.

Ж.Энхбаяр: 2025 оноос хууль хэрэгжинэ. Ургамал хамгааллын агентлаг үйл ажиллагаанд орно. Энд зориулсан төсөв 530 орчим сая төгрөгийн төсөв төсөвт суусан. Үйл ажиллагаа эхэлнэ. Хүний нөөцийн асуудал яах аргагүй хүнд байна. Хүний нөөцийг бид нар зохицуулалт хийхийн тулд мал зүйч, малын эмч нарыг энэ мэргэжлийн индексийг нь нэгтгэх замаар харилцан ийм хөрвөх бололцоотойгоор зохицуулахаар Боловсролын яаманд бас хүсэлт өгөөд, хариу хүлээж байна. Яг бодит байдал дээр үнэхээр хүний нөөцийн асуудлыг манай боловсролын салбар үндсэндээ бэлдэж чадсангүй. 20-иод жил боллоо. Манай ХААИС 15 мянган оюутан бэлдэж байсан сургууль одоо 3 мянга орчим оюутан. Тэгээд ангиуд нь аваад үзэхээр Хөдөө аж ахуйн маркетинг, Хөдөө аж ахуйн менежмент, Хөдөө аж ахуйн аялал жуулчлалын оюутан бэлдээд байдаг. Үндсэн манай технологийн агрономууд, мал зүйч нар, зоо техникүүд, Хөдөө аж ахуйн техникч нар байхгүй. Хүрээлэнгүүд.../минут дуусав/

Б.Бейсен: Наранбаатар гишүүн тодруулъя гэж байх шиг байна. Сангийн сайд хариулъя гэж байна. Энхбаяр сайд түрүүлээд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Үнэхээр энэ мэргэжлийн дутагдалтай. 330 сумаас бараг 60, 70 сум мал эмнэлэггүй байгаа. Хүн хүнгүй байгаа. 60, 70 гарсан, тэтгэвэртээ гарсан ахмадууд энэ ажил үүргийг аргалж байгаа. Зохицуулж гүйж байна. Тэгэхээр энд мэргэжлийн Байнгын хороо онцгой анхаарал хандуулахгүй бол хүний нөөц болохоо байлаа. ХААИС-ийн I жишээ байна л даа. Энэ агро-экологийн сургууль байгаа юм. Яг газар тариалангийн агрономи бэлддэг сургуулиуд. Дарханд салбартаа бэлдэнэ. Улаанбаатарт бэлдэнэ. Хоорондоо өрсөлдөнө. Үгүй ээ, яахаараа I газар бэлдээд, I газраа анги дүүргэлт хийгээд явж болдоггүй юм бэ. Ингээд бодлого нь, шинжлэх ухаан нь, хүрээлэнгүүд нь салбараасаа салчихсан. Энийг нэг гажуудал үүсээд байна. Салбар унаад байдаг. Хүний нөөц дутаад байдаг. Ерөөсөө бодитой болчихсон. Нэг бол бид гаднаас яаралтай олон 10 мянгаар нь ажиллах хүч авахаас аргагүй болж байна. Хөдөө аж ахуйн салбарт оёдол, ээрмэл, сүлжмэл, энэ арьс шир, ингээд хөдөө аж ахуйн энэ ногоо, жимс, хүлэмж гаднаас ажиллах хүч авахгүй бол бас.../минут дуусав/

Б.Бейсен: Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Байгаль орчны яамнаас тэр гүний усны цооногийн тайланг бичгээр надад өгчхөөрэй гэсэн хүсэлт байна. Сүүлийн жилүүдэд харьцуулаад гүний усны хэмжээ доошилж байгаа юм уу, дээшилж байгаа юм уу. Уул уурхай хэрхэн нөлөөлж байгаа юм. Бодитойгоор малчдын гар худаг ширгээд л байгаа шүү дээ. Тэгсэн мөртөө уул уурхайнхан болохоор гүний усны түвшин хэвээрээ байгаа, бараг л нэмэгдэж байгаа л юм яриад байгаа шүү

дээ. Тэгээд хэр зөрүүтэй байгаа юм. Бичгээр авчихъя гэж бодож байна.

Тэгээд ер нь боловсон хүчин дээрээ анхаарахгүй бол болохгүй. Ялангуяа энэ мал аж ахуйн чиглэлийнх байна. Тэгээд энэ гидрогеологи усны чиглэлийн боловсон хүчин Монгол улсын хэмжээнд 2024 онд 6 хүн төгслөө гэж сонсож байсан. Тэгээд энэ дээр ер нь анхаарал хандуулахгүй ингээд явах юм бол цаашидаа бид усны мэргэжилтэнгүй, хөдөө аж ахуй, мал аж ахуйн мэргэжилтэнгүй л болох юм байна. Энэ дээр хаана хаанаа анхаарч ажиллахгүй бол болохгүй юм байна. Төсөв хөрөнгө тодорхой хэмжээгээр хуваарилахгүй бол болохгүй юм байна гэсэн ийм л зүйл харагдаж байна. Баярлалаа.

Б.Бейсен: Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Би зүгээр нэмэлт мэдээлэл өгөх гэсэн юм. Энэ усны асуудал яригдаж байх үед бид нар нэг төслийг онцгойлон ярихгүй бол болохгүй ээ. Ялангуяа хүн ам ихээр төвлөрсөн Улаанбаатар хот болон бусад аймгийн төвүүд дээр хүн амын цэвэр усны хангамж болон хаягдал усны дахин боловсруулах асуудал нэлээн ахисан түвшинд бид яригдаж төсвийн бодлогоор ч дэмжээд явж байдаг юм. Энэ дотор хамгийн том төсөл яг одоо хэрэгжиж байгаа. АНУ-тай хамтарсан Мянган сорилтын сангаар дамжиж ирж байгаа энэ томоохон төсөл байгаа. Энэ бол нийслэл Улаанбаатар хотын хүн амын цэвэр усны хангамж, хаягдал усыг дахин боловсруулах маш том төсөл хэрэгжиж байгаа. Энэ төслийн хүрээнд одоо суурилагдсан дэд бүтцээр дамжиж цэвэр ус хэрэглэж байгаа болон гэр хороололд худгаар дамжиж хэрэглэж байгаа цэвэр усны бүх цэгүүд дээр тодорхой хэмжээний төслүүд хэрэгжиж байгаа. Гэр хороололд жишээ нь 180 худгийг автоматжуулсан байдаг. Төсөл маань 2026 оны 3 сард ашиглалтад орно. Ингэснээр.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Ингээд Мянганы сорилын сангаас 350 сая доллар, Монгол талаас 111 сая долларын төсөвт өртөгтэй томоохон төсөл явж байгаа. Ингээд хугацаандаа ашиглалтад орсноор нийслэл хотын маань хүн амын цэвэр усны хангамж бол ер нь маш сайн шийдэгдэнэ. Энэ бол маш том үндэсний хэмжээний хөтөлбөр чимээгүйхэн явж байна гэх үү дээ. Иргэд маань энэ талаар бас сайн мэдээлэл байдаггүй юм.

Б.Бейсен: Тэмүүлэн гишүүн асуулт асууя.

Г.Тэмүүлэн: Салбарын төсөв орж ирж байгаатай холбогдуулаад би нэг зүйлийг бас онцолж асуух гэсэн юм.

1 дүгээрт яах вэ, манай хөдөө аж ахуйн салбарын гол үндсэн тулгуур салбар нь мал аж ахуйн салбар. 2 үндсэндээ гол салбар байна. Мал аж ахуйн салбар дээр бид нар өнгөрсөн 3 жилийн хугацаанд яг энэ Байнгын хороонд байгаа бас хуучин гишүүд, манай Батжаргал гишүүн, манай Бат-Эрдэнэ гишүүн, Бейсен гишүүн, Наранбаатар гишүүн гээд бид нар хамтарч байгаад энэ Малчны тухай хуулийг хийсэн юм. Анх удаагаа Монгол Улсын 300 мянган малчид өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалах хуультай болсон. Энэ хууль сая энэ оны 6 сард батлагдсан. Тэгэхээр үндсэндээ яах вэ, зүгээр энэ салбарыг дэмжих төрийн бодлого өөрөө үүгээрээ анх удаагаа гарч ирж байгаа. Энэ магадгүй энэ салбарын чинь хөгжлийн зураглал нь өөрөө энэ хуулиар тодорхойлогдоод байгаа. Цаашидаа магадгүй шинэ яам болон шинэ сайдын ирэх 4 жилийн хугацаанд хийх ажлынх нь бараг гарын авлага болох ийм том бодлогын баримт бичиг болсон шүү. Та нар маань бас энэ дээр бас анхаарч ажиллаарай. Ирэх онд энэ хуулиуд эхнээсээ гол заалтууд хэрэгжиж эхлэх ёстой. Үндсэндээ бол бид нар энэ малчдынхаа боловсролын асуудлыг яах юм бэ. Цаашид энэ малчдынхаа эрүүл мэнд, нийгмийн баталгааг нь яах юм.

Эдийн засгийнх нь баталгааг нь яах юм. Цаашид энэ салбарыг эрсдэлээс хэрхэн хамгаалах юм ч гэдэг юм уу, бүх энэ салбартай хамааралтай, малчин хүнтэй хамааралтай бүх бодлогын зохицуулалтуудыг энэ хууль дээр хийж өгсөн байгаа шүү. Тэгэхээр одоо яам энэ хуулийг хэрэгжүүлэх тал дээр ирэх он дээр тодорхой төсөв, хөрөнгө мөнгийг шийдэх асуудлууд дээр мэдээж хууль гарлаа гарлаа гээд тэрийг хэрэгжүүлэх ёстой. Хэрэгжүүлэхэд төсөв хөрөнгө мөнгө шаардлагатай. Тухайн тэр хуульд тусгасан ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагууд бол байгаад байгаа юм. Тэгэхээр одоо бол энэ дээрээ та нар бас голлож ажиллаарай. Хөдөө аж ахуйн яамны маань бас гол салбар маань мал аж ахуйн салбар шүү. Малчидтай холбоотой эрхийн асуудал.

Дээрээс нь энэ хууль батлагдлаа гээд яамны хийх ажлууд үлдсэн байгаа юм. Холбогдох журмуудыг гаргах хэрэгтэй байгаа юм. Энэ дээр бас хэрхэн ажиллаж байна. Та нар маань ер нь яг энэ голлоод мал аж ахуйн бодлогын газрын дарга нь энэ дээр бас голлоод бариад явж байна уу. Ямар ер нь явцтай байгаад байна. Юун дээр анхаарахаар байгаад байна. Энэ дээр бас.

2-т би нэг зүйлийг бас онцолж хэлэх гээд байгаа зүйл нь Мэндсайхан сайдыг сайд байх үед Хөдөө аж ахуйн яам дээр бид нар бас ярьж байгаад энэ яг хөдөө аж ахуйн салбарын чинь бүсчилсэн хөгжлийг дэмжих үүднээс бид нар яг энэ олон улсын экспортын стандартад нийцсэн тусгаарлах аж ахуй бүхий дэлхийн жишиг махны үйлдвэрүүдийг 4 бүс нутагт байгуулъя гээд Хятадын Засгийн газартай хамтарч гаднын зээлээр хийхээр явж байсан юм. Энэ ажил ер нь ямар шатанд явж байгаа вэ. Бид нар одоо бүсийн хөгжлийг ярьж байна. Тэгэхээр Хөдөө аж ахуйн яам бол нэг талдаа бүсчилсэн хөгжлийг ярихын тулд энэ бүс нутаг болгонд нэг ийм үйлдвэр байгуулах шаардлага байгаа.../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя. Төрийн нарийн хариулъя.

Т.Жамбалцэрэн: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн. Малчны тухай хууль энэ онд батлагдсан. Тэгээд хуулийг хэрэгжүүлэх, хуулийг дагаж гаргах дүрэм, журам, стандартуудыг зохион байгуулах үйл ажиллагааны зардлууд, мал аж ахуйн салбар гэдгээрээ 4 тэрбум төгрөгийн зардал тусгагдсан. Төсөв батлагдсаны дараа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар тодорхой арга хэмжээнүүдийг санхүүжүүлээд явах бололцоотой.

Хууль дээр мал аж ахуйн салбарт оролцож байгаа малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эдийн засгийн тэр баталгааг бий болгох чиглэл дээр олон заалтууд тусгагдсан. Эдгээр заалтуудыг яг хуулийн заалт, зүйл ангиллаар нь аваад үзэхээр уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой, малчны хоршооны агуулгуудтай бас нэлээд зүйлүүд давхцаж байгаа. Дээр нь Монгол Улсын төрийн тэргүүний санаачилсан Хүнсний хангамжийн аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, түүн дотор багтсан мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх, мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг бэхжүүлэх чиглэл дээр тусгагдсан олон зүйл заалтууд бас давхцаж байгаа. Тийм учраас эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэхтэй холбоотой тэр зээл, татаас урамшуулал дэмжлэгүүд бол өмнөх хэлбэрээрээ олгогдоод явна. Аж ахуйн нэгж дээр тэр хөрөнгө оруулалтуудын зардлууд нь тухайн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх тэр зээлийн эх үүсвэрээсээ санхүүжээд, хүүгийн хөнгөлөлт, татаас, урамшуулал нь бол тухайн чиглэлээрээ зардлууд нь гараад явах ийм нөхцөл байдалтай байгаа.

Ж.Энхбаяр: Тэр тусгаарлагдсан, хамгаалагдсан аж ахуйнуудын асуудлыг ярьж байна. Энэ бол зайлиггүй. Махны экспортыг хийхийн тулд заавал тусгаарлагдсан бүс нутаг, энэ маш эрүүл бүс нутгийг бий болгох, тусгаарлагдсан, хамгаалагдсан аж ахуйнуудыг бий болгож байж тэр дээрээ тулгуурласан экспортынхоо чадавхыг хөгжүүлнэ. Энийг мэдээж энэ хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдэх бодлогын их том нэг зүйл маань энэ байгаа юм.

Б.Бейсен: Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр саяын тэр тусгаарлагдсан аж ахуй дээр та нар маань бас анхаарч ажиллаарай. 2 жил гаруй хугацаанд бас өмнөх сайд байхад энэ ТЭЗҮ, зураг төсвийг нь мэргэжлийн байгууллагаар хийлгээд дуусчихсан. Одоо тэгээд энэ яг Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхээр байгаад байгаа. Тэгээд бүс нутгийн хөгжлийг дэмжих үүднээс 4 бүс нутаг дээрээ яг үндсэндээ энэ үйлдвэрийг байгуулахаар ингээд бүх суурь ажлууд нь хийгдчихсэн байгаа шүү. Ингэж байж л цаашидаа бид нар бүтээгдэхүүнийг мал махыг үнэтэй болгох ч гэдэг юм уу, экспортод гаргах ч гэдэг юм уу ийм боломж бололцоо бол бий болох гээд байгаа юм.

2 дугаарт Байгаль орчны яамнаас нэг тодруулж асуух зүйл нь Одонтуяа сайд сая хүр хорхой устгал дээр, модны ойн шавжтай тэмцэх дээр 10 тэрбум төгрөг байгаа гэсэн. Энэ маань яг үндэсний хэмжээнд, улсын хэмжээнд бүх энэ хөнөөлт шавжийн тархалт, голомтыг устгах боломж бололцоо байгаа юм уу. Хангалттай төсөв мөнгө нь яг суусан гэж үзэж байгаа юу. Улсын хэмжээнд, хангайн бүс нутгууд дээр нэлээн бас хүнд байгаа.../минут дуусав/

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя. 2 номер Төрийн нарийн бичгийн дарга.

Э.Баттулга: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Энэ жилийн хувьд энэ хөнөөлт шавжийн судалгааг 2 сая га талбайд хийнэ. Хортон тэмцлийн ажлыг бол 318 мянган га талбайд хийхээр байгаа. Энэ жилийн хувьд Архангай аймгийн Ихтамир, Өндөр-Улаан сумдын нутагт бол жишээлбэл хүр хорхойн идэвхжил бол маш өндөр байсан. Энэ сумдын ой дээр хортон тэмцлийн ажлыг бол бүр нэн тэргүүнд хийнэ. Хоёрдогч хортон орохоос өмнө хийх төлөвлөлттэй байгаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя. Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Хөдөө аж ахуйн сайдаасаа Энхбаяр сайдаас ганц 2 асуулт байна. Сая Идэрбат гишүүн мал эмнэлэгтэй холбоотой асуудлуудыг ярилаа. Яг үндсэндээ Идэрбат гишүүний хэлдэг ч үнэн шүү дээ. Бид нар гадагшаа махаа экспортлож чадахгүй байгаагийн, 70 сая малтай Монгол Улсын мах гадаадад үнэлэгдэхгүй байгаагийн ганц юм чинь ерөөсөө л малын өвчин байхгүй юу даа. Бид үүнтэйгээ би яриад байгаа шүү дээ. Хувьсгал хийх ёстой гэж яриад байгаа. Сая Идэрбат гишүүний тэр хангалтгүй хариулт авлаа гээд байгаа байдлыг хараад байхад бол энэ нь нэг тийм тодорхой хариултыг л та бас хэлж өгөхгүй байна л гээд байна л даа. Тэгэхээр яг ерөөсөө бид нар мал эмнэлэг дээр ямар арга хэмжээ авах юм бэ гэдэг тийм том бүр хувьсгалын хэмжээний түрүүний нөгөө 14 том мега төслийн нэг нь бараг л энэ мал эмнэлгийнхээ асуудал, энэ био технологио сайжруулах асуудал байхгүй юу даа. Тэгж байж бид нар гадагшаа экспортод энэ мал маань гарах юм. Мал нь ч гарна, мах нь ч гарна, түүхий эд нь ч, бүтээгдэхүүн бүгдээрээ л гарах байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бас нэг тодорхой арга хэмжээ аваад цаашаа ажиллаарай л гэж хүсэж байна.

Энэ 70 тэрбум төгрөг Мал эмнэлгийн ерөнхий газар дээр тавигдсан

юм байна. Эндээс яг хэд нь вакцинжуулалтад орж байгаа юм.

2 дугаарт бид нар энэ Байнгын хороон дээрээс урьд нь нэг гарсан тогтоол байгаа шүү дээ. Бид нар ажлын хэсэг гарч байгаад гаргасан. Тэр дээр юу гэж байгаа билээ. Мэдрэмтгий малдаа жилдээ 2 удаа бүх тарилга, био вакцинжуулалтыг хийе гэсэн шүү дээ. Мэдрэмтгий бүх малдаа. Тэгж байж бид нар 5 жилийн хугацаанд энийгээ давтамжтай хийх юм бол энэ малынхаа өвчнөөс ангижрах юм байна гэсэн ийм тодорхойлолтыг Хөдөө аж ахуйн яам урьд нь яам, энэ мал эмнэлгийн газар чинь гаргасан шүү дээ. Тэгээд одоо энэ 70 тэрбум төгрөгөөс яг вакцин дээр хэд юм. Бидний тооцоогоор бол энэ чинь бараг л 100-аад тэрбум төгрөг. Түрүүн чинь бас өөрөө ч хэлчих шиг боллоо. Нэлээн өндөр түвшний мөнгө хэрэгцээтэй болж байж бид нар энэ малынхаа өвчнөөс гарах ёстой. Тэгээд жилийн 2 удаа вакцинжуулах энэ тарилга чинь хэдэн төгрөг шаардлагатай юм. Яг одоо жишээ нь энэ Байнгын хорооноос гарсан тогтоолыг хэрэгжүүлэхэд. Өнөөдөр тавьсан байгаа мөнгө чинь энэ 70-аас хэд нь жишээ нь вакцинжуулалтад хэрэгжүүлэх юм бэ л гэсэн энэ зүйлийг асуух гээд байна.

2 дугаарт хувийн хэвшлийг дэмжинэ л гэж байгаа. Одоо ер нь манай сайд нарын бүгд л амных нь уншлага болоод байна л даа. Хувийн хэвшлийг дэмжинэ дэмжинэ гээд. Яг үндсэндээ бол хувийн хэвслээ дэмжиж байгаа юм харагдахгүй болчихоод байгаа байхгүй юу даа. Бидний лоозон болоод хувирчхаад байна шүү дээ. Тэгэхээр та бол мал аж ахуй дээр ажиллаж байгаа яг туршлагатай хүн. Тэр мал аж ахуй дээр ажиллаж байгаа тэр туршлага чинь яг одоо хажууд чинь дахиад дахиад ингээд борооны дараах мөөг мэт энэ Монгол Улс даяар энэ аж ахуйнууд чинь бий болмоор байгаа байхгүй юу. Яагаад бий болж чадахгүй байна гэхээр ерөөсөө л бид нарт дэмжлэг алга байна шүү дээ.

Мал аж ахуй дээр дэмжлэг алга байна.../минут дуусав/

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүнд 1 минут.

Ж.Бат-Эрдэнэ: Шинэ хөдөө хөтөлбөр гээд л хэрэгжүүлсэн тэр маань Шинэ хоршоо болоод явж байх шиг байна. Яагаад Шинэ хөдөө хөтөлбөр гэж гаргасан юм гэхээр чинь ерөөсөө л хөдөөгийн малчид, тариаланчдыг дэмжлэг үзүүлэе гэж байгаа шүү дээ. Дэмжлэггүй бол тэгээд л 1990 онд бид нар зах зээлд орсон. Яг энэ хэлбэрээр өнөөдөр 30, 40-өөд жил бараг л жил ингээд л явсаар байгаад хүрч ирж байна шүү дээ. 20, 30 жил. Тэгэхээр дэмжлэг хэрэгтэй байхгүй юу даа. Юун түрүүнд дэмжлэг байж байж нөгөө аж ахуйнууд чинь хөл дээрээ босох хэрэгтэй шүү дээ. Тэгэхээр энэ дэмжлэгийгээ ямар хэлбэрээр явуулах юм. Одоо тэр шинэ хоршоо гэдгээрээ яг яаж зохион байгуулах юм та бүхэн маань. Энэ сум суман дээр Монгол Улсыгаа газар зүйн байдлаар харж байгаад аль газар нь орон нутгийн харгалзаж байгаль орчинтойгоо л харгалзаж байгаад, уур амьсгалтайгаа харгалзаж байгаад ямар аж ахуйнууд байх юм. Газар тариалан, мал аж ахуй аль руу нь орох юм. Тэр нь яаж хөл дээрээ босох юм гээд бараг л ч очиж босгож босгож өгөх л хэрэгтэй байхгүй юу даа. Ер нь бол тийм том сургалтыг явуулах том компаничилсан .../минут дуусав/

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Үнэхээр Био комбинаттай холбоотой одоо бид 2 шинэ шугам хүлээж авч байгаа. Энэ арга хэмжээнд Байнгын хорооныхоо гишүүдийг урья. Тэр хүрээндээ бид нар Мал эмнэлгийн ерөнхий газар Монгол Улсын малыг эрүүлжүүлэх бодлогыг иж бүрнээр нь бид нар танилцуулъя. Энд ярихаар 1 минутад ерөөсөө амжихгүй болоод байна. Энийг Бейсен гишүүн ээ,

дарга аа энийг бүгдээрээ зохион байгуулаад, Био комбинаттай танилцаад, үзээд үнэхээр манай их том чадавх шинжлэх ухааны их том суурь судалгааны гол зүйл тэнд бас байгаа. Тэгэхээр энийгээ бүгдээрээ нэг үзэцгээе. Тэр хүрээнд бид нар бодлогоо ярья гэж бодож байна.

Тэр хоршоо нэг хэлбэрээр л энэ малчдаа дэмжсэе гэдэг л бодлого шүү дээ. 5 их наяд их мөнгө. Одоо 1 их наяд дөхөж явна. Ирэх онд 500 тэрбум гарна. Энэ нь өөрөө дотроо 14 төрлийн үйл ажиллагаа явуулахыг дэмжиж зээл олгож байгаа юм. Малчдыг. Тэжээл тарихаас авхуулаад л дахин боловсруулах цех байгуулах, тоног төхөөрөмж, зоорь, хөргүүр, мал үржүүлэг, мал эмнэлэг, гахай, шувуу, зөгий, туслах аж ахуй эрхлэх, ингээд л усан хангамж, хөв цөөрөм, уст цэг гаргах, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн цех, тоног төхөөрөмж авах, мал бордох аж ахуй байгуулах эд нар гээд тус тусад нь биш. Гол нь хөдөлмөрийн зохион байгуулалт. Хамгийн доод 9 өрх нийлж байж 1 хоршоо болно. Нэг иргэнд очих дээд хэмжээ 50 сая, ингээд 300-500 сая дотор хоршоонд эх үүсвэр очоод байгаа юм. Тэр 300-500 сая төгрөгөөрөө малаа үржил селекцээ анхаарна уу, хамтраад худаг усаа гаргана уу, хамтраад хадлан тэжээлээ бэлдэнэ үү, энэ нь өөрөө яг энэ чиглэлээр л зээл олгож малчид өөрсдөө бас төсөл бичиж өгч байгаа. Манай хоршоо тэжээлийн таримлаа нэмнэ. Манай хоршоо ийм цех байгуулна гэж. Тэр дээр нь арилжааны банк хяналт шалгалт хийгээд зээлээ өгч байгаа юм. Эрсдэлээ арилжааны банк хариуцаж байгаа. Тэгэхгүй төр очиж энэ үйл ажиллагаа, аж ахуйн ажилд оролцохыг аль болох хязгаарлаж байгаа. Мэдээж сая Засгийн газраар нэг ийм асуудал шийдэгдсэн. Шадар сайд Амарсайханаар удирдуулсан хоршоог хариуцсан Үндэсний хороо байгуулж байгаа буюу хоршооны зохион байгуулалтын асуудлыг Шадар сайд Амарсайханд Засгийн газраас

хариуцуулсан шүү. Энэ Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөдөлгөөнийг удирдан зохион байгуулах онцгой бүрэн эрхийг Шадар сайдад олгож илүү ач холбогдлыг нь өндөрт өргөж байна гэсэн үг шүү дээ. Өндөр өргөж, улсын хэмжээний зохион байгуулалтыг хангахыг ийм үүрэг өгөхдөө явж байгаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ шинэ хоршоогоо Энхбаяр сайд аа, бүр зохион байгуулалттайгаа шиг зохицуулсан нь дээр. Төр энд орохгүй гэж байгаад ингээд хаях юм бол энэ чинь дахиад үргүй зардалтай холбоотой, үргүй зардалтай, үргүй, үр ашиггүй ийм ажил болоод өнгөрнө шүү. Тийм болохоор та яг энэ индрийнхээ ар дээрээс микрофоны ар дээрээс ярьж байгаатай адилхан ярьж байгаатай адилхан мал аж ахуйгаа яаж хөгжүүлэх юм, ямар ямар зүйл байх юм, ямар төрлийн мал үржүүлэх юм, ямар үр ашигтай байх юм, тэгээд тэрний аманд нь хийдэг тэжээлийг нь хэн боловсруулах юм эд нар гээд схем яриад байна шүү дээ. Энэ схемийгээ тэнд очиж гаргаж өгмөөр байгаа байхгүй юу. Тэгж байж танайд тэдэн аж ахуй байх ёстой. Энд тохирсон төдий хэмжээний хадлан тэжээл бэлддэг аж ахуй байх ёстой. Энд зориулсан бордоо, тэжээл бэлддэг аж ахуй байх ёстой гээд зохион байгуулаад өгөхгүй бол хөдөөгөөр явахад яг наадах чинь дутагдаж байгаа шүү. Тийм болохоор ерөөсөө маш замбараагүй байгаа. Зүгээр хэн чадаж байгаа нь нэг зээл авангуут л нөгөө банк нь панк гээд л цохиж өгөөд л заримд нь өгөөд л, заримд нь өгөхгүй.../минут дуусав/

Б.Бейсен: Мэндсайхан гишүүнд асуулт асууя.

З.Мэндсайхан: Хөдөө аж ахуйн салбарын өрсөлдөх чадвар гэхээр яалт ч үгүй малын эрүүл мэндийн асуудал байгаа юм л даа. Тэр мал, мах, арьс шир, ноос ноолуур гээд. Тэгээд бид нар хөнгөн

үйлдвэрийг дэмжих үндэсний “Цагаан алт” хөтөлбөрийг боловсруулахдаа би өөрөө бас зовлонг нь мэдэх хүний хувьд энэ Био комбинатын шинэчлэлийг улсын төсвөөр хийнэ гээд энэ хөтөлбөр дээр суулгаад, Их Хурлаар баталчихсан. Тэгэхээр энэ дээр яам маань яаж анхаарч байна. Одоо хэдүүлээ энэ малынхаа эрүүл мэндийн асуудлыг шийдэхгүй бол жилдээ ингээд улсын төсөв дээрээс 30 хэдэн тэрбум төгрөг суулгаж аваад, вакцин худалдаж аваад яваад байдаг чинь бол цаашидаа бид нарын малын эрүүл мэндийн өрсөлдөх чадварт бол тийм дорвитой өөрчлөлт авчрахгүй нь гэдэг асуудал байна.

2 дугаарт хөдөө аж ахуйн салбар дээр тусгай Цагаан алт, Шинэ хоршоо гээд хөтөлбөрүүд маань явж байна. Үүний цаана нөгөө Зээлийн батлан даалтын сангийн чинь активын асуудал юу болж байна. Өнгөрсөн жил 300 хэдэн тэрбум гараад явчихсан гэж байгаа. Одоо энэ Зээлийн батлан даалтын сангийн активыг нэмэгдүүлэхгүйгээр зээл цаашиаа гарах энэ боломж чинь хумигдана шүү гэдэг дээр ямар арга хэмжээ авсан бэ. Ер нь бол хөдөө аж ахуйн салбар бол Монгол Улсын тэргүүлэх салбар. Өнгөрсөн 2 жилийн хугацаанд зуд байгалийн цаг уураас болоод эрсдэлд орлоо гээд яриад байгаа. Тэгээд энэ салбар дээр ямар ч хөрөнгө оруулалт тавигдахгүй байна. Тэгээд энийг бид юу гэж ойлгох вэ.

Мал аж ахуйн салбар маань уналттай байна гэххэд энийгээ ямар нэгэн хөрөнгө оруулалтын бодлогоор ерөөсөө дэмжиж өгөхгүй байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийг Энхбаяр сайд аа цаашидаа бид нар ерөөсөө улсын төсөв дээрээс эргэн төлөлтөөр нь 50 тэрбумын л төсөв тавиад яваад байгаа шүү дээ. Сангийн яам бол 50 тэрбумыг тавиад, энэ нь бол эргэн төлөлтөөрөө төлөгдөөд цаашиаа явах төсөв гэж байгаа. Түүнээс биш улсын төсвөөс татаас очихгүй байгаа. Тэгэхээр Жижиг, дунд үйлдвэрлэлээ ерөнхийдөө энэ зээлийн

хүүгийн татаас руу шилжүүлээд, арилжааны банк руу шилжүүлээд явбал яасан юм бэ. Тэгвэл энэ 50 тэрбум чинь өөрөө бараг 500 орчим тэрбум төгрөг гарах зээлийн хүүгийн татаас болчихно шүү дээ. Бид нар 50 тэрбумыг эргэн төлөлтөөр гэхчээд 20, 30-ийг цуглуулаад буцааж тарааж байхаар энэ систем рүү нь оруулаад явах өөрчлөлтийг хийгээч гэж нэг хүсэлт байна.

Энэ газар тариалангийн бүс нутаг дээр одоо газар тариалангийн үйлдвэрлэл дээр манай газар тариалангийн нийт орцын чинь бараг ихэнх нь импортоор байгаа шүү дээ. Тэгээд нөгөө улаан буудайныхаа өртөг өсчихсөн байгаа. Тэгээд гурилын үнийн асуудал гээд бид нар ийм зах зээлийн жамаараа явчих юман дээр л их оролцоод байна. Тэгэхээр улаан буудай өртөг бууруулах чиглэл дээр импортыг орлох тал дээр Атрын 4 дүгээр аяны хүрээнд ямар ажлууд хийгдэх гэж байна. Ялангуяа үрийн шинэчлэл, хөрс хамгааллын чиглэлдээ бид нар анхаарахгүй бол дотоодынхоо хэрэгцээг хангана, хангахгүй гэдэг ийм уралдаан шиг юман дээр явж байгаад энэ салбарын маань үндсэн тэр хөрсний асуудал үр шинэчлэлтийн асуудлууд маань технологийн шинжтэй юмнууд маань хаягдчих вий дээ. Энэ дээр ямар арга хэмжээ авч байна.../минут дуусав/

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн гүйцээж асууя.

З.Мэндсайхан: Хөдөө аж ахуйн салбарын татаасны хэмжээ нэмэгдчихсэн байна гээд хүмүүс яриад байгаа юм. Тэгэхээр энэ татааснуудаа бид нар шилэн болгохын тулд ойлгомжтой болгох хэрэгтэй байна. Биржийн үйл ажиллагаагаа бид нар илүү оновчтой болгомоор байна. Малчид маань үйлдвэрүүд рүү арьс шир, ноос ноолуур гээд нөгөө 5 төрлийн урамшуулалтай бүтээгдэхүүнээ нийлүүлээд, нийлүүлснээ тэр арилжааныхаа гүйлгээгээр дамжуулаад шууд юугаа авчихдаг баймаар байна.

Урамшууллаа. Тэгэхгүй бол малчид маань нөгөө А данс бүрдүүлээд үйлдвэртэйгээ тулгана. Нөгөө ноос ноолуур, арьс ширний холбоо нь тулгана гээд нэг ийм хоцрогдсон бүгд цахимжаад л юм яриад байгаа шүү дээ бид нар. Ингээж явсаар байгаад малчид маань татаас авч чадахгүй буюу энэ урамшууллаа авч чадахгүй хугацаа алдаад байна. Энэ нь өөрөө сайдын зохицуулалт нь ороод хойшоо ороод явчихдаг. Тэгэхээр энийг биржийн арилжаатай уяж өгмөөр байна. Мөн тэртээ тэргүй бид нар үндэсний үйлдвэрлэл нөгөө талдаа хоршооллын бодлогоо дэмжиж байна. Одоо малчид маань түүхий эдээ биржээр дамжуулаад арилжаалахад урамшуулал нь шууд ордог энэ механизмыг бүрдүүлж өгмөөр байна.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Та их зүйтэй саналууд гаргаж байна. Үнэхээр бирж өөрөө хөдөө аж ахуйн гол идэвхжүүлэгч болно. Энэ дээр нь сүүн дээр нэг ийм эвтэйхэн жишээ бас овоо жигдрээд байгаа. Сүү тушаалаа, үйлдвэр хүлээж авлаа, урамшууллын литрийн I мянган төгрөг панк гээд л дансанд нь ордог болчихсон. Энэ мэтчилний ноолуур овоо цэгцэрсэн. Түүрүүн хэллээ үр тариан дээр ажил ахиц гарч байна гээд. Энийгээ бол улам бид нар төгөлдөржүүлээд, цахим ерөөсөө цахим хөдөө аж ахуйн хүрээнд цахим малчин, цахим тариачин, цахим фермер, цахим газар тариалан гэсэн бүх зүйл цахим. Мэдээлэл ил тод бүх талаас оролцогч ашиглах бололцоотойгоор ингээж дэд бүтцийг нь бий болгож байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар дээр улсын төсвөөс хөрөнгө оруулалт байхгүй. Жижиг, дунд үйлдвэрийн газар маань өөрөө нөгөө өмнөх зээлийн үлдэгдэл, эргэн төлөлтөөсөө үйл ажиллагаагаа санхүүжүүлээд, тодорхой хэмжээний эх үүсвэр гаргаад л ингээд л явж байна. Гол нь Жижиг, дунд үйлдвэрийн бизнесийг туслах, дэмжих

зах зээлийг нээх, үзэсгэлэн худалдаануудыг зохион байгуулах, олон улсын арга хэмжээнд оролцох чиглэлд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр явж байна.

Зээлийн батлан даалтын сан дээр 2025 онд 50 тэрбум тавигдсан. Энэ нь бас 300-аад, 400 тэрбумын зээл дээр батлан даалт үүсгэх бололцоог бий болгоно. Био комбинат үнэхээр бид нар хөтөлбөртөө оруулсан. Энэ бол Улсын Их Хурлын тогтоолтой, хуульчилсан хөтөлбөр. Тэгээд санхүүжилтийн асуудал ердөө яаж шийдэх вэ гэдэг Сангийн яамыг л би хариулаасай гэж бодоод байна. Ер нь явж явж салбарын олон юм Сангийн яам дээр очоод л үгүйсгэдэг, хойшлуулагддаг, эрэмбэлэгддэг зүйл байгаа шүү дээ. Тэгэхээр Сангийн яам заримдаа Хөдөө аж ахуйн яамны ажлыг их хийгээд байгаа зүйл бий л дээ. Мэдэж шийдээд байгаа зүйл. Бас төсөв, санхүү нь болохгүй л байгаа байх. Тэгэхээр энэ Сангийн яам, сайд хариулна биз дээ. Энэ Биокомбинатыг яах юм бэ гэж. Үндсэндээ Монголын хөдөө аж ахуй, малчдын амьдралыг сайжруулах, орлоготой байхын тулд экспорт хэрэгтэй. Экспорт байхын тулд бид нар мал эмнэлгийн салбар маш сайн байх ёстой. Олон улсын чанартай түвшинтэй үйлчилгээ үзүүлэх хэрэгтэй. Тэгэхийн тулд чанартай эм бэлдмэл, вакцинаар бид нар хангах ёстой. Ингээд л био комбинат суурин асуудал нь байхгүй юу. Тэгэхээр Жавхлан сайд гараад явчихсан юм байна. Ганбат Төрийн нарийн бичгийн дарга нь хариулна биз. Ерөөсөө явж өгөхгүй байгаа. Тэгээд бид бол олон улсын зээл хөтөлбөр лүүгээ л хөөцөлдөнө дөө. Санал тавина.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн тодруулах юм байна. Ганбат хариулах юм уу. 7 номер. Сангийн яаманд Төрийн нарийн бичгийн дарга.

Ж.Ганбат: Асуултад нэмэлт байдлаар яриулъя. Яах вэ, Сангийн яаман дээр гацаж байгаа, Хөдөө аж ахуйн

яамны ажлыг энэ тэр хийж байгаа юм бас байхгүй л дээ. Бид үнэхээр Хөдөө аж ахуйн салбар дээр анхаарч байгаа шүү дээ. 500 гаруй тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг өгч байна. Төсвийг нь 180 хэдэн тэрбумаар нэмлээ гээд л Байнгын хороод дээр саяхан л яригдаад л бид бол онцгой анхаараад манай гол салбар бол хөдөө аж ахуй ийм байгаа.

Био комбинатын хувьд бол Био комбинатын төсөл бол 100 сая ам.долларын төсөл нь Дэлхийн банкнаас яригдаж байгаад Хүнс, хөдөө аж ахуйн яам өөрөө төслийн дизайнаа Дэлхийн банктэй тохиролцож чадахгүй юм байгаа юм шүү дээ. Бодит үнэ нь энэ байна. Дэлхийн банктэй Хүнс, хөдөө аж ахуйн яам төслийнхөө дизайнаа тохиролцож чадаагүй байгаа ийм юм байна.

Нөгөө талдаа Унгарын компани 57 сая ам.долларын гэрээ байгуулаад, ажлаа эхлүүлээд явж байгаад шүлхийн.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж яриулъя. 7 номер.

Ж.Ганбат: Мөн Унгарын компани тэр 57 сая ам.долларын гэрээ байгуулаад, ажлаа эхлүүлээд явж байгаад шүлхийн вакцины технологи юмаа мэдэхгүй байна гээд өөрсдөө гэрээгээ цуцлах хүсэлтээ ирүүлээд энийг нь бол больсон. Энэ дээр гол асуудал нь 40 сая ам.долларыг Био комбинат биш өөр зориулалттай бас дамжуулан зээлдүүлэх нөхцөлтэй Хөдөө аж ахуйн яам дэмжихгүй байгаа бас ийм асуудлууд байгаа юм байна лээ. Яг бодит үнэн нь. Тэрнээс биш Сангийн яам энэ дээр гацаагаад, саатуулаад байж байгаа юм бол байхгүй л дээ. Нөгөө талдаа тэр хөрөнгө оруулалт, юун дээр яах вэ, Хөдөө аж ахуйн яам дээр шилжих хөрөнгө оруулалт Улсын төсөв дээр 44 тэрбум төгрөг гаднын зээл, тусламжаар зээл тусламжийн ашиглалтын дүн нь 27 төгрөг төгрөг байгаа. Нийтдээ орон нутгийн хөгжлийн сангийн бас хөрөнгө

оруулалт 2025 онд аймгууд дээр 599 тэрбум төгрөг байгаа. Энэ бол дийлэнх нь орон нутагтаа бол хөдөө аж ахуйн чиглэл энэ тэр юмнууд дээр бол зарагдаад явдаг ийм хөрөнгө оруулалт юмнууд бол байгаа.

Б.Бейсен: Мэндсайхан гишүүн тодруулъя.

З.Мэндсайхан: Тэгээд энэ миний асуугаад байгаа юм Биокомбинат гаднын зээл тусламжаар явна гээд бид нар бол янз бүрээр оролдоод болохгүй байгаа шүү дээ. Унгарын компанийг чинь барилгын компани шалгарчихсан. Био технологийн үйлдвэр дээр барилгын компани хийх гэж байсан учраас тухайн үед цуцлаад явж байсан санагдаж байна. Тэгэхээр одоо Их Хурлаар баталчихсан хөтөлбөр дээр улсын төсвөөр хийнэ гээд Биокомбинатыг шинэчилнэ гээд тусгачихсан байгаа. Тэгэхээр Их Хурлаар баталсан тэр хөтөлбөрийг юу гэж үзээд байна. Тэр бол тэгээд тунхаг төдий юм гэх гээд байгаа юм уу.

2 дугаарт ЖДҮ дээр мөнгө тавигдаагүй гэж байна. Энхбаяр сайд аа, энийг яагаад энэ Шинэ хоршоо, Цагаан алт хөтөлбөрийнх шиг болгоод явуулж болохгүй байна. Жижиг, дунд үйлдвэрлэл дээр чинь 20-30 тэрбум төгрөг буцаад төвлөрнө, эргээд аймгууд руу 1, 2 тэрбум л хуваарилагдаж очиж байгаа байхгүй юу. Тэр чинь 2, 3 л аж ахуйн нэгжийн асуудал. Тэгэхээр Жижиг, дунд үйлдвэрлэлийн чинь хөгжлийн асуудал, хөрөнгө оруулалтын асуудал хаягдаад байна. Цагаан алт хөтөлбөр дээр зээлийн батлан даалтын санг уяж өгөх боломж байна уу.../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Төсөв өргөн баригдсан Зээлийн батлан даалтын сан тэрбумаар дүрмийн сан нэмж байгаа. Жижиг, дунд үйлдвэр дээр тоо байхгүй. Хөрөнгө оруулалт байхгүй. Тэгэхээр энэ хүрээндээ л бид нар үйл ажиллагаа зохицуулна шүү

дээ. Өөрөө энэ хэрэгжиж байгаа Цагаан алт, Хүнсний хувьсгал, Атрын 4 чинь том жижиг гэж ялгахгүйгээр ногоочин байсан ч жижиг жимс ногооны төгөлтэй байсан ч энэ зээл очиж байгаа. Өмнө бол жижиг, дунд үйлдвэрлэл гээд нэг тийм бодлого 10-аад жил явж байгаад салбарын ийм том бодлого ороод ирэхээр үндсэндээ энэ нь өөрөө жижиг дундаа шингээгээд л явчхаж байна гэж бүгдээрээ ойлгоё. Тэгэхгүй бол тусад нь жижиг дунд гээд авахаар тэд нарт зориулсан бас нэг эх үүсвэр гарах нь зохисгүй. Нэгэнт ийм том эх үүсвэр төсвөөс гарч байгаа болохоор энэ хүрээндээ зохицуул гэдгээрээ л явж байна гэж ойлгоод.

Био комбинат дээрээ ингээд бас л нэг мөр тохирох хэрэгтэй байгаа юм. Улсын төсвөөр явна гэвэл хүлээгээд л ирэх онд төсвийн санал дээр оруулаад нэг зүтгэе. Эсвэл олон улсын зээл тусламжаар явна гэвэл тэр дээрээ санал нийлээд л зээл тусламж руугаа явъя гэдэг. Тэгэхээр энэ.../минут дуусав/

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.5-д заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд гишүүн нам, эвслийн бүлэг, төрийн аудитын төв байгууллага саналаа зарчмын зөрүүтэй саналын хамт гаргана гэж, мөн хуулийн 39.14-д гишүүн зарчмын зөрүүтэй саналаа хэлэлцүүлэг явуулахаас ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр урьдчилан ирүүлсэн байна гэж заасан.

Дээрх хуулийн холбогдох заалтуудын дагуу Байнгын хорооны гишүүдээс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаар санал ирүүлээгүй байна. Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн

Жигжсидийн Батжаргал Төсвийн
байнгын хорооны хуралдаанд
танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

12.14 цаг.

Дараагийн асуудалд орёе.
Өвөлжилтийн бэлтгэл ажил ургац хураалтын явц байдлын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсьё.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр, Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн, Газар тариалангийн бодлого хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ, Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Наранчулуун, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Дондогдорж, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Нарантуяа. Нарантуяа ирсэн үү. Асуултад хариулах хүмүүс тэр дугаартай саналууд дээр суугаарай.

Сайдын мэдээлэл сонсьё.

Ж.Энхбаяр: Байнгын хороон дарга, Их Хурлын эрхэм гишүүд ээ,

1.Ургац хураалтын урьдчилсан дүнгийн талаар:

Газар тариалангийн салбарын технологийн үйл ажиллагааг хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр

олон ажил, арга хэмжээг хэрэгжүүлж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллалаа.

2024 оны 10 дугаар сарын 19-ний байдлаар 405,3 мянган тонн үр тариа, үүнээс улаан буудай 397,6 мянган тонн, 239,1 мянган тонн төмс, 221,2 мянган тонн хүнсний ногоо, 160,7 мянган тонн тэжээлийн ургамал, 56 мянган тонн тосны ургамал тус тус хурааж аваад байна.

Хураасан ургацын хэмжээг өмнөх онтой харьцуулахад улаан буудай 12,6 хувиар буурлаа. Тосны ургамал 1,3 хувь, төмс 33,3 хувь, хүнсний ногоо 14 хувиар тус тус өсөж нэмэгдлээ.

Намрын ургац хураалтаас стратегийн нөөцөд Хөдөө аж ахуйн корпорац төрийн өмчит компанид 38,2 мянган тонн, 8 нэр бүхий гурилын үйлдвэрт 134,92 мянган тонн, нийтдээ 173,16 мянган тонн хүнсний улаан буудай нийлүүлэгдээд байна.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хүрээнд арилжааны 10 банкнаас жимс, хүнсний ногооны тариалан эрхлэгч 400 иргэн, аж ахуйн нэгжид 20,5 тэрбум, газар тариалангийн үйлдвэрлэгч 486 иргэн, аж ахуйн нэгжид 91,3 тэрбум, нийтдээ 111,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, хаврын тариалалт, урини боловсруулалт, ургамал хамгаалах ажлыг технологийн хугацаанд явуулах, ургац хураалтын бэлтгэл ажлыг хангах боломжийг бүрдүүлээ.

Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтыг сайжруулах, техник технологийн шинэчлэл хийх зорилгоор тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд 137 иргэн, аж ахуйн нэгжид 3,9 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлсний үр дүнд төмс, хүнсний

ногооны 1200 га талбайн ажлыг механикжуулах боломжоор хангагдлаа.

2.Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай:

Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 02 дугаар албан даалгавар гаргаж, хэрэгжилтийг нь хангах ажлыг зохион байгуулагдаж байна. Аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүй нөөцөд энэ оны 10 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 9.0 мянган тонн өвс, 4,2 мянган тонн тэжээл бэлтгэгдсэн. Өвсний нөөц бүрдүүлэлт 48,6 хувьтай, тэжээлийн нөөц бүрдүүлэлт 34,1 хувьтай явагдаж байна.

Хадлангийн нөөц дутмаг говийн бүс аймгуудад өвсний нөөц бүрдүүлэх худалдан авалтын ажлыг зохион байгуулж байна. Худалдан авалтууд ирэх сарын 15-ны дотор бүрэн дуусаж, өвсний нөөц бүрдүүлэлт хангагдах бололцоотой байна. Өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлтийг аймгаар нь авч үзвэл Булган, Дархан-Уул, Говьсүмбэр, Дорнод, Орхон, Ховд аймгууд 70-аас дээш хувьтай, Баянхонгор, Хөвсгөл аймагт 50-70 хувьтай, бусад аймгууд 50 хүртэлх хувийн биелэлттэй явагдаж байна.

Улсын хэмжээнд 2024 онд 93,7 мянган га талбайд малын тэжээл тариалж, 160,7 мянган тонн малын тэжээлийн ургамал хураан авагдаад байна. Ингэхдээ тоо нь эцэслэн гараагүй. Эд хураалт бас дуусаагүй явагдаж байна гэж ойлгоорой. Үр тарианы үйлдвэрлэлээс нийт 87,8 мянган тонн улаан буудай малын тэжээлд шилжих урьдчилсан төлөв гарч байна.

3.Мал, мах бэлтгэл, нөөцийн талаар:

Монгол Улс хүн амын махны хэрэгцээг дотооддоо 100 хувь хангаж байна. Монгол Улсын нийт хүн амын 2024 оны хүнсний хэрэгцээнд нийт 122,6 мянган тонн, 2025 оны хүнсний хэрэгцээнд 124 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн шаардлагатай боловч бодит хэрэглээ 2,7 дахин их байна.

Монгол Улсын мал сүргийн тоо 2015-2023 онд дунджаар 2,6 хувиар өсөж, 2023 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 64,681.8 мянган толгой, 2024 онд 15,4 сая төл хүлээн авч бойжуулсан. Малын зарлага хорогдлыг хасаад 2024 оны хагас жилд 66 сая 872 мянган толгой мал тоологдоод байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны урьдчилсан тооцооллоор 2024 оны өвлийн улиралд нийт 10 сая толгой малыг хүнсэнд хэрэгцээлж, 6 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд буюу экспортод гаргахаар байна. Монгол Улс 2024 онд 6 сая 67 мянган толгой мал буюу 202,9 мянган тонн малын мах экспортлох боломжит нөөцтэй байна.

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасны дагуу нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга нар авч хэрэгжүүлэхээр заасан төдийгүй Засгийн газрын 2023 оны журам батлах тухай 344 дүгээр тогтоолоор стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг баталж, стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан. Үүний биелэлтийг мөн яам гаргаж ажиллаж байна.

4.Малын эрүүл мэндийн талаар:

Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ технологийн

дагуу хэвийн хэрэгжиж байна. 2024 онд 20,6 тэрбум төгрөгөөр, нийт 51,7 сая тун вакциныг худалдан авч малын вакцины нөөцийг бүрдүүлсэн. Малын вакцинжуулалт болон бусад арга хэмжээ 83 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Одоо эд намрын вакцинжуулалтын ажил орон нутагт явагдаж байна. Малын гоц халдварт шүлхий, бог малын мялзан, үхрийн арьс товруутах өвчнөөс сэргийлэх вакциныг импортоор хонины цэцэг болон бусад 6 нэр төрлийн халдварт өвчин болон архаг халдварт өвчин бруцеллёз өвчнөөс сэргийлэх вакциныг дотоодын био комбинатаас малын эрүүл мэндийг хамгаалахад ашиглаж худалдан авч байна.

Хэдийгээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ хийгдэж байгаа хэдий ч 2024 оны эхний 10 сарын байдлаар мал амьтны гоц халдварт 3 нэрийн өвчний нийт 100 голомт бүртгэгдээд байна. Үүнийг өмнөх онтой харьцуулахад голомтын тоо 2 дахин, хамрагдсан аймаг сумдын тоо 1,6 дахин, өвчилсөн малын тоо 2,1 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Өнөөдрийн байдлаар мал, амьтны гоц халдварт өвчний улмаас нийт Дорноговь аймгийн 2 сумд 2 голомтод хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм үргэлжилж байна. Өвчний дэгдэлтийг зохиох, ариутгах, халдваргүйжил хийх зэрэг шаардлагатай арга хэмжээг Мал эмнэлгийн ерөнхий газар, аймаг, сумдын мал эмнэлгийн байгууллагуудтай хамтран шуурхай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Илтгэж дууслаа. Асуултад хариулахад бэлэн.

Б.Бейсен: Энхбаяр сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн нэрсээ өгнө үү. Мэндсайхан гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой мэдээлэл сонслоо. Мэдээж энэ бол технологийн цаг хугацаатай ажлууд. Тодорхой нааштай үр дүнгүүд байгаа гэдэгт би итгэл дүүрэн байна. Тодруулмаар зүйлүүд байна.

Хаврын гурилын импортын татвар тэглэсэнтэй холбогдоод тарих талбай хурааж авсан ургац буурчихсан. Тэгээд хураагаад авчихсан 367 мянган тонн улаан буудайн борлуулалтын явц 100 гаруй мянган тонн улаан буудай борлогдоогүй байгаад байгаа юм билээ. Үүнийг борлуулах чиглэлээр ер нь ямархуу бодлого чиглэл, судалгаа дүгнэлтүүд гараад байгаа юм. Орон нутгуудаас ирж байгаа мэдээлэл дотор бол гурилын үйлдвэрүүд 1, 2 дугаар ангиллын будаагаа авчхаад 3, 4-өө авахгүй байгаа тухай ярьж байгаа. Өөрсдийнх нь элеватор дүүрсэн. Тийм учраас бид авахгүй гээд. Жишээ нь Төв аймаг гэхэд улаан буудай 80 орчим мянган тонныг хураасан байна. Өөрийнхөө үрийн нөөц, тэжээл, гурилын үйлдвэрүүд, корпорац гээд бүгдийг нь нийлүүлээд үзэхээр 30 орчим мянган тонны борлуулалт буюу технологийн нөөц бол бий болгосон байна. Тэгэхээр цаана нь 50 орчим мянган тонн будааны борлуулалт хийгдээгүй байгаа юм байна. Энэ дээр ямархуу арга хэмжээ авч хэдүүлээ энэ тариаланчдын бий болгосон бүтээгдэхүүн баялгийг зохих ёсоор нь зөв зах зээлд эргэлтэд оруулах ёстой вэ гэж нэг ийм зүйл байна.

2 дахь зүйл ногоон тэжээлийн тариалалтын асуудал нэлээн явагдаад байгаа юм. Ерөнхий бүх юмаа харахаар зэрэг нийт газар нутгийн 30 гаруй хувь нь бэлчээрийн газрын шүү дээ. Тодорхой хэмжээний даац хэтрэлт нэлээн давамгайлчихжээ. Энийг дагаж бас тодорхой хэмжээний өвөлжилт, хаваржилтад хүндрэх нь гээд ингээд яриад байгаа. Тэгэхээр энэ бүс нутгууд руу тэжээлийн байрилын асуудлыг ямархуу байдлаар бодлого зохицуулалт юмнууд хийгдэж байна вэ. Хэт

оройтчихвол бас тээвэр логистикийн тал дээр нэлээн хүндрэл үүсээд байдаг. Тэгэхээр зэрэг жоохон гайгүй байгаа цаг үед нь энэ тэжээл байршуулалтынхаа асуудлыг ямархуу байдлаар авч хэрэгжүүлэх гэж байна вэ гэж нэг ийм зүйл байна.

3 дахь хэлмээр байгаа зүйл хаврын тэр гаргасан шийдвэрийг та цуцлуулах санал боловсруулаад яваад байсан. Энэ ер нь ямар шатдаа явна вэ.

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя. 1 минут.

Ж.Батжаргал: Зүгээр баруун бүс нутагтаа бол яах аргагүй малын тэжээл, гурилыг тухайн бүс нутгийн боомтуудаар нь тодорхой гаалийн тарифын хөнгөлөлттэй оруулж ирээд, энэ бүс нутгийн тухайлсан бүтээгдэхүүнүүдийн тээврийн зардлын өсөлтийг буулгах боллоо байгаад байгаа юм билээ. Би бол тэгж хардаг юм. Тэгээд үүнийгээ шийдээд, бусад бүс нутагтаа бол энийгээ зөв зохицуулж байж энэ газар тариалангийн анхдагч үйлдвэрлэлээ тэгээд бий болгосон тэр боловсруулах үйлдвэрүүдээ хамгаалах, дотоодынхоо хүнсний хангамж аюулгүй байдлыг бий болгох асуудал дээр бид нэлээн том байр суурь барихгүй бол энд нэг асуудал хүнд байна гэж.

Дараагийн нэг зүйл мах бэлтгэлийн асуудал байгаа юм. Ерөөсөө өвлийг хорогдол багатай эрсдэл багатай чарга дээр мал хоргодолгүй гаръя л гэвэл малаа ангилж байж мах бэлтгэлтэй явуулж байж сая энд жоохон үр дүн гарах ёстой. Тийм учраас энэ чиглэлээрх ажлуудыг.../минут дуусав/

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Гурилын татварыг тэглэсэнтэй холбоотойгоор энэ салбарт нэлээн цохилт, нөлөөлөл, доргилт үүссэн. Нийт хаврын тариалалт 56 мянган га-

аар огцом унасан. Харин байгаль, цаг уурын таатай нөхцөл бүрдсэнтэй холбоотойгоор ургацаараа нэлээн нөхчихлөө. Хэдий нөхсөн хэдий ч бас ноднингийнхоо түвшинээсээ 12,6 хувиар нийт ургацын дүн уначихлаа. Засгийн газраар асуудлыг оруулаад хэлэлцүүлсэн. Хөгжлийн яам, Сангийн яам, Хууль зүйн яам бүгд дэмжсэн. Ийм санал өгсөн. Их Хурлын дарга дээр асуудлыг танилцуулсан. Их Хурлын дарга ажлын хэсэг гаргасан Баярбаатар гишүүнээр ахалсан ажлын хэсэг гаргасан. Газар тариалангийн бүс нутаг аж ахуйн нэгжийн салбарт бүх оролцогч нартай нь очиж уулзсан. Уулзах нөхцөл бололцоог яам хангаж өгсөн. Ажлын хэсгийнхээ дүнг хүлээж байна. Ажлын хэсгийн дүн юу гэж гарахаас шалтгаалаад цаашидаа асуудал өрнөх болов уу гэсэн бодолтой. Нөөц 25 тэрбумын эх үүсвэр тавигдсан. Хэдийгээр хөтөлбөр 100 тонныг авах бол улаан буудайн нөөц бүрдүүлэх ёстой боловч бид 25 мянган тонноос илүү авч чадахгүй байна. Тэгэхээрээ цаана таны хэлдэг улсын хэмжээнд 100-аад мянган тонн улаан буудайн борлуулалт хүлээгдэж байгаа. Энийгээ бас чанар ангиллаар нь үзээд 87,8 мянган тонн улаан буудай малын тэжээлд, тэжээлийн үйлдвэрлэл, гахай, тахиа, сүүний аж ахуйнууд шилжих ийм багцаа гарч байна.

Нэгэнт татварын асуудал, дээрээс нь эх үүсвэр хязгаарлагдмал байгаа болохоор гурилын үйлдвэрүүд болон сан хамгийн өндөр чанартай, цавуулагтай, натур сайтай энэ улаан буудайгаа сорчлоод худалдан авалтыг үндсэндээ хийгээд, байгаа нөөцийн хэмжээндээ татан авалт хийчхээд байна. Тэгэхээр энэ үлдэж байгаа будаа үндсэндээ юу руу явна л гэсэн үг. Малын тэжээлийн нөөц рүү шилжих байх аа.

Тэжээлийн таримал их сайжирсан, нэмэгдсэн. Энэтэй холбоотойгоор байгалийн хадлангаасаа илүү таримал тэжээлийн нөөцүүд улсын хэмжээнд

нэлээн бодитой масс үүслээ. Ингээд төв, орон нутаг өөрөө энэ өвс тэжээлийн аюулгүй нөөцийг татах, өөрөө төсөвтөө энэ эх үүсвэрээ суулгадаг болоод явж байгаа юм байна лээ. Тэгээд орон нутаг зохион байгуулаад зарим аймгууд ажилдаа эрт орсон. Татан авалтууд нэлээн эрчимтэй хийгдэж худалдаа нэлээн идэвхтэй явж байгаа ийм мэдээ ирсэн.

Тэжээл байршуулалт буюу энэ дээр цэвэр улсаас ямар нэгэн хөрөнгө мөнгө гаргаад тэжээл зөөгөөд байршуулаад байгаа зүйл байхгүй. Бүх орон нутаг өөрийн төсөвт тавьчихсан эх үүсвэрээрээ дотооддоо аюулгүй байдлынхаа нөөцийг бүрдүүлж байгаа. Мах бэлтгэл дээр мөн адилхан. Орон нутаг, орон нутгийн төв, суурин газрын хангалтыг хийхийн тулд махны нөөцийг өөрөө бүрдүүлж байгаа. Жишээлбэл нийслэл хот өөрөө нийслэлийнхээ махны нөөцийг өөрөө бүрдүүлдэг ийм төсөв, санхүү нь нийслэлдээ хуваарилагддаг болсон ийм зохицуулалт явж байгаа юм байна лээ. Нэмэлтээр хариулах хүмүүс байвал.

Б.Бейсен: 4 номер. Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн.

Т.Жамбалцэрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Байгалийн хадлан болон өвс тэжээлийн нөөцтэй холбоотой Засгийн газар дээр өвөлжилтийн бэлтгэл хангах тогтоол гарсан. Аймаг болгон тодорхой чиглэлүүдийг өгсөн. Өнөөдрийн байдлаар гэхэд аймаг байгалийн хадлан тэжээл 1,1 сая тонн бэлтгэгдэж, зах зээлд борлуулагдахаар 300 мянган тонн орчим бэлтгэгдсэн худалдаалагдаж байна. Энэ дүнгээр аваад үзэх юм бол зүгээр байгалийн хадлан, өвсний нөөц бол болчих болов уу гэсэн байдалтай. Цаг хүндэрвэл хүчит тэжээл, холимог тэжээл, ялангуяа хорголжин, хивэг, овъёос, тэжээл гээд гаднаас импортоор авах зайлшгүй шаардлага гарна. Улсын хэмжээнд 42 тэжээлийн үйлдвэр

одоогоор ажиллаж байгаа. Түрүүн сайд хэлсэн тэр 87 мянган тонн тэжээлийн улаан буудайг тэжээл рүү шилжүүлээд ингээд үзэхээр 480 мянган тонн тэжээлийн нөөц бүрдэх болов уу гэж ингэж үзэж байгаа. Жилд 130-аад мянган тонн өвс.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Т.Жамбалцэрэн: Импортоор 130 орчим мянган тонн тэжээл импортоор авдаг. Тэгээд энэ жил бид нар 70-80 мянган тонн тэжээл цаг хүндэрвэл импортоор авах болов уу гэсэн ийм тооцоо байгаа.

Махны хувьд экспорт бол ид явагдаж байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай мал, мах бэлтгэж байгаа аж ахуйн нэгжүүд бодлогын гэрээгээ байгуулаад ингээд явж байна. Өнөөдрийн байдлаар гүйцэтгэл 45 мянган тонн мах экспортод гарсан дүнтэй байгаа. Өнгөрсөн жил жилийн эцсийнхээ дүнгээр 80 мянган тонн мах экспортод гарсан гэж үзсэн.

Мал төллөлт, төл хүлээн авалттай холбоотой бид нар 16-17 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулах болов уу. Дотоодын хэрэгцээнээс илүү гарсан дүнгээрээ экспортод гаргана гээд үзэх юм бол өнгөрсөн оны экспортын дүн хэмжээнд энэ тоо ойртох болов уу гэсэн ийм тооцоо тавьж байна.

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм ээ, тэр аюулгүй нөөц бүрдүүлэлт дээр энэ Жамбалцэрэн энэ тэр их сайн мэдэх ёстой. 2 жилийн нийлбэр нь би 63 орчим тэрбум байгаа болов уу гэж санаад байх юм. 25 дээр та хэд 25 гэхээр 80 хэд болчихож байгаа юм уу гэж л би ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд 100 мянга гээд тооцох юм бол наадах чинь 110 орчим тэрбум төгрөг байх ёстой. Тийм учраас

би одоо 30 орчим тэрбум төгрөгийг энэ төсвийн хэлэлцүүлгийн үед яаж нэмүүлэх ёстой юм. Үүнийгээ шийдэх ёстой юм биш үү. Тэгж байж тэр аюулгүй нөөцийнхөө бүрдлийг хангах ийм бололцоо боломж чинь бий болох ёстой гэж ингэж би бол ойлгоод байдаг. Тэгэхээр энэ дээр та хэдийн бодол санаа юу байгаад байгаа юм гэдэг нэг ийм зүйл байгаа юм.

2 дугаарт энэ гурилын үйлдвэрүүд дээр тодорхой хэмжээний өнгөрсөн жилийн будаа байгаад байгаа. Энэ жилийн тэр 134 мянган тонн будаа авчхаад байгаа нь би бол 1, 2 дугаар ангиллын будаа юм байна гэж ингэж ойлгоод байгаа. Тэр нь .../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер хариулъя. 3 номер хариулах юм уу. Хэн нь хариулах юм. 5 номер хариулах уу. Хэн билээ.

Д.Есөн-Эрдэнэ: Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ. Энэ жил гурилын үйлдвэрүүд нийт 8 гурилын үйлдвэрүүд 135 мянган тонн хүнсний улаан буудай аваад байна. Мөн Хөдөө аж ахуйн корпорац 40 мянган тонн авсан. Ингээд 174 мянган тонны ийм нөөц байна. Өмнөх нөөцүүд бас 20 орчим мянган тонны нөөцүүд байна. Тэр дээр бас гурилын үйлдвэрүүд бол технологио хангахын тулд жорлох хэлбэрээр ингэж явдаг. Тэр дээр гурилын үйлдвэрүүд энэ технологийн ажлуудаа гурилын үйлдвэрүүд тус бүрээрээ ингээд зохион байгуулаад явж байгаа.

Мөн Хөдөө аж ахуйн корпорацад 2023 оны ургацын 20 мянган тонны бас үлдэгдэл байгаа.

Б.Бейсен: Сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ жилийн будааны цавуулаг ер нь боломжийн буюу тэр жорлох түвшинээ дийлэнх нь хангачихна. Ноднин жоохон түрүүн дээрээ соёолоод жоохон чанарын уналт байгаа. Тэгэхээр

гурилын үйлдвэрүүдэд байгаа 100 гаруй мянган тонн ноднингийн будаа, энэ жилийн будаа 2 нийлээд ер нь гурилын чанар бол ер нь боломжийн түвшинд гарчих байх. Ер нь гаднаас ахиж энэ улаан буудай авахгүй гэдэг л ийм хатуу ийм байр суурьтай байгаа. Үрээ ч дотроосоо хангана. Дотоод нөөцөөрөө л хийнэ. Тун хязгаарлагдмал нөхцөлд юу гардаг юм, технологийн ийм гоймонгийн хатуулагтай өөр ийм сортын улаан буудайн асуудал зарим хүнсний үйлдвэрүүдээр гардаг. Тэрийг нь маш өндөр ийм хяналт доор цөөн тоогоор оруулна. Бусдаар байгаа дотоод нөөц бололцооноосоо л хангадаг энэ чиглэл рүүгээ л шилжихгүй бол салбар ингээд доголдоод, огцом огцом ингээд өөрчлөгдөөд саваад байж боломгүй байгаа.

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Нийт 87,8 мянган тонн улаан буудай хэрвээ эх үүсвэр шийдэгдэхгүй бол тэжээлд шилжих, дараа хавар хүлээхээс аргагүй ийм байдал үүсээд байгаа. Борлуулалт буюу энэ чинь 100-аад тэрбум төгрөгийн борлуулалт хийгдэхгүй гэсэн үг. Тэр хэмжээнд аж ахуйн нэгжүүдийн зээл эргэлт, санхүүжилт хүлээгдэнэ гэсэн үг. Тэгэхээр засаг бол нэгэнт байгаад төсвийн хүрээнд өргөн барьчихсан болохоор бид ямар нэгэн санал гаргах эрх алга. Энэ дээр Байнгын хороо бодлогын буюу шаардлагатай хөрөнгө, нөгөө төсвийн бодлогууд, хөгжлийн том зорилт хөтөлбөрүүд нь бүгд батлагдсан тэр хүрээндээ саналаа гаргаад дэмжээд явбал салбарт бол хэрэгтэй л байна.

Б.Бейсен: Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: 3 асуулт асууя. Газар тариалангийн салбарын хувьд ургац хураалт гэдэг бол үнэхээр хамгийн том кампанит ажил байгаа улс орны хувьд. Тэгээд ургац хураалтын урьдчилсан дүнг

урьдчилсан байдлаар бол сонсож мэдлээ. Улаан буудайн хураалт өмнөх оны гүйцэтгэлээс 12,6 хувиар буурсан гэсэн дүн мэдээ өгч байна. Энэ буурсан шалтгаан нь чухам юу юм. Яагаад буурав гэдэг тийм ээ ноднингийн мөн үеийнхээс яагаад буурав гэсэн асуулт байна.

Тэгээд энэ улсын хэмжээнд үр тарианы ургац хураалт 403,9 мянган тонн хурааж авсан нь урьд оны мөн үеийнхээс өссөн гэж үзэх үү, бууралттай гэж үзэх үү. Энд нэг хариулт авъя.

Малын шүлхий өвчин, тэгээд үхрийн арьс товруутах, сүүлийн үед хонины цэцэг өвчин их гарч байгаатай холбоотой мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 32 сая толгой мал хамруулахаас 25 сая толгой мал хамрагдаж, улсын хэмжээнд 83 хувьтай дархлаажуулалтын ажил 83 хувийн гүйцэтгэлтэй байгаа гэсэн дүн мэдээ байна. Тэгээд энэ бол зүгээр миний хувьд жоохон чамлалттай дүн санагдаж байна л даа. Дүн мэдээ санагдаж байна. Энэ төлөвлөснөөс 7 сая толгой мал урьдчилан сэргийлэх вакцин тун арга хэмжээнд хамрагдаж чадаагүй гэж байгаа энэ ойлголтыг ер нь бас нэг шалтгааныг нь тодруулж өгнө

3-д вакцины тал дээр байгаа юм. Шүлхийн вакцин 11,6 тэрбум төгрөгөөр 10,5 сая тун, үхрийн арьс товруутах өвчинд 2,4 тэрбум төгрөгөөр 9,5 сая тун, бруцеллэз өвчинд 2,5 тэрбум төгрөгөөр 11,3 сая тун ингэж тус тус төсөвлөж зарцуулагдсан. Тэгээд нийтдээ 20,6 тэрбум төгрөгөөр энэ 2024 онд вакцин нийлүүлэлтийг хийсэн юм шиг байгаа юм. Худалдаж авсан. Тэгэхээр энэ 6 нэр төрлийн малын өвчин гэсний нэг нь ямар төрлийн өвчин энд мэдээлэгдэлгүй хоцорчхов. Тэгээд улсын хэмжээнд эдгээр нэр төрлийн вакцины хэрэгцээ шаардлага, тэгээд л нөөцийг нь хэрхэн зөв удирдаж ирсэн, цаашдаа ер нь энэ тооцоололыг малын тоо толгойд харьцуулсан вакцины тунгийн асуудлыг

яаж тийм төлөвлөлт хийж явдаг юм бэ. Тэгээд энэ үр дүнг нь ер нь хэрхэн мэдээ мэдээллээр мэдээлдэг юм болоо гэдэг тал дээр хариулт авъя.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Энэ 12,6 хувиар тоо хэмжээ, ургацын хэмжээ унасан. Энэ бол ноднингийн татварын эрс өөрчлөлттэй холбоотойгоор нийт 56 мянган га талбайд улаан буудайн тариалалт багассан юм. Өөрөө энэ гурил маань маш хямд үнэтэй, их эмзэг бараа байдаг. Ашигийн түвшин маш бага түвшинд явдаг. Тэгээд жоохон хаалт болсон татвар нь байхгүй болонгуут ОХУ-аас бэлэн гурил, улаан буудай татваргүй бүх боомтоор орж эхэлсэн. Энэтэй холбоо тариаланчид тариалалтаа багасгаад, тосны ургамлынхаа тариалалтыг нэмээд буюу Хятадын зах зээлд зориулсан экспортынхоо ургамал руугаа гол хүчээ хаячихсан. Яаралтай энэ татварын бодлогын эрс өөрчлөлтийг зогсоож залруулахгүй бол ирэх онд мөн адилхан. Ахиад багаар бодоход 50, 60 мянган га-аар, үндсэндээ 100 гаруй мянган га-аар ингээд улаан буудайн тариалалт унахаар ийм тоо гараад байна.

Сая Батжаргал гишүүн санаа зовж асуугаад байна л даа. Үнэхээр хүрэлцэх үү гээд байна. Бид нар энэ жилийн ургацаар бол дөнгөн данган л чүү ай л нэг амсуулах хүрэх болов уу гэж бодож байна. Аль болох импортоор улаан буудай авахгүйг бодно. Дотоодынхоо бүх юмыг бүрэн дайчилж, тээрэмдэж бүтээгдэхүүн тэжээл үйлдвэрлэл рүүгээ анхаарна. Хэрвээ татварын асуудал шийдэгдэхгүй бол ирэх онд ахиад тариалалт багасчихвал хүрэлцээ унаж, бид нар гаднаас импортын хамааралтай буюу дотроосоо 100 хувь хангаж байсан хүрсэн амжилтаасаа ухарна л гэсэн үг. Тэгэхээр энэ асуудлыг засаг дээр оруулж танилцуулсан. Одоо Их Хуралд оруулахаар бэлдэж байна. Ахиад хэлье. Баярбаатар даргатай, саяын Мандухай

гишүүнтэй ажлын хэсэг ажиллаж байгаа. Эд нар энэ талаар тайлбар хийгээд сонсоод ингээд яваад байгаа. Ойрын үед асуудлаа танилцуулна гэсэн. 6 номер юугаа хариулаарай. Мал эмнэлгийнхэн мэдээллээ сайн өгөөдөх.

Б.Бейсен: 6 номер.

Б.Батсүх: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал эмнэлгийн хяналт, баталгаажуулалтын газрын дарга Батсүх байна. Манай улс энэ жилийнхээ тооцооллоор ер нь бол гаднаас импортоор 3 төрлийн гоц халдварт өвчний вакциныг авдаг. Шүлхийн вакцин байж байна. Бог малын мялзан өвчний вакцин. Мөн үхрийн арьс товруутах өвчний вакциныг гаднаас бол импортоор худалдаж авдаг. Хонины цэцэг болоод бусад дотоодод гардаг нийтлэг халдварт өвчний вакциныг бол Био комбинатаасаа ингэж худалдаж авдаг ийм байгаа. Тэгээд энэ 2024 онд 13,7 сая малыг шүлхийн вакцинд, 27,7 сая малыг бог малын мялзан өвчний вакцинд, 12,3 сая малыг хонины цэцэг өвчний вакцинд дархлаажуулалттай, 948 мянган толгой малыг бол үхрийн арьс товруутах өвчний эсрэг дархлаажуулалтад хамруулахаар төлөвлөөд ажиллаж байгаа. Одоо 83,3 хувьтай явж байгаа маань вакциныхаа технологид хугацаа нь дуусаагүй, зарим төрлийн вакцинууд нь бол үргэлжлээд хийгдээд явж байгаа.

Б.Бейсен: Нэмэлт хариулт. 6 номер.

Б.Батсүх: Вакцины төлөвлөлтийг бол эпидемиологийнхоо судалгаа дээр үндэслэж хийдэг. Мэдээж бид нар хангалттай тухайлбал шүлхий өвчний дархлаажуулалтад нийт малын 20 орчим хувь нь бол хамрагддаг. 2 удаа дархлаажуулалт хийгддэг. Тэгэхээр цаана нь бусад мэдрэмтгий бас 80 орчим хувийн малыг дархлаажуулах ийм шаардлага бол байж байгаа. Монгол Улсын тухайд болохоор шүлхий өвчний

дархлаажуулалтад үхрийг хамруулах стратегийг хэрэглээд явж байгаа ийм байгаа.

Б.Бейсен: Батчимэг гишүүн тодруулъя. Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн гүйцээж хариулъя гэж байна. 4 номер.

Т.Жамбалцэрэн: Гишүүний асуултад хариулъя. Мал эмнэлгийн тарилга үйлчилгээ вакцины хүрэлцээ хангамж бол яг манай улсын хэмжээнд бол маш их дутагдалтай байгаад байгаа юм. Бид нар үндсэндээ 60 орчим тэрбум төгрөгийг мал эмнэлгийн төсөв дээр тавьдаг. Үүний 50 хувь, 40 хувь нь импортын тарилга вакциндаа явчихдаг. Энэ түрүүнд дурдсан 3 төрлийн вакцин. Энэ 3 нь бол импортоор авдаг. Бусад 20 төрлийн вакциныг нь бид нар дотоодын био комбинатынхаа үйлдвэрлэлээр хангадаг. Тэгээд Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулиараа олон улсын хорио цээртэй гоц халдварт өвчнийг улс хариуцаад улсын төсөв дээр суулгаад, 21 аймаг Мал эмнэлгийн газраар дамжуулаад хүргэгдээд, ингээд тарилга вакцин хийгдээд энэ зардлууд нь явж байдаг. Бусад тэр дотоодын хорио цээртэй 20-иод төрлийн өвчнийх нь шаардлагатай тарилга вакцин, эм урвалжийнх нь зардал нь 21 аймгийн төсвүүд дээр суулгадаг. Тэгээд аймаг орон нутгийн төсөв дээрээ эдгээр зардлууд нь бүрэн сууж өгдөггүй.../минут дуусае/

Б.Бейсен: Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Ер нь бол энэ вакцины асуудал бол Хунс, хөдөө аж ахуйн яамны хувьд бас малын юун дээр маш их бас асуудал дагуулдаг л даа. Тэгээд Монгол Улсын хэмжээнд байгаа малын тоо толгойтой харьцуулахад хийж байгаа дархлаажуулалт малын өвчний эсрэг хийж байгаа вакцины тун хангалтгүй. Ажлын гүйцэтгэл бас шаардлага, зорилгодоо хүрээгүй байгаа нь цаашидаа

энэ ажлыг яаж сайжруулж явах юм бэ гэдэг асуудал бүр илт хөндөгдөж гарч ирж байна гэж харж байна. Улсын төсөвт жилийн жилд суулгаж байгаа вакцинжуулалт, дархлаажуулалтын төсөв болохоор өндөр.../минут дуусав/

Б.Бейсен: Батчимэг гишүүнд 1 минут өгье.

П.Батчимэг: Тэгээд хийж байгаа ажлын гүйцэтгэл нь ийм сул ийм хангалтгүй байгаа дээр анхаарах хэрэгтэй л гэж би бодож байна. Ер нь одоо энэ малын өвчлөл жилээс жилд л улирлаас улиралд ихсээд байгаа юм л даа. Тэгэхээр энэ байдалтай энэ ажлаа маш сайн уялдуулж ажиллах хэрэгтэй. Тэр оруулж ирсэн гадаадаас импорттоор гадаад улс орнуудаас оруулж ирж байгаа вакцины чинь чанар ямар байдаг юм, хадгалалт нь ямар байдаг юм. Тэгээд хүртээмж нь ямар байдаг юм гэдэг энэ төлөвлөлтийн асуудал дээрээ анхаарах хэрэгтэй гэж би бас хэлэх байна.

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайд Энхбаяр.

Ж.Энхбаяр: Байнгын хороон дарга аа, ер нь мал эмнэлгийн салбарын өнөөгийн байдал, мал эмнэлгийн орон нутгийн салбарын өнөөгийн байдал, тоног төхөөрөмж, чадавхын байдал, хүний нөөц, био комбинат буюу вакцины үйлдвэрлэл гээд энэ Био комбинат 2 шинэ шугам ашиглалтад оруулж байгаа. Тэр арга хэмжээний хүрээнд гишүүдээ уриад ер нь бид нэг иж бүрэн танилцуулга хийе. Тэгээд ер нь ойлголтоо бүгдээрээ нэг болгоод, цаашидаа ер нь яах аргагүй энэ мэргэжлийн Байнгын хорооныхоо бодлогын дэмжлэг, Байнгын хорооны тогтоолууд, хуулийн өөрчлөлтүүд энэ дээр төсөв гээд олон зүйл дээр Байнгын хороотойгоо хамтарч ажиллахгүй бол бас үнэхээр олон зүйл хойш тавигдаж байгаа. Зайлиггүй хийгдэх ёстой олон зүйл хойшлогдоод л байгаа. Гэтэл энэ чинь ажиллах хүчний $\frac{1}{2}$, дотоодын нийт бүтээгдэхүүний 30 гаруй хувь, ялангуяа

орон нутгийн үйлдвэрлэлийн 85 хувь нь энэ хөдөө аж ахуйн салбар дээр л явагдаад байдаг.../минут дуусав/

Б.Бейсен: Хөдөө аж ахуйн сайдын саналыг хүлээж авлаа. Энэ ер нь малын эрүүл мэндийн асуудал бол Монгол Улсад үнэхээр орхигдсон байгаа. Сая Наранбаатар гишүүн ярьж байна. 9 сумд багийн малын эмч байхгүй гэж байна шүү дээ. Тоног төхөөрөмжийн дутагдалтай, эм нь бас тийм, малын эмч нар нь бараг малчин болсон явж байгаа шүү дээ. Тэтгэвэрт гарчихсан хүмүүс л байна. Боловсон гишүүнд бэлтгэх асуудал дээр түрүүн Энхбаяр сайдын ярьдгаар Боловсролын яамны харьяа, гэтэл боловсон хүчин бэлтгэх асуудал мөн алдагдчихсан. Тийм учраас энийг бид нар ирэх 7 хоногоос хэлэлцүүлэг холбогдох яамд, мэргэжилтнүүд дуудаж байгаад хэлэлцүүлэг хийж байгаад тэр Био комбинатын үйл ажиллагаатай танилцах талаар бид нар ажил зохион байгуулъя.

Идэрбат гишүүнд асуулт асууя.

Ц.Идэрбат: Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбоотой асуудлаар бас тодруулах юмнууд байгаа юм. Зүгээр энэ өвлийн нөхцөл байдлыг ер нь яаж дүгнэж байгаа вэ. Цаг уурын мэдээгээр олон жилийн дунджаас ямар байх юм. Үүнтэй холбогдуулаад ер нь өнгөрсөн өвөл бол зудын үеэр мал борлуулах асуудлуудыг бас зохион байгуулж байсан. Тэгэхээр заавал зудын үеэр тэгж тулгаж хямд үнэтэй борлуулж байгаа юм шиг авах тийм бололцоог олгож байгаа юм шиг биш, ер нь энэ борлуулалтын үйл ажиллагааг байнга хийдэг байвал яадаг юм бэ. Цас их болохоор л борлуулаач гэдэг ийм зүйлээр биш гэдэг 1 дүгээрт ийм зүйл асуух гэж байгаа юм.

2 дугаарт ер нь өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулаад энэ отрын нөхцөл байдлыг ер нь яаж үзэж байгаа вэ. Энэ отор дээр ер нь бид ер нь цаашидаа ямар бодлого барих ёстой юм

бэ. Энэ отрын ямар нэгэн зохицуулалт яг амьдрал дээр бол байдаггүй шүү дээ. Зүгээр цаасан дээр бол янз янзын л юм байдаг байх. Яг амьдрал дээрээ бол ямар ч асуудал байхгүй. Энийг хянадаг ч газар байхгүй, мөрддөг ч хүн байхгүй. Ингээд л энэ чинь ингээд л нэг өвчин тараасан. Хаана соргог бэлчээр байна тэрийг очиж талхалсан ийм л юм байгаа юм.

Дараагийн нэг зүйл бол ер нь энэ бэлчээр хамгаалах тал дээр эд нар бол ямар ч мөнгө шаардахгүй асуудлууд байхгүй юу. Хөдөө аж ахуйн яам ер нь ямар бодлого барьдаг юм бэ. Одоо энэ Дорнод, Сүхбаатараар явж байхад Монголын хамгийн л бэлчээрийн сор болсон зүүн бүсийг бол ер нь талхалж дуусаж байгаа юм билээ дээ. Тэгээд цаана нь улсын хил байгаа учраас цаашаа явж чадахгүй байх л даа. Энэ чинь Төв аймгаас эхлээд л зүүншилсээр, зүүншилсээр, манай Хэнтийг талхлаад, одоо Сүхбаатарын зүүн тал, Дорнодын зүүн тал руу орчихсон юм байна лээ шүү дээ. Хэдэн мянгаар нь адуу тэнд адгуулж байдаг нөхөд ер нь ер нь яах юм бэ. Мянган адуу, 2 мянган адуу. Идээд барахгүй, унаад барахгүй, эдлээд барахгүй. Зүгээр тэнд байгаа хүмүүсийн бэлчээрийг нь л талхалж байдаг. Эзэд нь энд байдаг. Тэр тоог нь сонсож зугаацдаг юм уу, кайф авдаг юм уу. Тэгээд л хамгийн өнгөтэй өөдтэй тэр бэлчээрийн соргог газрыг нь аваачаад талхлаад хаячихдаг. Дүүрэн байгаа шүү дээ. Та нар тэрийг мэдэж байгаа юу. Яг үүн дээр ер нь Хөдөө аж ахуйн яам ер нь яг ямар арга хэмжээ төлөвлөж байгаа юм. Би үндсэндээ нэг ийм 3 юм асууя гэж бодоод байгаа. Энэ бол би ч биш ард иргэд сая биднийг явахад ялангуяа энэ бэлчээр хамгаалах асуудал дээр ямархуу байдалтай байх юм. Одоо ингээд тийшээ оччиход аймгийн дарга яаж ч чадахгүй, сумын дарга бүр яаж ч чадахгүй. Багийн дарга яаж ч чадахгүй. Тэгээд цагдаа яаж ч чадахгүй. Тэгэхээр энэ дээр бол мөнгө шаардахгүйгээр уг нь жоохон зохицуулалтууд хийгээд өгчих бололцоо уг нь баймаар л юм шиг надад санагддаг

юм. Тэгээд энэ дээр би 3 асуултаар хариулт авъя гэж бодож байна. Хариулт авъя.

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: 1 дүгээрт цас зуд болохоор л мал худалдан авах асуудал гэж ярилаа. Яг өнөөгийн байдлаар бид ерөөсөө гол зорилго бол экспорт, экспорт, экспорт. Ялангуяа махны экспортыг л эрс нэмэгдүүлэхийн төлөө л тэр зах зээлийг нээхийн төлөө салбарт байгаа тэр ямар нэг хүнд суртал, тэр квот, хязгаарлалтыг нь тэглэсэн. Гадаад зах зээл нээхийн төлөө идэвхтэй ажиллаад амжилтууд, боломжууд нээгдэж байна. Өнөөдөр манай махны үйлдвэрүүд үндсэндээ 100 хувь бүрэн ачаалалтай ажиллаж байна. Экспорт маш сайн явж байгаа. Экспорт үндсэндээ 100 хувь урд хөршөөс хамааралтай байсан. Одоо Төв Ази, Ойрх Дорнод чиглэл рүүгээ бараг 40, 50 хувь экспортын бүтэц өөрчлөгдөөд, идэвхжээд эхэллээ. Тэгэхээр энэ дээр дараагийн зүйл байнга борлуулалтыг хангахын тулд тэжээл. Манай нүүдлийн мал аж ахуй дээр байгаа мал маань намартаа ганц тарга хүчээ аваад, бусад үед дандаа жингийн алдагдал ороод, жингээ нөхөх ийм цаг хугацааны юм яваад байгаа. Тэгэхээрээ тэжээлийн тариалалт буюу тэжээлээр тарга хүчийг нь барих энэ ажлыг л хөгжүүлж гэдэг нь тэр 200 мянган га талбайг тэжээлийн талбайг нэмэгдүүлж гээд байгаа нь тэр. Байгалийн хадлангаар биш шүү дээ. Тэжээлийн хүчит тэжээл байж байж тэр экспортын чанарт нийцээд байгаа юм. Экспорт тасралтгүй байна. Ингээд энийгээ дагаад мал маллах арга ухаанд өөрчлөлт ороод, дадал нь өөрчлөгдөөд ирэхээр малчид маань улам урам зоригтой идэвхтэй болоод байна. Байнгын борлуулалт. Хавар, зун, намар, өвлийн аль ч улиралд нэг стандартын тарга тэвээрэхтэй малыг л бид нар борлуулдаг. Нөгөө сая гишүүдийн яриад байсан тэр хамгаалагдсан аж ахуй, хамгаалагдсан бүсүүдийг бий болгоод

ийм өсвөр малыг бордох тэжээлийн баазууд бүхий тийм цэгүүдийг олноор бий болгоод ингээд тасралтгүй тэжээлдээд, тэндээс стандартын дагуу экспорт хийгээд байх энэ системийг босгоод авч чадвал бид тэгээд л тасралтгүй л манай мал аж ахуй үр өгөөжтэй, ашигтай, малчдын орлого маань ч гэсэн илүү болоод илүүдэл ийм олон малыг өвөлжүүлэх гээд л тэжээх гээд л байх шаардлага багатай болох юм байгаа юм.

Мэдээж зохицуулалт отор. Отрын бүс нутгийн захиргаа үндсэндээ яамны харьяанд 5, 6 хүн ажиллаж байна. Улсын хэмжээнд отрын тодорхой бүс нутаг байна. Энэ дээр аль болох байнгын өвөлжөө айлуудын хаваржаа, зуслан байлгахгүйгээр аль болох байгаль өөрөөрөө нөхөн сэргээгдэх бололцоог хангахын тулд л ажиллаж байгаа хэдий ч үнэхээр Монгол Улсын хэмжээнд малын тоо, бэлчээрийн даац 2 хэтэрчихсэн. Бэлчээрээ нөхөн сэргээх чадавхаа бид нар авч чадахгүй байгаа юм. Ингээд ирэхээр чинь малчин бүрэн тарга хүчээ авч чадахгүй, тэгээд цас зуд, байгаль дэлхий эрсдэлийг даван туулах чадавх нь унаад ингээд л олон саяараа хорогдоод байгаа нь үүнтэй холбоотой. Тэгэхээр бид нар мал аж ахуйн салбартаа, ялангуяа тэжээлийн таримал дээр онцгой бодлого, тэжээлийн аж ахуйнуудыг бий болгохгүй бол цаашдаа явахгүй гэдэг нь тодорхой болсон.

Адуу хамгийн эдийн засгийн эргэлтэд бага орж байгаа адуу байгаа. Сая Төв Азийн орнуудтай мал эмнэлгийн хөдөө аж ахуйн салбар хоорондын гэрээнүүдийг үндсэндээ хийгээд овоо дөхөж байна. Одоо 2 орон үлдээд байна. Ингэх юм бол Төв Ази бүс нутаг өөрөө адууны их томоохон зах зээл адууны махны хэрэглээ. Энэ дээр бид нар ажиллаж чадвал нэлээн үр дүн экспортыг идэвхжүүлж байж л энэ тоо толгой зохицуулна. Тэгэхгүй бол байгалиараа зөнгөөрөө өсөж байгаа адуу чинь мянга мянгаараа сая саяараа өсөж

байна шүү дээ. Нөгөө талаас татварын асуудал. Байнгын хороо энийг анхааруулаад, малын хөлийн татвар дээр нэг бодлого өөрчлөлт хиймээр байгаа юм. Ялангуяа адууны тоо толгойг зохицуулах эрс арга хэмжээ авахгүй бол үнэхээр бусад малын бэлчээрийг талхлах, отрын нөөцийг талхлах, эрсдэл дээр нэлээн гол ачаалал үүсгэж байгаа нь үнэн. Тэгэхээр энэ дандаа л татварын бодлогоор эдийн засгийн арга ухаанаар л шийднэ үү гэхээс биш, бусдаар тэр урт хөлийн малыг орон нутаг, сум зогсоох, хөөх, зохицуулах бололцоогүй болчихоод байгаа юм. Тэгэхээр татварын асуудал татварын жсоохон даацтайхан байгаад толгойд нь.../минут дуусае/

Б.Бейсен: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Отрын бүс нутаг дээр сайд бас анхаарлаа хандуулж байгаад баяртай байна. Манай Хэрлэн баян-Улаан гэж аль л социализмын үеийн одоо бол тэр утгаа алдчихсан. Тэнд 190 мянган га газрыг нэг хэдэн хүн давуу эрхтэйгээр орж байдаг. Тэгээд тэнд хавар ердөө малын өвчин, тэгээд л малын сэг зэм үлдээж байдаг нэг ийм айхтар газар болчихсон. Тэгээд энэ дээр ердөө яам бол энэ отрын бүс нутгийн асуудал дээр эргэж нэлээн анхаараарай. Өнгөрсөн парламентын хугацаанд нэлээн сайн ажилласан. Харамсалтай нь шийдвэр гаргуулж чадаагүй. Тэгэхдээ одоо араас нь бас дахиад явна гэж ингэж бодож байгаа.

2 дугаарт энэ адууны асуудал дээр яам бас энэ орон нутгуудтайгаа чиглэл өгөх үү. Бас нэлээн сайн ажиллах хэрэгтэй. Миний яриад байгаа тэр олон мянган адуутай нөхөд мөнгөгүйдээ юм уу энийг зарчихъя, борлуулчихъя гэх юм байхгүй юм билээ. Ердөө л тэр олон мянган адууг цуглуулж, тэндээсээ л нэг кайф авах маягтай. Тэгэхээр энэ дээр ер нь татварын бодлого дээр яам нь ч тэр, Засгийн газар нь ч, орон нутаг нь ч тэр

нэлээн хатуу байр суурь илэрхийлэх нь зүйтэй юм.

Б.Бейсен: Идэрбат гишүүн санал хэллээ. Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд хүргэе. Тэр улаан буудайн ургац тариа хураалт энэ асуудлууд дээр бол ер нь тэгээд Батжаргал гишүүн, Батчимэг гишүүн 2 бол асуучихлаа даа. Яг үнэндээ бодитой байдал дээр энэ гурилын үйлдвэрүүд чинь улаан буудай авахгүй байгаа юм байна лээ шүү дээ. Одоо тэр илүүдэл түрүүн сайдын ярианд гарч байна. Илүүдэл 87 тонн улаан буудай тэжээлд шилжих тухай. Тэгээд ингээд яваад байх юм бол наад татварын асуудлаа яаралтай шийдэхгүй юм бол энэ чинь газар тариалан чинь буцаад уначихна шүү. Нөгөө Атрын 3, одоо үргэлжлэх гэж байгаа 4 дүгээр аян гэдэг чинь ямар ч үр дүнгүй болно. Тийм учраас яаралтай наад татвартай холбоотой тэр улаан буудайг чөлөөлсөн асуудлаа шийдэхгүй бол тэгээд орон зайн дээр нь рапс ихээр тариалж байна. Яах вэ, таримлын сэлгээнд муу ургамал биш л дээ рапс. Гэхдээ энэ чинь тэнд амьдрал юм болохоор хүмүүс хэдэн төгрөгөө бодоод хурдан борлогдохоо бодоход рапс тариад эхэллээ шүү дээ. Хөрсний үржил шим юу болох вэ тийм ээ. Энэ саналыг анхаарчхаарай.

Тэгээд 2 асуулт байна. Энэ өвөл улсын хэмжээнд 189,2 мянган малчин өрх 50 сая толгой мал өвөлжих юм байна. Говийн бүсэд 8,3 сая толгой мал өвөлжих юм шиг байна. Өнгөрсөн өвөл хүнд болсон. Энэ өвөл ч бас их хүнд болж магадгүй. Энэ байдал ийм орой болтол бороо орж мөсөн өвөл болж магадгүй гээд туршилагатай хүмүүс яриад байна. Өнгөрсөн өвөл бид бол зуд гэж яриад байгаа болохоос яг үнэндээ зүүн аймгууд давагдашгүй хүчин зүйл болсон. Улсын хэмжээнд 8,1 сая толгой мал, 70-аас дээш хувийн малаа алдсан 4816 өрх, 509 өрх айл огт малгүй болсон гээд. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор энэ малгүй болсон

өрхүүдийг малжуулах чиглэлээр яг ямар ажил хийж байна вэ яамнаас. Би дээр бас Байнгын хорооны хурал дээр хэлсэн. Зөвхөн нэг жишээ хэлэхэд манай Дорноговь аймаг, говийн бүс зөвхөн Дорноговь аймаг гэхэд өнгөрсөн жил 613,986 толгой малаа нийт мал сүргийнхээ 26,7 хувийг алдчихсан. Дахиад сая нөгөө гоц халдварт өвчинтэй холбоотойгоор 14 мянган ямааг ингээд үндсэндээ нядалж байна. Нядлаад эхэлчхээд байж байна. Оруулж ирсэн тайланд чинь 3 төрлийн халдварт өвчин гарсан гээд л орчихсон л байгаа харагдана. Яах вэ мал, махны экспорттой холбоотойгоор энийг бас нэг их нийтэд ярихгүй л байгаа байх л даа. Тэгэхээр нөхөн олговор яах вэ тэр мал, махтай холбоотойгоор ингээд олгогдох байх. Төсөв дээр чинь суусан уу. Нэг их сунжирч сунжирч жоохон мөнгө очдог. Цаашид энэ зудад, гоц халдварт өвчинд малаа алдсан мал сүрэггүй болсон малчдыг малжуулах, төв суурин газар малгүй болоод орсон иргэдийг амьдрахад нь чадавхжуулах энэ талаар яамнаас яг ямар арга хэмжээ зохион байгуулж байна вэ.

Манай улсын хөдөө аж ахуй, ялангуяа газар тариалан, мал аж ахуйн салбар бол маш эрсдэлтэй салбарт ордог. Эрсдэлийг бууруулдаг, хуваалцдаг, төрд ачаалал хүргэдэггүй салбар бол яалт ч үгүй даатгал. Хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт даатгалын системийг боловсронгуй болгох чиглэлээр яамнаас бодлогоор ямар асуудлууд явж байна вэ. Сая.../минут дуусав/

Б.Бейсен: 1 минут Ганбаатар гишүүнд.

Г.Ганбаатар: Энэ Байнгын хорооны хурал дээр ярих нь зохимжгүй байх зүгээр үүнтэй холбоотой манай орон нутгаас бас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Энхбаяр тан дээр нэг ил захидал ирсэн. Орон нутгийн ялангуяа тэр Хатанбулаг сумын малчдыг төлөөлөөд Сономын Чулуун гээд зохиолч

бас би үүнийг танд бас гардуулчихъя. Энд уншаад яах вэ. Энэ бол бас цаашидаа манай мал аж ахуйн салбарт анхаарахаар бодууштай, ялангуяа энэ малын гоц халдварт өвчин гарсантай холбоотойгоор бол танд бол мэдээлэл их оройтож ирсэн байна шүү гэсэн агуулгатай. Энэ чинь 7 сард гарсан шүү дээ яг үнэндээ бол. Сая тэр мал аж ахуйн юуны хэн гэлээ өөрөө. Батсүрэн. Яг та нар өөрсдөө мэдэж байгаа биз дээ. Энэ чинь 7 сарын 6-нд анх гарсан шүү дээ. 4 сарын дараа гээд сайдыгаа худлаа мэдээллээр хангасан байна лээ шүү. Энийгээ анхаараарай та нар. Яах вэ энэ Байнгын хорооны хурал болоод чуулган дээр бол бас ярих ярихгүй юм бол байна. Үүнийгээ бас ойлгоно. Тэгээд энэ захидлынх нь бас би Энхбаяр сайдад өгчихье. Тэгээд 2 асуултдаа.../минут дуусав/

Б.Бейсен: Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Мэдээж энэ гурилын салбарыг газар тариалан салбартай холбон авч хэрэгжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ. Малын тэр хорогдолтой холбоотойгоор нийт одоогийн байдлаар 77,3 тэрбум төгрөгийн хүү малчдын өмнөөс энэ улсын төсөв дээр сууж, төлж байгаа. Нийт 109 мянган малаа алдсан малчдын арилжааны банканд байсан 1,1 их наяд төгрөгийн зээлийн хүүг нь улсын төсөв дээр суулгаж төлж байгаа. Нийт 77,3 тэрбум төгрөг байгаа. Түүгээр манай урсгал зардал их өндөр гарч ирээд байгаа юм. Нөгөө талаар улсын нөөцөөс Засгийн газрын нөөц хөрөнгөөс малжуулах ажил, арга хэмжээнүүдийг тухайн үед нэлээн өргөн хүрээнд авч хэрэгжүүлсэн. Үүгээр л бид нарын үйл ажиллагаа хязгаарлагдаж байна.

Гурил үйлдвэрлэлтэйгээ үнэхээр гурилын үйлдвэрүүд авахгүй байгаа. Яагаад гэвэл бэлэн гурил их хэмжээнд орж ирж байгаа. Бэлэн гурил ороод ирэхээр үйлдвэрлэх шаардлагагүй. Үйлдвэрлэлийн тоо хэмжээ багасаад

ирэхээр тэжээлийн гарц багасаад эхэлнэ. Тэжээл багасахаар нөгөө гахай, тахиа, сүүний аж ахуйнууд чинь тэжээл нь дутагдалд ороод тэжээл үнэтэй болоод байна. Ингээд хөдөө аж ахуйн чинь бүгд ингээд нэг ийм цогц зүйл байхгүй юу. Нэгийг нь буруу хөндөхөөр л бусад нь ингээд доголдол үүсчихдэг. Тэгэхээр асар их сайн олон талын тооцоолол хийж байж хөдлөх ёстой юм байдаг.

Хөдөө аж ахуйн даатгал үндсэндээ байхгүй байгаа. Муу байгаа. Үерт ороод л хүнсний ногоо ургац алдчихаж байна. Даатгал байхгүй. Малын даатгал маш хязгаарлагдмал нөхцөлд явж байна. Тэгэхээр хөдөө аж ахуйн даатгалыг иж бүрэн системийг босгох өөр арга байхгүй. Ийм манай цаг уурын ийм эрсдэлтэй газар. Тэгэхээрээ нөгөө талдаа эдийн засгийн хувьд бас үр өгөөжийн талд яг энэ даатгалын систем маань өөрөө цэвэр хувийн хэвшил дээр тулгуурласан ашигийн төлөө явж байгаа болохоор хөдөө аж ахуйгаас тойроод байгаа нэг ийм зүйл байдаг.

Хатанбулагийн нөхцөл байдлыг мэдэж байгаа. Та хэлсэн. Бас ярих юм байна, ярихгүй юм байна. Зохион байгуулалтын арга хэмжээг авч, олон зүйлийг судлах, шалгах мэдээлэл тодруулах ажиллагаанд явагдаж байгаа. Арга хэмжээг аль болох хурдтай, богино хугацаанд авч хэрэгжүүлж дуусгах. Үндсэндээ асуудлаа боогоод голомтын хүрээг тодорхойлоод устгалын ажлыг эрчимтэй явуулж байгаа. Энэ дээр орон нутгаас сонгогдсон гишүүд байнгын дэмжлэг үзүүлээрэй. Энэ бол их үр дагавар нь их ноцтой зүйл үүсэх юм шүү гэж гэдэг талаас нь хэлье дээ.

Б.Бейсен: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Яах вэ, Энхбаяр сайд аа, ийм байхгүй юу. Миний асуулт малжуулах тал дээр яг юу хийж байна вэ гэж. Та бол сая нөгөө өнгөрсөн хугацаанд малаа алдсан малчдын хүүг чөлөөлсөн,

түүний төлбөрийн 77,3 тэрбумыг ярьчихлаа л даа. Яг өнөөдөр бодит амьдрал дээр хөдөө малчин малаа алдсан айлын гадаа нэг хятад портёр, хятад мотоцикл 2 л байна. Хэдхэн мал нь үлдсэн айлууд нь төв рүү орчихсон. Тэгээд малжуулах тал дээр эсвэл олон улсын байгууллага төсөл хөтөлбөр энэ дээр яг ямар асуудлууд зохион байгуулж байгаа юм бэ гэж асуугаад байгаа юм.

2 дахь зүйл нь болохоор тэр төв рүү малгүй болоод орсон улсуудыг чадавхжуулах тал дээр зах зээл дээр нэн тэргүүнд хэрэгтэй мэргэжлээр сургах ч юм уу, тэр амьдрал төлөө олоход нь туслах ийм юм хийхгүй бол үнэхээрийн нийт 8,1 сая мал чинь түрүүний хэлсэн тоо 5300 гаран өрхүүд огт амьдралгүй болж байгаа байхгүй юу хөдөө аж ахуйн салбарт. Тэгээд уг нь бол тэд нар чинь хороо нь бэлэн, бэлчээр нь бэлэн байдаг. Мал нь байхгүй л болчихоод байгаа байхгүй юу. Энэ тал дээр яам бодлого гаргах ёстой л гэж хэлээд байгаа юм.

Б.Бейсен: Сайд хариульъя.

Ж.Энхбаяр: Хэлээд байгаа шүү дээ. Сангийн яам төсвийн хүрээндээ л бид ажиллана шүү дээ. Бүх хөтөлбөрөө хүсэлтээ шаардлагаа бичээд л өргөн барьдаг. Сангийн яаман дээр нэгтгэн зангиддаг. Тэгээд л орж ирж байгаа байдал маань энэ. Олон улсын хандив тусламжийн юм яг гамшигийн үед нэлээн тодорхой хэмжээний эх үүсвэр бий болсон. Тэр нь 100 хувь зарцуулагдаад орон нутагтаа, иргэддээ хүрээд дууссан гэдгийг Гамшигийн ерөнхий газраас мэдээлж байсан. Тэгэхээр бидэнд бол ямар нэгэн малжуулах төсөл хөтөлбөр жоохон хязгаарлагдмал. Хоршоо гэсэн нэг хөшүүрэг байна. Хоршооныхоо хүрээнд явуулна. Гэтэл хоршоо маань гол барьцаа хөрөнгө мал аж ахуйн асуудал байхгүй болохоор тэр иргэд маань тэр хоршоонд хамрагдах байдал нь унаад ороод ирж байна.

Тэгэхээрээ ахиад л хэлье. Мэргэжлийн Байнгын хороотойгоо энэ салбар дээрээ бүгдээрээ хамтраад хийх ажил их байна. Их байгаа шүү. Мааш их байна. Ганц яам өөрийн хүчээр гэж юмны ард гарна гэж байх ёсгүй.

Б.Бейсен: Өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар өвс тэжээлийн аюулгүй нөөц түрүүн Батжаргал гишүүн ч ярилаа. Идэрбат гишүүн ч ярилаа. Энэ ер нь тун хангалтгүй шүү. Та нар аймгуудаар яваад үзээрэй. Бэлдсэн юм байхгүй. Ноднин нэг аймагт бүр хавар зуд болох үед чинь тэр зарласан тендерийг чинь 2, 3 сард өвс тэжээлээ бэлдсэн шүү дээ. Тендерээ яасан шүү дээ. Тэгэхээр энэ асуудал дээр 11 сарын 15 гэхэд өвөлжилтийн бэлтгэл ажил бүрэн хангагдах ёстой. Тэгэхээр энэ дээр та нар хяналт хийж байна уу.

2 дугаарт өнгөрсөн жилийн зудын зардал үргүй зардлын асуудал байна шүү дээ. Гамшигийн. Энийг тооцож үзсэн үү.

3 дугаарт бол өвөлжилтийн бэлтгэл ажил гэхээр чинь тэр Хэнтий, зарим аймаг, Сүхбаатар, Дорнод, Говийн аймгууд дээр чинь малын хашааны асуудал дээр энэ сая юун дээр чинь ядахдаа 1 багийн ч юм уу өвөлжилтийн битүү хашаатай болох тал дээр юм байж байна. Тийм сараалжтай өвөлжиж байна гэдэг чинь цас шуурганаар мал байхын аргагүй шүү дээ. Ерөөсөө энэ талаар баримталж байгаа бодлого байна уу. Нөгөө талаар энэ хүнсний ногооны талаар. Дотоодын энэ жил тариалсан хэчнээн хувь хангагдчихаад байна. Импортоор хэдэн хувийн хүнсний ногоо оруулахаар төлөвлөж байна. Ер нь улсын хэрэгцээ хэр байна.

3 дахь асуудал. Малын өвчлөлийн асуудал байна. Тэр годрон өвчин гарсан шүү дээ. Тэр дээр хорио цээрийн арга хэмжээ, вакцинжуулалт нь ямар шатандаа явж байна. Энэ талаар тодорхой мэдээлэл авъя.

Эхлээд сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Төмс хүнсний ногоон дээр ахиц их сайтай, ургацын хэмжээ их сайн нэмэгдэж байгаа. Төмс гэхэд л 33,3 хувиар, хүнсний ногоо 14 хувиар нэмэгдэж байгаа. Гэсэн хэдий ч бид импортоор авсан ногооны хэмжээ өндөр хэвээрээ байгаа. Нэлээн буусан, маш сайн буусан. Нийт 260-аад тэрбум төгрөгийн импортын уналтын нэлээн хэсэг нь ногоон дээр ноогдож байгаа. Гэхдээ бид 70-аад мянган тонн ногоо Монгол Улс импортоор авсан хэвээр байна. Жишээлбэл мөөг гэхэд л 20 сая долларын мөөг авч хэрэглэж байна шүү дээ. Тэгэхээр бид бусад төрлийн ногоог тарималжуулалтыг урамшуулах, хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх, зоорины чадавхыг нэмэгдүүлэх гэсэн арга хэмжээнүүд яваад байгаа. Энэ тоо дандаа манай талдаа бид экспорт нэмэгдээд, дотоодын хангалт нэмэгдээд л, импорт буураад л яваад байна. Ногоон дээр бол.

Өвөлжилтийн бэлтгэлийн хүрээнд орон нутагт энэ бүх төсөв хөрөнгүүд орон нутгийн өөртөө удирдах ёсны байгууллагын эрх мэдлийн хүрээнд бүрэн шилжсэн. Яагаад гэвэл малын хөлийн татвар, малын тоо толгойг зохицуулах эрхийг нь орон нутагт нь олгогдсон. Хэчнээн татвар тогтоохоо орон нутаг өөрөө мэднэ шүү дээ. Тэр орлогыг нь буцаагаад тэр мал аж ахуйд нь зарцуулах эрхийг нь орон нутагт нь өгчихсөн. Тэгэхээр хуучин бол Хөдөө аж ахуйн яам энэ өвс тэжээлийн нөөц бүрдүүлээд л мал мах худалдаж аваад л мах бэлдээд л ийм зүйл ерөөсөө байхаа больсон. Бүх эрх мэдэл төсвийн хуваарилалт орон нутагт буюу орон нутгийн удирдлага өөрсдөө зохион байгуулалт хангаж, бэлтгэл ажлаа хийж байгаа. Бид бол гол тариалалтын үр сорт, үрээр нь бодлогоор нь хангах, дэмжих ажлуудаа техникээр хангах дэмжлэгүүдээ хийгээд энэ жилийн тухайд ямар ч байсан тэжээлийн ургамал, тэжээлийн тариалалт бол

нэлээн их том дүнгээр сайжирсан. Энийгээ бол орон нутгууд татан авалтууд янз янзын хэмжээнд зохион байгуулагдаж байна. Борлуулалт их идэвхтэй байна. Бид нөгөө тэжээлийн үйлдвэрүүдийг бас их сайн дэмжиж байгаа. Тэжээлийн улсын хэмжээнд чинь бараг 50 орчим тэжээлийн үйлдвэрүүд үндсэндээ бий болоод байна. Тэрний бараг л 90 хувь нь төвийн бүсдээ л ажиллаж байгаа. Нөгөө тэжээл тариалалт дээрээ тулгуурлаад. Тэгэхээрээ гахай, тахиа, бусад сүү м махны, тэжээлийн олон төрлийн тэжээлүүд үйлдвэрлэл эрс нэмэгдэж байгаа. Ийм хэмжээнд бодлого явж байна даа. Тэрнээс малчны хотонд өвс тэжээл хүргэх, мал худалдаж авах асуудлууд дандаа орон нутгийн нийлүүлэлтийн асуудлууд орон нутгийн эрх мэдэл өөрөө шилжчихсэн.

Б.Бейсен: 6 номер. Мал эмнэлэг.

Б.Батсүх: Мал эмнэлгийн ерөнхий газрын Хяналт баталгаажуулалтын газрын дарга Батсүх асуултад хариулъя. Годрон өвчний халдвар гарч, бүртгэгдсэнтэй холбоотойгоор эндээс Мал эмнэлгийн ерөнхий газраас 3 чиглэлд ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Тандалтын хүрээгээ тодорхойлж байна. Тэгээд холбогдох тэмцэх зааврын дагуу арга хэмжээнүүдийг бол авч хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар Мал эмнэлгийн ерөнхий газраас нийт 10-аад хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж байна. Орон нутгийн 98 хүн гээд нийт 110 хүн яг энэ өвчний голомтыг устгах энэ арга хэмжээг бол орон нутагт зохион байгуулаад ажиллаж байна. Хэрэгжүүлж байгаа арга хэмжээний юу маань болохоор түрүүн бас гишүүн хэлж байна. Өвчний шинж тэмдэгтэй, өвчтэй малыг бол устгах арга хэмжээг бол газар дээр нь зохион байгуулж байгаа. Одоогийн байдлаар 9,9 мянган ямааг устгалд оруулсан. Өөрөө энэ өвчний онцлог юу вэ гэхээр худалдааны хорио.../минут дуусав/

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя.

Б.Батсүх: Устах арга хэмжээ маань болохоор энэ олон улсын байгууллагуудаас тавьдаг шаардлагын нэг байгаа. Дээрээс нь энэ өвчний өөрийнх нь онцлог бол тухайн өвчнөөр өвчилсөн малын 80-90 хувь нь шууд үхэлд хүрдэг ийм онцлогтой учраас устгах арга хэмжээ маань хамгийн оновчтой арга хэмжээ гэж үзээд, мэргэжлийн байгууллагын хариуцсан газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг орон нутагт ажиллаж байна.

Б.Бейсен: Энхбаяр сайд гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Мал эмнэлэг вакцины төсөв дутагдалтай байгаа. Тэгэхээр бид нар нөгөө тактикийн юмнууд нэлээн сайн нарийвчлаад л голомтыг богино хугацаанд л хүчтэй дарах, хүрээг тогтоох, 2 дахь хүрээгээ өргөн хийгээд л устгалыг хурдан хурдан хийгээд л нэг ийм арга хэмжээгээр л бид нар ингээд зохицуулалт хийж байна. Уг нь бүх нийтийн вакцинжуулалт хийгээд л нэг захаас нь ингээд л явах ёстой шүү дээ. Тэгэхээр төсөвтөө захирагдаад явж байгаа гэдгийг та бүхэн сайн ойлгоорой.

Б.Бейсен: Мэдээлэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Мэдээлэлтэй холбогдуулан уг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна. Замира гишүүн байгаа юм байна.

С.Замира: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ сая асуулт дээр уг нь асуух гэж байгаад утсаар ярьж байгаад хожимдсон байна. Энэ орон нутгийн сонгууль дуусаад нэлээд хугацаа өнгөрч байна. Орон нутгийн зарим засаг төр нь одоо хүртэл бүрэлдээгүй ингээд юу юугүй өвөл болж байна. Цас зуд болохгүй гэсэн баталгаа байхгүй. Ялангуяа манай Баян-Өлгий аймгийн хувьд өнгөрсөн

жилийн зудаар бол Булган сум ямар ч холбоогүй, тоггүй, цахилгаангүй, бүх юм нь тасарсан. Нэлээд хугацаагаар эмнэлгийн тусламж авах боломжгүй тийм байдалд хүрсэн шүү дээ. Тэгэхээр орон нутгийн төр засгийг хурдан бүрдүүлээд, аль болох тийм зудтай тийм холбоо тасрах газруудад өвс ногоо ялангуяа өргөн хэрэгцээний бараагаа хангаж өгөх тал дээр төр засаг, Хөдөө аж ахуйн яам анхаарах нь зөв болов уу гэж би бодож байна.

Тэгээд энэ мал, сүүний чанар муудсан гээд яриад байна шүү дээ. Экспортод гарахгүй байна. Үүний нэг гол шалтгаан нь нөгөө шавж хорхой устгана газар цацаж байгаа хор болоод тэр нь болохоор өвс, ногоогоо хордуулаад, тэр хордсон юуг мал идээд ингээд байдаг. Манай малын, сүүний бүх юмны чанар муудаад, тэгээд өвчин нь ихсээд байгаа юм биш үү. Яагаад гэвэл дархлаа гэдэг нэг юм хүнд бас байдаг даа. Тэрүүн шиг мал ч бас дархлаатай шүү дээ. Тэр дархлаа нь буунгуут тэгээд өвс ногоо нь болохоо байнгуут мал өвчин юунд их нэрвэгдээд байгаа болов уу гээд. Тэгэхээр зэрэг Хөдөө аж ахуйн яам, Байгаль орчны яам хоорондоо холбоотой байгаад ямар газарт яаж шавж хорхой устгах юм цацаж байна. Тэр цацаж байгаа химийн бодис нь яг чанарын шаардлага хангасан уу. Энэ бүгдийг нь ер нь тодорхой болгох нь зүйтэй болов уу гээд би бодож байна.

Тэгээд сая гишүүд ярьж байна. Өнгөрсөн жил 453,9 мянган мал хорогдсон байна шүү дээ. Тэр хорогдсон малыг нь бол малчид байхгүй хөдөө гээд тэгж байна. Тэгэхдээ тэр байгаа малчдыг малжуулж өгөх нь зүйтэй байх. Яагаад гэвэл тэд нар мэргэжлийн хүмүүс шүү дээ.

Тэгээд энэ малчид хөдөө эзгүйдсэн гээд яриад байгаа шүү дээ. Бид нар ялангуяа залуучууд очихоо байсан гээд. Энэ гол шалтгаан нь нөгөө бидний нөгөө бодлого алдагдсан 6 настай хүүхдийг хичээл сургуульд хамруулснаас болоод

тэр аав ээж нь заавал тэр 6 настай хүүхдийг байрлуулах газар нь байхгүй, байр нь байхгүй, тэгээд айлын гэрт сургах биш тэгээд залуучууд ихэнхдээ хот суурин газрыг бараадаад, тэгээд хөдөө дандаа нөгөө настайвтар хүмүүс нь үлдэж байгаа. Энийг бол ер нь манай Монгол Улсын хувьд бол 6 настай хүүхдийг хичээлд хамруулах тийм бэлтгэл нь ч яагаагүй, одоо сургуульд багтахгүй байгаад байгаа шүү дээ. Тэгээд энийг ер нь хуучнаараа нөгөө 8 наснаас 10 жил сурах боломжоороо яамнууд, засаг төр хоорондоо яриад энийг зохицуулж өгвөл яадаг бол. Ер нь яваандаа ингээд 6 настай хүүхэд сургуульд хамаарагдана гэх юм бол хөдөө ер нь малчид олдохгүй. Яагаад гэвэл тэр хүүхдүүдийг сургах тал дээр тэгээд явж байгаа шүү дээ.

Тэгээд энэ гурил, өвс ногоо бол хангалттай хэмжээнд хүрээгүй байна даа. Ялангуяа Баян-Өлгий аймгийн хувьд бол өөрсдөө.../минут дуусав/

Б.Бейсен: Ганбаатар гишүүн үг хэлнэ гэсэн.

Г.Ганбаатар: Түрүүн тэр сайдын юунд нөгөө тусгаарлагдсан мал аж ахуй мал бордох аж ахуй, тэжээлийн үйлдвэрлэл, малын хөлийн татвар, ялангуяа тэр олон мянган адуунаас огт ашигладаггүй мөртөө нэг чамирхдаг юм уу, яадаг юм, баярхдаг юм уу тэр Хэнтий, Дорнодыг дамнасан тэр адуу тэрнээс татвар авах дээр бол санал нэг байгаа шүү. Үнэхээрийн энэ бэлчээр талхлалд юу бол арай дэндүү байгаа. Нөгөө талдаа 2 зүйл байгаа юм. Тэр хүүгийн зөрүүний мөнгө би Монголбанкнаас түрүүн асууж байсан байхгүй юу. Тэгэхэд энэ 3 сарын 1-ээс ирэх оны 3 сарын 1 хүртэл малчдын хүүг чөлөөлсөн юм байна лээ шүү дээ. Зээлийнх нь хүүг тэгээд тэр хүүгийн зөрүүнд нь 77,3 тэрбум. Тэгээд ирэх жилээс төлье гэхэд юу ч байхгүй байгаа байхгүй юу. Тэр сая 8,1 сая мал алдсан гээд байгаа тэр олон малчин өрх чинь юу

ч байхгүй. Тийм учраас яаралтай малжуулах талын тэд нар чинь туршилага нь байна. Бэлчээр нь байна. Хаашаа хороо нь бүх юм нь байгаа байхгүй юу. Ганцхан мал нь л байхгүй болчихоод байгаа юм. Энэ чиглэл рүүгээ нэлээн сайн ажиллаж анхаараарай гэж санал хэлэхээр байна.

2-т нь тэр шинэ хоршоо л гээд байгаа юм. Шинэ хоршоо чинь бол яг үнэндээ зүгээр малтай малчдыг малыг нь барьцаалаад, хөрөнгөтэй хүнийг малыг нь барьцаалж бага хүүтэй зээлийн хүүгийн зөрүүг нь юу яагаад бага хүүтэй зээл олгож байгаа болохоос биш малгүй хүмүүсийг ерөөсөө дэмнэх бодлого биш шүү дээ. Энэ чиглэл рүү бас үүнтэй холбоотойгоор танай яам дээр яригдаж байгаа түрүүнд өөрөө бас нэг дурсаж байх шиг байсан. Жижиг, дунд үйлдвэрлэлийн сангийн эх үүсвэрийг нь жоохон нэмэгдүүлбэл зүгээр юм болов уу гэж бодож байгаа шүү. Тэр хоршоо хөгжүүлэх сан гэж сумдад байгаа. Түүнийг нь дэмжвэл бас энэ яг хоршоод малгүй болсон. Хоршоо хөгжлийн сан чинь болохоор арай нөхцөл нь өөр байхгүй юу. Шинэ хоршооноос өөр. Тэгээд энэ мэтээр ингээд бодлого явуулбал арай дээр болов уу гэж бодож байна. Тэгээд энэ бүгдийг анхаарч ажиллаарай гэж хэлье.

Б.Бейсен: Өвөлжилтийн бэлтгэл ажил, ургац хураалттай холбоотой Хүнс, хөдөө аж ахуйн яамны мэдээллийг сонслоо.

Ер нь өвөлжилтийн бэлтгэл ажил, зуд гээд засагтаа чихэх биш ер нь Хөдөө аж ахуйн яамныхан аймгуудын хөдөө аж ахуйн газрууд байна. Манай байнгын хороотой хамтраад эртхэн шиг өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах, хангуулах тал дээр анхаарч ажиллая. Яагаад гэвэл өнгөрсөн жил та бүгд мэдэж байгаа. Тэр өвөлжилтийн бэлтгэл ажил дээр чинь анхаараагүй. Тэгээд өвлийн зудын үед бэлдээгүй аймгууд гарсан. Нөгөө талаар энэ жил цас эрт

орчихлоо. Энэ жил ч хатуухан өвөл болох янзтай байна. Тийм учраас энэ отрын бүс, хил орчмын отрын асуудал байж байна. Тусгай хамгаалалттай газрууд байж байна. Энэ дээр нэлээн анхаараад зөвшөөрлийг нь тухайн аймаг сумын түвшинд сайн яриад эртхэн шиг тохирохгүй бол бас л хүндрэл гарна. Ноднин нэг аймагт тэр тусгай хамгаалалттай газар очсон малчдыг сум нь зөвшөөрчхөөд сүүлдээ Байгаль орчны яамныхан 3 сая төгрөгөөр торгоод л мал нь хорогдоод ийм хохирол гарсан. Тийм учраас энийг эртхэн зохицуулах талын асуудал дээр Хил хамгаалах ерөнхий газрууд байж байна. Тэгээд энэ бэлтгэл хангуулах тал дээр манай Байнгын хорооны гишүүд бас аймгуудаар явъя гэвэл хамтраад явахад бэлэн байгаа. Хамтарч ажиллая. Ер нь зудын үед л их хэмжээний улсаас хохирол зардал гардаг. Энийг аймаг, сум, улсын түвшинд, аймаг, сумын түвшинд энийг эрт хангуулах тал дээр хамтарч ажиллаад, 11, 12 сард бас биелэлтийн ажил хангуулах тал дээр Хөдөө аж ахуйн яамныхан бас санаачилга гаргаад, манай Байнгын хорооноос санаачилга гаргаад л ер нь яваад энэ аймгууд дээр нэг шаардлага тавихыг та бүгдэд уриалж байна.

Гишүүд үг хэлж, мэдээлэлтэй холбоотой асуулт асууж дууслаа. Хөдөө аж ахуйн яамныханд баярлалаа гэж хэлье.

13.33 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, салбарын үйл ажиллагааны талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсьё.

Ажлын хэсгийг нь оруулъя. Ажлын хэсгийг танилцуулъя.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Салдангийн Одонтуяа, Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ахлах зөвлөх Ламбаа, Усны газрын дарга Батбаяр, Ойн газрын дарга Оюунсанаа, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга Оюунжаргал, Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн сайдын зөвлөх Уртнасан, Байгалийн нөөцийн бодлого хэрэгжилтийн газрын дарга Уранчимэг, Хүрээлэн буй орчны бодлого хэрэгжилтийн газрын дарга Энхмөнх, Тусгай хамгаалалттай газрын бодлогын хэрэгжилтийн газрын дарга Батцогт, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Нямхүү, Салбарын хяналтын газрын дарга Мөнхтогтох, Хуулийн хэлтсийн дарга Солонгоо, Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга Цогтсайхан, Мэдээллийн сан, кадастрын хэлтсийн дарга Мөнхбаатар ирээгүй юм уу. Ийм ажлын хэсэгтэй байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, салбарын үйл ажиллагааны талаарх мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Одонтуяа танилцуулна.

С.Одонтуяа: Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тус байнгын хорооноос 7 чиглэлээр танилцуулга хийх үүрэг өгөгдсөний дагуу бид энэ чиглэлээр 40 гаруй хуудас дэлгэрэнгүй материал бэлтгэж, Байнгын хороонд хүргүүлсэн тул товчхон мэдээлэл хийе.

Манай салбарт 1 дүгээрт салбарын болон салбар дундын 43 хууль тогтоомж, 90 захиргааны хэм хэмжээний акт мөрдөгдөж байна. Монгол улс байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр 12 олон улсын

гэрээ конвенц, 5 протоколд нэгдэн орсон байдаг. 2024 оны байдлаар байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарын 87 байгууллагад улсын хэмжээнд 3184 албан хаагч ажиллаж байна. Салбарын 2024 оны төсөв 240,2 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд энэ нь дотоодын нийт бүтээгдэхүүний 0,35 хувийг эзэлж байна. Энэхүү төсвийн 80 орчим хувь нь цалин болон бусад урсгал зардалд зарцуулагдаж, байгаль хамгааллын менежментийн арга хэмжээг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй хэвээр байна.

Монгол Улсын Засгийн газрын бүтцээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамыг 9 газар, 10 хэлтэстэйгээр байгуулан ажиллаж байна. Яамны гол үйл ажиллагаа нь 5 чиглэлээр явагдаж байна.

1.Уур амьсгалын өөрчлөлтийн тухайд:

Монгол Улс газар зүйн байршлын хувьд дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг, хамгийн өртөмтгий орнуудын нэг юм. Сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд агаарын жилийн дундаж температур 2,4 хэмээр дулаарч, мөнх цас, мөсөн голын хэмжээ 29,9 хувиар буурч, цэвдэг хайлж багасаж байгааг судлаачид тогтоогоод байна.

Монголын төр энэ байдалд дүгнэлт хийж, урт, дунд хугацааны бодлого чиглэлээ тодорхойлж, дэлхийн 200 гаруй улс нэгдэн орсон Парисын хэлэлцээрийг 2016 онд соёрхон баталж, үндэсний зорилтоо тодорхойлсон. Тухайлбал, хүлэмжийн хийн ялгарлын 2030 он гэхэд 22,7 хувиар бууруулах зорилтыг хэрэгжүүлж байна. Хөгжлийн жилийн төлөвлөгөө болон 2025 оны улсын төсөвт салбарын хэрэгжүүлэх зорилт арга хэмжээг тодорхой тусгасан.

2.Цөлжилт, газрын доройтлын тухайд:

Цөлжилтийн төлөв байдлын үнэлгээг 5 жил тутамд хийдэг. 2020 онд хийсэн цөлжилтийн үнэлгээгээр Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76,9 хувь буюу 120,3 сая га талбай бүхий газар нутаг цөлжилтөд тодорхой хэмжээгээр өртсөн байна. Үүний 23 хувь буюу 30 орчим сая га талбай цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж байна. Сүүлийн 30 жилд мал сүргийн тоо толгой 3 дахин нэмэгдэж, бэлчээрийн даац хэтэрсэн. Уул уурхай эрчимтэй хөгжиж, эвдэрсэн газрын тоо хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна. Хот, суурин газрын хөрсний бохирдлын гол эх үүсвэр нь Улаанбаатар хотын хөрсний бохирдол, эко геохимийн судалгаагаар 360 цэгээс сорьц авч шинжлэхэд 88 хувьд нь нян, хөгц, мөөгөнцөр илэрсэн байдаг. Боловсруулах үйлдвэр, машин засвар, хогийн цэгийн ойр орчмын хөрсөнд хар тугалга, хром, цайр зэрэг хүнд металлын бохирдол их байна.

3.Орчны бохирдлын асуудлын тухайд:

Агаар бохирдуулагч эх үүсвэр үүрийн тооллогоос харахад Улаанбаатар хотод 2023 онд 697 мянган хөдөлгөөнт эх үүсвэр буюу автомашин тоологдсон ба өмнөх оноос 8,2 хувиар нэмэгдсэн байна. 2024 оны 1 дүгээр сарыг өмнөх оны дундаж агууламжтай харьцуулахад Пи Эм 10 тоосонцор 5 хувиар, хүхэрлэг хий нь 10 хувиар, 2.0 тоосонцор 4 хувиар, азотын давхар исэл нь 11.11 хувиар тус тус их байна.

4.Хог хаягдлын тухайд:

Хог хаягдлын бүтэц өөрчлөгдөн хэмжээ нь жилээс жилд өсөж, 2,2 сая тоннд хүрсэн байна. 2023 онд энгийн хатуу хог хаягдлын 63,7 хувийг өрхийн хог хаягдал, 36,3 хувийг аж ахуйн нэгж, байгууллага зам талбай, бусад газраас цуглуулсан хог хаягдал эзэлж байна. Аюултай хог хаягдлын хэмжээ 2023 онд 1 сая тонн болж 281 хувиар өссөн байна.

5.Цаг уур орчны хяналт шинжилгээний тухайд:

Монгол Улсад 2023 оны байдлаар Цаг уурын шинжилгээний 318 өртөө харуул, агаар мандлын дээд давхаргыг судлах 4 станц, шар шороон шуурганы 9 станц, хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах 2 станц, цаг уурын доплерын радарын 1 станц, ус судлалын шинжилгээний 155 өртөө харуул, орчны хяналт шинжилгээний 22 лаборатори, агаарын чанарын хяналтын 36 станц, хүчиллэг тунадастын 1 харуул, усны чанарын хяналтыг 184 цэгт, хөрсний чанарын хяналтыг 1550 цэгт дээж авч шинжилгээ хийж байна. Энэ хүрээнд тавьж буй зорилтуудыг товчхон танилцуулъя.

Судалгаа шинжилгээний ажлын үр дүнг нэмэгдүүлж, уур амьсгалын сөрөг үр дагаврыг арилгах, бууруулах. Шинжлэх ухаанд суурилсан бодлогын оновчтой шийдвэр гаргах. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын үндэсний сүлжээг өргөтгөх, орчин үеийн шинэ технологийг нэвтрүүлэх, автоматжуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний нөөц, нийгмийн баталгааг сайжруулах зайлиггүй шаардлага тулгарч байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын тухайд Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 21 хувь буюу 32,8 сая га талбайг улсын тусгай хамгаалалтад хамруулж, нэгдсэн сүлжээг бүрдүүлээд байна. Олон улсын хэмжээнд санаачлан хэрэгжүүлж байгаа газар нутгийг тусгайлан хамгаалах 30 ба 30 санаачилгыг Монгол Улс 1992 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Цаашид олон улсын чиг хандлагын дагуу Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувийг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын

намрын чуулганаар батлуулах. Бид Улсын Их Хуралд өргөн барихаар энэ хуулийг бэлтгээд байна.

6.Усны нөөц ашиглалт, бохирдлын тухайд:

Монгол орны усны нийт нөөцийн 564км³ бөгөөд үүний 90 гаруй хувийг гадаргын ус, 1,91 хувийг газрын доорх ус бүрдүүлж байна. Улсын хэмжээнд 2023 оны байдлаар 679 сая шоо метр ус ашиглаж байгаагийн 50 гаруй хувийг газрын доорх усаар хангаж байна. Ус хэрэглэгчдийн хэтийн төлөвөөс харахад 2030 онд усны хэрэглээ 3-4 дахин нэмэгдэхээр төлөвтэй байна. Тулгамдсан асуудал гэвэл улсын хэмжээнд баталгаат ундны ус хангамж ариун цэврийн байгууламж хүрэлцээгүй байна. Үйлдвэрлэлийн хэрэгцээт усны нөөц хомс байна.

7.Ан агнуурын талаар баримталж буй бодлогын үйл ажиллагааны тухайд:

Цаашид авах арга хэмжээг нь танилцуулчихъя. Амьтны тархац нөөцийн судалгааг тодорхой давтамжтай хийж байгаа боловч ямар амьтдыг хэдэн жилийн давтамжтай судалгаа хийх зохицуулалт байхгүй байна. Тиймээс цаашид улсын хэмжээнд үе шаттай тогтсон давтамжтайгаар хийж, нөөцийг зөв тогтоох, зохистой менежмент хэрэгжүүлэх, агнуур зохион байгуулалтын судалгааны явцад хяналт тавих.

8.Геологи уур уурхайн холбогдолтой эрэл хайгуул, ашиглалтын ажилд тавих байгаль орчны хяналтын тухайд:

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд байгаль орчны хяналт шалгалтыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх хэлбэрээр хийж гүйцэтгэж байна. Улсын хэмжээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар уул уурхайн үйл ажиллагаа

явуулж буй 117 аж ахуйн нэгжид байгаль орчны хяналтын чиглэлээр хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 164 заалт бүхий албан даалгавар өгч, 19 аж ахуйн нэгжид эрх хязгаарлах арга хэмжээ авч, 4 аж ахуйн нэгжид албадлагын арга хэмжээ авхуулахаар шүүхэд шилжүүлсэн байна. Мөн 448 сая төгрөгийн торгох шийтгэл, 2,5 тэрбум төгрөгийн байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн төлбөр оногдуулан ажиллаж байна.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилт явцын талаар:

2024 оны эхний хагас жилийн байдлаар 50,6 сая модыг тарьж, зохих арчилгаа хамгааллын ажлыг гүйцэтгэж байна. Намрын мод тарих ажлын хүрээнд 60 сая дахь модыг тарихаар төлөвлөн мод тарих ажиллагаанууд үргэлжилж байна. 2021-2024 оны хугацаанд 120 сая мод тарихаар төлөвлөгдсөн бөгөөд гүйцэтгэл нь 42,4 хувьтай байна. Улаанбаатар хот болон аймгууд 680 сая мод тарихаар амлалт авч, гэрээ байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 3 агуулгаар нийт 27 зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөж оруулсан. Биологийн олон янз байдлыг хамгаалах үндэсний төлөвлөгөөг Засгийн газраар батлуулж, 23 зорилтыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж, олон улсын санхүүжилт, хяналт, үнэлгээ, тайлагналын тогтолцоог хэрэгжүүлэх, хүний нөөцийн чадавхыг сайжруулах, нутгийн иргэд, орон нутгийн нөхөрлөлийн уламжлал, соёл, эрхийг хамгаалж, байгаль хамгааллын үйл ажиллагаанд хамтын менежментийн шинэлэг арга хэлбэрийг нэвтрүүлнэ.

Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. Байгаль орчны цахим дижитал шилжилтийг хийж,

дэвшилтэт технологийн хэрэгцээг тодорхойлж, шинэ технологийг нэвтрүүлнэ.

Салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шинээр 2, шинэчилсэн найруулгаар 5, нэмэлт, өөрчлөлт оруулахаар 7 хууль, нийт 14 хуулийг боловсронгуй болгоно.

Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлд тулгуурласан стандарттай байгаль орчны салбар хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Хог хаягдлаас үүдэн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулж, хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагаагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгож, татварын бодлогоор дэмжинэ.

Бид энэ зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө шаргуу хөдөлмөрлөж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Бейсен: Одонтуяа сайддаа баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан танилцуулсан асуудалтай холбоотой асуулт асуух гишүүн байна уу. Нэрс өгье. Батчимэг гишүүнээр тасалъя. Ундраа гишүүн орохгүй байгаа юм уу. Ундраа гишүүнээр тасалъя. Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ нэг говийн бүсийн хэдэн аймгууд, ер нь манай Монгол улсын нутаг дэвсгэрийн урд талын хэсэг аймгууд л цөлжилт, газрын доройтолд их хэмжээгээр үлэмж, нэн хүчтэй өртсөн гээд ингээд судалгаанууд жил болгон гардаг. Энэ талаар ер нь ямар арга хэмжээнүүд ирэх он, жилүүдэд зохион байгуулахаар, бид нар энэ газрын доройтлоос яаж гарах юм бэ. Гарах боломж ер нь байгаа юм уу гэдэг тал дээр энэ салбарын яам ямар арга хэмжээнүүд зохион байгуулж байна гэдгийг тодотгож асууж байна.

Бас нэг юм энэ аюултай бодис гэх юм уу нөгөө тэсэрч дэлбэрдэг янз янзын химийн гаралтай ийм бодис бүтээгдэхүүнүүдийн агуулдаг агуулахыг тухайн үйлдвэр барьж байгуулахын тулд орон нутгийн байгаль орчны газраасаа тусгай зөвшөөрөл авдаг юм шиг байгаа юм. Тэгээд энийгээ авах гээд Байгаль орчны газар санал өгөхлөөр аж ахуйн нэгж саналаа өгөхлөөр зэрэг манай Байгаль орчны газраас юу гэдэг вэ гэхээр бид нар мэргэжлийн хяналтын байгууллага чиг үүргээ өөрчилснөөс болоод яамтай зарим мэргэжилтнүүд нэгдэж тэр чиглэлийн мэргэжилтнүүд газар луу очсон шүү дээ. Тийм ээ. Тэгэнгүүт 1 тийм журам шинээр боловсруулагдах ёстой. Тэр журам нь боловсруулагдаагүй гэдэг ийм харуу өгөөд тусгай зөвшөөрлийг нь олгодоггүй юм байна. Тэрнээс болоод нөгөө орон нутагт жишээ нь ноос угаах үйлдвэр байгуулагдаад нөгөө үйлдвэрлэлээ явуулах гэхээр зэрэг шаардлагатай бодисоо хадгалах сав байдаггүй. Ажлаа явуулахын тулд нөгөө журмыг хүлээсээр байгаад нөгөө бодисоо авчраад хадгалаад явсан чинь экологийн цагдаа манай байгаль орчны байцаагч нар очоод хэрэг үүсгүүлчихсэн. Прокурортой нийлж байгаа. Тэгээд нөгөө орон нутагт үйлдвэрлэл үйл үйл ажиллагаа явуулах гэж байгаа аж ахуйн нэгжүүдийнхээ үйл ажиллагааг ингээд боомлоод байгаа ийм нэг дүр зураг байна. Бүр тодорхой жишээгээр хэлж болж байгаа. Тэгэхээр энэ журам нь хэзээ батлагдах юм бэ. Энэ ер нь батлагдчихаад өгөхгүй байгаа юм уу. Мэргэжлийн хяналт салаад танай руу очоод хэдэн жил болж байгаа юм. Энэ хооронд яагаад энэ журам нь батлагдахгүй байгаа юм бэ гэдгийг нь асуух асуулт байна.

2 дугаарт энэ тэрбум модтой холбоотой зарим аймгуудын мод үржүүлгийн газрын хүчин чадал тарьц, суулгац, мэргэжилтэй боловсон хүчний нөөц дутмаг тэгээд үндэсний хөдөлгөөний хэрэгжилт хангалтгүй байгаа учраас бодлогын дэмжлэг үзүүлэх

хэрэгтэй байна гэж байна. Энийг яаж үзүүлэх гэж байгаа юм. Говийн бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн.../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхбат гишүүнд 1 минут.

Ц.Мөнхбат: Уул уурхайн аж ахуйн нэгжүүд энэ Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд бас хамтдаа оролцох ёстой. Ийм үүрэг хүлээсэн. Өмнөговь аймагт явуулдаг томоохон уул уурхайн аж ахуйн нэгжүүд зөвхөн Өмнөговьдоо биш, энэ говийн бүсийн 4 аймагт дөрвүүлд нь оролцох ёстой. Гэтэл нөгөө аж ахуйн нэгжүүд нь яадаг вэ гэхээр хэдэн суулгац өгөөд хаячихдаг. Тэрийг арчлах хамгаалах зардал гэж байхгүй. Хашаа хороо юу ч байхгүй. Нөгөө хэдэн суулгац өгөөд, тоол нэмээд байдаг. Ингээд 50 мянган суулгац өглөө. 20 мянган суулгац өглөө гээд. Тэгэхээр зэрэг энэ юмнуудыг давхард нь шийдүүлдэг байхыг салбарын яам маань зохион байгуулж, чиглүүлж өгөх ёстой биш үү. Энэ тал дээр ямар арга хэмжээ авдаг вэ гэдэг ийм санаануудыг асуух гэсэн юм.

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Манай хүмүүс нэмээрэй. Тэр аюултай хог хаягдал модон дээр. Монгол Улс энэ цөлжилтийн асуудал бол ер нь бол нэлээд гамшигийн хэмжээнд хүрсэн гэж хэлж болно. Энэ асуудал дээр 2, 3 хоногийн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч яаралтай ажлын хэсгийн хуралдаан зарлаж, энэ асуудлыг бас сонссон байгаа. Одоо удахгүй Улсын Их Хурлаар Хөрсний доройтол, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гэж бэлдэж байсан. Энийг Монгол улсын Ерөнхийлөгч цөлжилтөөс урьдчилан сэргийлнэ гэж байхгүй. Одоо бид нар бүр тэмцэнэ гэж энэ хуулийг оруулж ирнэ. Ингээд энийг Монгол улсын Ерөнхийлөгч өөрөө өргөн барихаар энд бол маш том ач холбогдол өгөөд, энэ хуулийн төсөл ер нь бэлтгэгдээд бараг бэлэн болж байгаа. Цаашид цөлжилтийн

талаар хэд хэдэн чухал арга хэмжээ авна.

1 дүгээрт энэ 2026 онд Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг манай орон зохион байгуулна. Энэ хурал бол яах вэ. Мэдээж бас зардал гарах хэдий ч сайн талууд бол байгаа. Ямар сайн талууд байгаа вэ гэхээр жишээлэхэд цөлжилтийн бага хурлыг зохион байгуулсан орнуудад бол урт хугацаанд маш том том хөрөнгө оруулалтууд бол орж ирдэг. Жишээлэхэд Бүгд Найрамдах Энэтхэг улс 2019 онд зохион байгуулаад бүүр 26 сая га газрыг нөхөн сэргээх амлалт бүхий ийм төсөл тэнд шийдэгдсэн. Дараа нь Комтедуар улсад бас энэ ногоон хэрэм байгуулах 10 жилийн хөтөлбөр гээд 2,5 тэрбум долларын төсөл болсон байх жишээтэй. Тэгэхээр энэ бол олон улсын арга хэмжээ Монгол орны энэ цөлжилтийг дэлхийн анхаарлын төвд авчрах утгаараа бол их чухал ийм арга хэмжээ болно.

Мөн 2026 оныг бэлчээр нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн жил болгохыг санаачилга гарч байгаа. Энэ дээр бол ер нь энэ бэлчээрийн хомсдол, цөлжилт гэсэн энэ асуудлыг бол нэлээд чухалчлан авч үзнэ.

Мөн цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах төрөөс баримтлах бодлого хөтөлбөрийг боловсруулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачилж, Улсын Их Хурлаар батлуулах шаардлагатай байгаа.

Мөн Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц болон Парисын хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжилтийг хангах ажил дээр бид нэлээдгүй ажлуудыг хийж байгаа. Тэгэхээр цөлжилтөөс бас урьдчилан сэргийлэх тэрбум модны санаачилга бол маш чухал үүрэг гүйцэтгэж байгаа. Энэ дээр бол тэрбум модны хүрээнд сая би бас говийн аймгуудаар явж нэлээн судаллаа. Тэнд

нэг хэцүү асуудал нь гэвэл боловсон хүчний дутагдал байна. Ерөөсөө боловсон хүч олдохгүй. Тэнд ажиллах хүч олдохгүй ийм байгаа. Тэгээд энийг түрүүн Байнгын хороо дээр хэлсэн учраас энэ дээр бид нар бас нэлээд чухал ажлуудыг Улсын Их Хурлын гишүүдтэйгээ хамтарч бас санаачилж хийхгүй бол ерөөсөө боловсон хүчний бодлого энд маш хүнд байна.

Нийт Монгол Улсын хэмжээгээр 425 нэгж дээр мод тарьж байна. Монголчууд бол бас энэ санаачилгын хүрээнд мод тарих маш эрмэлзэлтэй болсон байна. Тарьж чадаж байна. Бүгдээрээ ингээд нарийн усалгаатай болж эхэлсэн байна. Говьд ч тарьж байна. Хангайд ч тарьж байна. Энэ дээр манай ойн хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг үзүүлж ирсэн. Энэ дээр бол нэлээдгүй том хөрөнгө оруулалтуудыг бол хийж байгаа. Тэгэхээр би энэ жил яамныхантайгаа юу гэж ярьж байгаа вэ гэхээр 2024 онд бид нар нэлээд том том аж ахуйн нэгжүүдийг бас дэмжлэг үзүүлсэн. Өөрөөр хэлбэл том том суулгац бэлтгэдэг газрууд бол олон том аж ахуйн нэгжүүд бий болсон. 2025 оныг дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдээ дэмжье. Нийтлэгээр нь нэг газар их хэмжээний мөнгө санхүүжүүлэх биш, дунд хэмжээний газруудаа дэмжлэг тусалцааг маш сайн үзүүлье. Энэ мөнгийг нь.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер. Төрийн нарийн бичгийн дарга нэмж хариулъя.

Э.Баттулга: Мөнхбат гишүүний асуусан химийн бодистой холбоотой асуудлаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн тушаалаар хүлээгдэж байсан журам батлагдсан. Үүгээр аймаг, нийслэлийн байгаль орчны газрын улсын байцаагч нар дүгнэлт гаргах боломжтой болсон байгаа. Тэгэхээр энэ гацаа 9 сарын 12-оос хойш гарсан. Цөлжилттэй холбоотой асуудал дээр бас бид нар олон талт арга

хэмжээнүүдийг зохион байгуулж байгаа. Жишээлбэл үүний нэг нь бол ХХААХҮЯ-тай хамтраад Шинэ хоршоо, Сайн малчин гээд энэ янз янзын хөдөө аж ахуй, малчдад чиглэсэн бодлогын арга хэмжээнүүд дээр нь байгаль орчны суурь шаардлагуудыг тавьж өгье. Ер нь малын тоогоор биш, чанараар урамшуулдаг, тэтгэмж авдаг, ногоон зээлд хамрагддаг ч гэдэг юм уу ийм боломжуудыг гаргаж өгч байгаа. Яамны хувьд хамгийн хийх гэж зорьж байгаа том бодлогын зорилт бол бид нар энэ цаг агаарт зориудаар нөлөөлөх.../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхбат гишүүн тодруулъя.

Ц.Мөнхбат: 9 сарын 24-ний өдөр журам гарсан юм байна. Одоо тэгээд энэ журмаас өмнө өгсөн санал, хүсэлт журам гараагүй байснаас болоод хэрэг болоод үүсээд явж байгаа. Энэ дээр ямар зохицуулалт хийж өгөх вэ. Журмаа нөхөж үзүүлээд жишээ нь явах ёстой юм уу. Байгаль орчны газар нь манай журам батлагдлаа гээд нөхөж өгөх ёстой юу. Нөгөө аж ахуйн нэгжүүдээ. Тэр дээр ямар юутай байдаг юм.

2 дугаарт нь энэ уул уурхайн аж ахуйн нэгжүүдийг сая Одонтуяа сайд хэлчихлээ. Ер нь ингээд өнгөрсөн хугацаанд бол яг үнэндээ бол уурхайн аж ахуйн нэгжүүд ч гэсэн бодит байдал дээрээ энэ Тэрбум мод санаачилгатай бол сайн ажиллаагүй. Манайх дээр жишээ нь, Дундговь аймгийн хувьд Эрдэнэт үйлдвэр 50 га дээр агро паркийн ТЭЗҮ хийнэ гээд л 4 жил болсон. Одоо дуусаагүй л байгаа. Тэгэхээр энэ уул уурхайн томоохон аж ахуйн нэгжүүдийг нэгэнт Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгыг дэмжээд, бас үүрэг хүлээгээд гарын үсэг зурчихсан ийм аж ахуйн нэгжүүдийг.../минут дуусав/

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтээр маш дэлгэрэнгүй тайлан гарсан. Саяын хэлдэг том том аж ахуйн нэгжүүд жишээлэхэд Эрдэнэт үйлдвэр, Оюутолгой энэ аж ын нэгжүүд ямар амлалт аваад хэдэн хувиа биелүүлсэн, биелүүлээгүй гэдгийг маш нарийн гаргасан. Аймгууд бас амлалт үүрэг авсан, хэдэн хувь биелүүлсэн гээд нарийн гарсан. Энийг би танд бас шаардлагатай гэвэл хүргүүлье. Нэг чухал асуудал бол энэ бид хөв цөөрөм олноор байгуулах асуудал байгаа. Тэгэхээр энэ хөв цөөрмийг байгуулах 333 сум санаачилгыг 2025 онд бид нар нэлээд өргөн хүрээнд хэрэгжүүлэх юм. Тэгэх юм бол ялангуяа энэ говийн бүсэд гадаргын усыг хуримтлуулах энэ ажил дээр бол нэлээд ахиц бол гарна. Тэгээд манайд зөвхөн говийн бүсэд усны асуудлыг шийдэх ажлын хэсэг гаргаад манай Уртнасан зөвлөх энэ ажлын хэсгийг ахлаад ажилласан. Эхний дүгнэлтүүдийг бүгдийг гаргасан байгаа. Би бас говийн бүсээс сонгогдсон гишүүдэд бас хүргүүлчихье.

Б.Бейсен: 2 номер хариулъя.

Б.Оюунсанаа: Мөнхбат гишүүний асуултад нэмж хариулъя. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын дарга Оюунсанаа байна. Тэгэхээр бид говь цөлийн бүс рүү бол онцгойлон анхаарч байгаа. Цөлжилт хамгийн их өртөж байгаа аймгууд, бүсүүд маань өмнийн 4 аймаг тэгээд баруун тийшийгээ энэ урдуур байгаа аймгууд бий. Ерөнхийдөө Их нууруудын хотгорын яг цөлжилт салхины коридорыг дагасан энэ аймгууд маань маш ихээр өртдөг. Тэгээд бид Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд томоохон амлалт авсан уул уурхайн компаниуд болох Эрдэнэс Тавантолгой, Оюутолгой, Эрдэнэт үйлдвэрүүд дээр онцгойлон говийн бүсүүд дээр тодорхой хуваарилалтууд өгсөн байгаа. 30-аас доошгүй хувийгаа яг энэ аймгууд дээр хийнэ гээд. Тухайлбал Эрдэнэт үйлдвэр гэхэд Дундговь дээр,

Оюутолгой компани гэхэд Өмнөговь дээр, бусад компаниудыг түр орхиод ярихад. Жишээ нь 5 мод үржүүлгийн газар жилдээ 1,5 саяас доошгүй тарьц, суулгацыг үйлдвэрлэдэг ийм мод үржүүлгийн газруудыг байгуулаад сая хүлээж авсан байж байгаа. Тэгээд энэ мод үржүүлгийн газрууд нь үйл ажиллагаа явуулаад ирэхээр тарьц суулгацыг нь буцаад тэр уул уурхайн компаниуд авч.../минут дуусав/

Б.Бейсен: 2 номер гүйцээж хариулъя.

Б.Оюунсанаа: Мөн түүнчлэн бас Говьсүмбэр аймаг дээр бас Эрдэнэт үйлдвэрээс тодорхой юунуудыг тавьсан байж байгаа. Тоонуудын моднуудыг. Жишээ нь 5 сая модыг Говьсүмбэрт гээд. Дундговь түрүүн хэлсэн. Өмнөговь дээр бол мөн түүнчлэн ингээд дэд бүтцүүдийг бий болгохоор. Дараагийн ирэх жил дээр бас бүсийн ийм аймгууд дээр тухайн нөгөө байгаль цаг уурынх нь нөхцөл дээр таарч бид нар тарилтыг хийнэ. Хаа хамаагүй газар бас тарихгүй учраас ТЭЗҮ, нарийвчилсан судалгаа юмнууд бол тодорхой бүсүүдээр хийгдсэн. Гол нь уур уурхайн компаниудтай уяад ширээний ард суугаад энэ ажлуудыг ингээд урагшаа явуулж байгаа гэж хэлье. Баярлалаа.

Б.Бейсен: Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: 3 асуулт байна. Хог хаягдал дахин боловсруулах асуудал дээр нэг зүйлийг асуухад хогоо ангилаад хаяж болж байгаа боловч яг цаанаа очихоороо ангилсан байдлаар нь дахин боловсруулах тийм үйлдвэр нь байхгүй. Тийм боломж байхгүй гэсэн хариутай байгаад байдаг. Тэгэхээр энэ дээр ямар бодлого хэрэгжүүлж байгаа вэ. Танай дээр хамаарахаар байна уу. Эсвэл нийслэл рүү эсвэл яг аймаг аймаг руу нь явахаар байдаг юм болов уу. Энэ дээр хариулт авъя.

Хоёрдугаарх нь болохоороо усны олдоц цөлжилттэй холбоотой усны түвшин бууралт гээд нөгөө дандаа усыг хэлбэр хэмжээгээс нь ингээд яриад байдаг. Тэгэхдээ нөгөө танай яамныхан бол мэргэжлийн хүмүүс ихтэй учраас бүгд энийгээ сайн яриад байвал хүмүүс нэг зүйлийг ойлгохоор байгаа. Тэр нь болохоор газрын доорх ус болгон цэнгэг биш. Ямар гүнээс гарч байгаагаасаа шалтгаалаад давстай байна. Унданд хэрэглэж болно, болохгүй гээд. Тэгээд унданд хэрэглэж болохгүй усыг үйлдвэрлэлд ашиглах ёстой байхгүй юу ер нь бол. Тэгээд зүгээр 2019 оноос авхуулаад Шинжлэх ухааны академи, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтраад аймгуудын ундны усны худгуудыг шинэчилсэн юм билээ. Тэгээд та хэд маань Шинжлэх ухааны академиас мэдээллээ авч байгаа байх. Би нөгөө Их Хурал дээр Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ундны ус болоод ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хүрээнд хууль, эрх зүйн орчны хэрэгжилтийг үнэлэх ажлын хэсгийг ахалж байгаа учраас мэдээллүүдийг энэ Шинжлэх ухааны академиас татсан юм. Тэгээд Өмнөговь аймгийн сорьцуудыг нь харж үзсэн юм. Тэгээд Өмнөговь аймгийн 15 сумаас хамгийн багадаа 2 худгаас нь ингээд усны чанарын асуудлыг нь 73 сорьцод аваад үзсэн чинь зөвхөн 22 худгийг нь л шууд унданд хэрэглэж болно. 13-ыг нь унданд хэрэглэж болохгүй гэх мэт хариунууд гарсан байгаа байхгүй юу. Тэгээд энэ тайлан нь өөрөө 2021 онд боогдсон. Тэгээд 2021 оноос хойш бол Өмнөговьд бол юм хийгдээгүй юм байна лээ. Тэгэхээр та хэд маань говийн бүсийн тэр ажлын хэсэг дээрээ ер нь чанар талаас нь хэр их анхаарсан бол. Усны олдцыг ярихаасаа гадна унданд хэрэглэж болох, болохгүйг нь бүгдээрээ сайн ярьдаг болчихвол. Тэгээд халдваргүйжүүлэлт хийх ёстой, филтер хийх ёстой, тавих ёстой гэсэн газруудад нь шууд энэ үр дүнг нь гаргаад хараад үйл ажиллагаа явуулъя гэхээр усны чанарын асуудал заавал тогтмол хяналтад байх ёстой байдаг. Сая энэ зун

устай зун байсан учраас хөрсний ус нөхөн сэргээгдэж байх ёстой. Тэгэхээр гүн рүүгээ усны чанар нь өөрчлөгдөж байгаа учраас энэ 73 сорьцын үр дүнг одоо бас шууд ашиглахад хүндрэлтэй болчихно. Тэгэхээр дахиж энэ чанарын сорьцуудыг авах ёстой болно. Тэгэхээр энэ мэт ажлууд бол ер нь Ховд аймгаас бусад бүх газруудад хийгдсэн юм билээ. Дундговьд энэ тайлан очиход Дундговийнхон филтер тавьсан гээд Шинжлэх ухааны академиас бол ярьж байна лээ. Тэгэхээр зарим аймгууд нь үр дүнгээ хараад ажлуудаа хийгээд, зарим аймгууд нь ширээн доороо ингээд тавьчихаад байгаа нь нөгөө ундны усаар хангагдах бид нарын үндсэн эрхийн асуудал бас хөндөгдөнө. Тэгэхээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам маань яг энэ усныхаа олдоц дээр нэмээд чанарын асуудлаа давхар харж харж явбал.../минут дуусав/

Б.Бейсен: 1 минут.

Б.Уянга: Тэгээд гуравдугаарх нь болохоороо одоо нөгөө уур амьсгалын өөрчлөлт бол явагдах нь тодорхой. Бид нар өөр нөхцөл байдалд амьдрах нь тодорхой болчихоод байгаа учраас эндээ нөгөө үндэсний хэмжээнд сөрөн тэсвэрлэх чадвараа л сайжруулах ёстой болчихоод байна. Тэгэхээр цөлжилтийг бууруулах гээд мод тарих уу, эсвэл ирээдүйн циклүүдээ харж байгаад устай жилийн цикл нь эхэлж байгаа тохиолдолд тэндээ бүгдээрээ усаа яаж хадгалах юм. Цөлжилт нь тэнд бид нар юу ч хийсэн болохгүй юм байна гээд эрдэмтэд хэлэх юм бол тийшийгээ бид нар хөрөнгө зарж хамгаалах хэрэгтэй юу. Тэгэхээр энэ дээр бас та хэд сөрөн тэсвэрлэх чадвар дээр ямар ажлууд төлөвлөж байгаа вэ.

Б.Бейсен: Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Маши чухал асуулт асуулаа. Энэ хог хаягдлын асуудал бол нөгөө хүний хүчин зүйлээс шалтгаалж байгаль орчин бохирдож байгаа хамгийн

том хүчин зүйл байгаа. Манайд ерөөсөө хогоо ангилж хаядаггүй. Тэгээд би ажлаа авсны дараагаар хог хаягдлын компаниудыг цуглуулаад хэлэлцүүлэг хийсэн. Зовлон жаргалыг нь сонссон. Тэд нар юу гэж ярьж байгаа вэ гэхээр хогийн тариф бол дэндүү бага байдаг. Жишээлэхэд манай Баянгол дүүрэг гэхэд нэг өрхөөс сарын хогийн хураамж 2500 төгрөг байж байх жишээтэй. Тэгэхээр энэ дэндүү бага байгаа. Тэгэхээр ер нь бол энэ хогийн тарифыг нь нэмээд, бодитой болгоод, ерөөсөө хувийн хэвшилд өгөхөд бол хувийн хэвшил бол 100 хувь бид нар гүйцэтгэж чадна гэж байгаа. Хогийн маш олон үйлдвэрүүд бий болсон байна. Бүгдээр нь явлаа. Ерөөсөө 20 хувийн хангалттай гэсэн үг. Өөрөөр хэлбэл үйлдвэр нь 20 хувьдаа л хүчин чадалтай ажилладаг. Бусад нөгөө юугаа нааш нь татаж дийлдэггүй юм байна л даа. Тэгэнгүүт бид нар аль болохоор газартай нь ойрхон болгоё гээд нэг гялгар уутаар хаягдал хийдэг их хөөрхөн компани байна. Даанч гялгар уутны хаягдлаасаа хол болохоор болохгүй учраас дахиад л яг хогийн цэг дээр нь газрыг нь олж өгөх гээд л бид нар ажиллаж байгаа. Тэгэхээр тэд нар бас нэг шаардлага тавьсныг нь Их Хурал баталсан. Энэ юу вэ гэхээр энэ хог хаягдлын тоног төхөөрөмжүүдийг татвараас чөлөөлж өгөөч. Гаалийн татвараас гэсэн. Сая өнгөрсөн Улсын Их Хурлаар бид нар хууль батлаад, боловсруулах төхөөрөмжүүд бүгд гаалийн татвараас чөлөөлөгдсөн байгаа. Тэгэхээр манай энэ хогийн боловсруулдаг бүх тоног төхөөрөмжүүд гаалийн татвараас чөлөөлөгдчихөөрөө их чухал болчихно.

Усны талаар манайхан бас нэмээд хэлнэ биз. Та бас яг зөв хэллээ. Энэ уур амьсгалын өөрчлөлт биднээс хамаарахгүй ийм зүйлүүд байгаа гээд. Тэгэхээр манай яамны 3 бодлогын 1 чиглэл бол бид нараас хамаарахгүйгээр уур амьсгал өөрчлөгдөж байгаад хэрхэн дасан зохицсон үндэстэн байх юм бэ гэдэг дээр бид нар маш том хөтөлбөр

манай яамны бодлогын хамгийн чухал бас хэсэг байдаг. Өөрөөр хэлбэл хүний хүчин зүйлээс хамаарахгүй юм чинь энэ ирээдүйд болох гай гамшиг, үер энд бас бид нар яаж бэлэн байх юм. Яаж эндээ бас дасан зохицож, хүлэмжийн хийгээ бууруулах тэр пассив хаус дулаан алдагдлыг нөхөх, эсвэл олноор нь тэр хөв цөөрмийг байгуулах, гадаргын устай жилдээ хөв цөөрмөө байгуулах гэсэн энэ маш олон төрлийн ажлуудыг бол одоо яг хийгээд явж байгаа. 1 нь хүний хүчин зүйлээс хамаардаг, 1 нь биднээс хамаарахгүй гэсэн ийм 2 бас үндсэн яг гол зүйлийг бол та яг олж харсан байна.

Б.Бейсен: Усны чанар дээр хэн хариулах вэ. Хэдэн номер вэ. Танилцуулаад хариулаарай. 8 номер.

Ц.Уранчимэг: Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Уранчимэг байна. Уянга гишүүний асуултад хариулъя. Усны чанарын асуудал бол яг тийм судалгаа хийгдсэн байгаа. Тэр судалгаа маань бас яг аймаг болгон дээр ялангуяа говийн бүсийн аймгууд дээр хийгдсэн. Технологийн шийдэл оруулаад 2 аймаг дээр бол 2016 онд бол туршиж байсан. Гэтэл тэр технологи нь бас нөгөө шүүлтүүр нь үнэхээр бас чанарын шаардлага хангах ус хэмжээнд нөгөө стандартын шаардлага хангасан усыг бол бас гаргаж чадахгүй байсан. Тэгэхээр говийн ус маань яг таны хэлдгээр үнэхээр унд ахуйн шаардлага хангасан ус бол бас маш бага байна гэдэг нь бол харагдаж байгаа юм. Тэгээд хүн амын ариун цэврийн шаардлагад нийцсэн, стандартын шаардлага хангасан худаг хүн амын ундны хэрэгцээний усны асуудал дээр яг манай улсын хэмжээнд тогтвортой хөгжлийн зорилтын бас шаардлагыг хангадаггүй ийм тулгамдсан асуудал бол яах аргагүй байгаа. Энэ дээр говийн.../минут дуусав/

Б.Бейсен: 8 номер гүйцээе.

Ц.Уранчимэг: Говийн бүсийн усан хангамжийг нэмэгдүүлэх, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ус хангах, ус

хангамжийн эх үүсвэрийг тогтоох зорилго, газрын доорх усны хайгуул судалгааны ажлыг үе шаттай хийе гэдэг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бол үйл ажиллагааны төлөвлөгөөнд орчихсон явж байгаа. Тэгээд энэ хайгуул судалгааны ажил дөнгөж дунд масштабын зураглал эрэл хайгуулын ажил бол 17,6 хувь нь л Монгол Улсын хэмжээнд хийгдсэн байгаа. Тэгэхээр зайлиггүй энэ ажлыг үе шаттай хийе. Энэ дээр санхүүжилтийн асуудал бас шаардлагатай. Тэгэхдээ Өмнөговь аймгийн хэмжээнд бол харьцангуй уур уурхайд түшиглэсэн Байгалийн усны төлбөрийн тухай хуулиар ус бохирдуулсны төлбөр усны дүгнэлтээрээ бас тодорхой хэмжээний зардлууд орж ирдэг. Энэ Байгалийн усны төлбөрийн тухай хуулиар буцаагаад яг энэ усыг, нөөцийг хамгаалах эрэл хайгуул хийх ажил дээр нь зарцуулахыг бол Өмнөговь аймгийн Засаг дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын хамтарсан гэрээн дээр бол энэ жил тусгах гээд ингээд тодорхой ажлуудыг төлөвлөөд явж байгаа.

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Байгаль орчин, уур амьсгалтын өөрчлөлтийн яам бол мэдээж байгаль орчноо хамгаалах үндсэн үүрэгтэй байх гэж бодож байна. Тэгээд нийт нутаг дэвсгэрийн 76,9 хувь нь буюу 120,3 сая га талбайд цөлжиж байна гэж. Энэ мэдээж дэлхий нийтийн байгаль орчны, уур амьсгал, мөсөн голын хальт гээд ингээд хүний хүчин зүйлээс шалтгаалахгүй нь явагдаж байгаа байх. Гэхдээ хүний хүчин зүйлээс шалтгаалж явагдаж байгааг бид өнөөдөр яах вэ. Жишээ нь миний сонгогдсон Говийн бүс болох Дорноговь аймаг, Өмнөговь аймагт өнөөдөр уул уурхай аж үйлдвэржилтийн бүс болсон. Ямар ч аргагүйгээр. Тэнд өнөөдөр зам тавьж байна. Төмөр зам тавьж байна. Олборлолт баяжуулах үйлдвэр явагдаж байна. Одоо бид нар энд юу ярих ёстой

болсон бэ гэхээр нөлөөллийн бүс гэдэг үгийг ярьж хэвших хэрэгтэй болсон байна л даа. Нөлөөллийн бүсэд амьдарч байгаа хүмүүсээ яах юм. Нүүлгэн шилжүүлж байгаа. Нүүлгэн шилжүүлэлтэд бид нар мөнгө, нөхөн олговор өгч байгаа гэж ярьж байгаа юм. Тэгээд яах юм ингээд говийнхныг бүгдийг нь нүүлгэн шилжүүлээд л мөнгө өгөөд л явуулаад л байх юм уу. Тэнд нь авч үлдэх юм уу. Энэ тал дээр яг бодитой ямар ажил хийх юм. Хэдэн төгрөг зарцуулахаар төлөвлөгдсөн юм гэдэг 1 дүгээр асуудал байна.

Говийн бүсийн ундны ус шаардлага хангахгүй байгаа нь үнэн. Эрдэсжилт ихтэй. Дорноговь, Өмнөговь аймгийн нутгуудад энэ бол маш өндөр хувьтай байгаа. Тэгээд саяын хэлсэн тэр мэргэжилтний юугаар бол 17 хувь нь л хийгдсэн гэж байна шүү дээ. Нэмэлт хайгуул тийм үү. Тэгээд үлдсэнийг нь яах юм. Энд яг хэдэн төгрөг хэрэгтэй байна та хэлээд өгөөч. Энд мөнгө хэрэгтэй гэж байна. Тэгвэл энийг нэн яаралтай, энэ чинь бүүр түгшүүр зарлах хэмжээнд байгаа юм биш үү. Тэгэхээр яаралтай мөнгөн дүнг нь хэлж өгөөч. Говийн усны төсөл Засгийн газар дээр ажлын хэсэг байгуулагдсан нь сайн алхам боллоо гэж бодогдож байна. 2024-2027 онд зөвхөн барилга угсралтын ажил хийгдэнэ гэж ойлголоо. Мөн үү. 2024 он ингээд дуусаж байна шүү дээ. Тэгэхээр миний мэдэж байгаагаар л лав энэ говийн усны төсөл дээр хэд хэдэн ийм судалгаа, хувийн компаниудын хийсэн ТЭЗҮ энд тэнд байдаг. Тэд нарыг бүгдийг нь тэр ажлын хэсэг дээр нэгтгэх үү. Тэгж ойлгоод байна зөв үү.

Ус бохирдуулсны төлбөр улсын хэмжээнд 5,7 тэрбум төгрөг орж ирдэг юм байна л даа. Гэтэл яг энэ говийн бүсэд ажиллаж байгаа бол уурхайгаас гүний ус ашигласны төлбөрт яг хэд орж ирдэг вэ. Энийг надад яг тоогоор нь хэлж өгөөч. Говийн гадаргын ус татах төсөлд 4,9 их наяд гэж тавьсан байна. Төр, хувийн хэвшлийн түншилэлээр. Энэ зөвхөн

юунд зарцуулагдах юм. Барилга угсралтад юм уу. 2 юунд вэ.

Б.Бейсен: Хариулъя. Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Манай яамныхан бас нэмээд хариулаарай. Говийн усан дээр манай усны ажлын хэсгийн ахлагч хариулчихгүй юу. Цөлжилт бол яах аргагүй бас маш аюултай түвшинд хүрсэн. Тийм учраас Ерөнхийлөгч энэ хуулийг зүгээр цөлжилтөөс урьдчилан сэргийлэх энэ тэр гэж ярихгүй, цөлжилттэй тэмцэх гэж ач холбогдол өгөөд, ажлын хэсгүүд ажиллаж байна. Энэ хуулийг оруулж Улсын Их Хурлаар батлуулах гэж байгаа юм. Энэ цөлжилтийн төлөв байдлын үнэлгээг 5 жил тутамд хийдэг. Хамгийн говь хээрийн бүсийн хур тунадас багатай Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Төв, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай зэрэг аймгууд бол илүү цөлжилт, газрын доройтолд өртсөн гэсэн судалгаа гарсан. Та бүхэн мэдэж байгаа байх сая Өмнөговьд бид нар энэ 17-нд болох юутай холбогдуулж бас цөлжилтийн өөрсдийн дотоодын ийм том хурлыг хийсэн. Энд бүх л манай цөлжилтөөр мэргэшсэн бүх л эрдэмтэд оролцож бас нэлээн чухал илтгэлүүдийг тавьсан. Одоо цөлжилтийн талаар тайлан гаргах гэж байгаа. Удахгүй бэлэн болно. Тэгэхээр энэ яг юунаас, хэдэн хувь нь юунаас гэдэг нарийн ийм зүйл бол гарна. Ер нь бол үндсэн гол 2 шалтгаан нь юу вэ гэхээр сүүлийн 30 жил мал сүргийн тоо толгой 3 дахин нэмэгдэж, бэлчээрийн даац хэтэрсэн. Энэ бол 1 дэх шалтгаан.

2 дахь нь бол уул уурхай эрчимтэй хөгжиж, эвдэрсэн газрын тоо хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой гэсэн ийм 2 шалтгааныг хэлж байгаа. Говийн усан дээр манайхан нэмээд хариулчих. Яг барилга байгууламж түрүүн ингэсэн, нөгөө усан дээр ингээд маш бага хувь нь манайх судалгаа хийчихсэн байна. Тэгээд жил болгон л төсөвт мөнгө тавиулах гэхээр энэ нь хасагдчихдаг юм. Энэ жил

бид нар 10 тэрбумыг л төсөвт тавиад өгөөч гэсэн усны судалгаа дээр. Энэ бас санал өгсөн чинь хасагдчихсан. Тэгэхдээ бид нар энийг Засгийн газар дээр ярьж байгаад төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийлгэхээр ерөнхийдөө гайгүй шийдэгдэж байгаа. Тэгэхээр манайх энэ жилдээ 2025 онд 10 тэрбум төгрөгөөр жил болгон бид нар 10, 10 тэрбум төгрөгөөр хийгээд байхад бол бас боломжийн ийм судалгаа гарчих юм байгаа юм. Манайхан нэмээд хариулаарай.

Б.Бейсен: 8 номер.

Ц.Уранчимэг: Мөнхбаясгалан гишүүний асуултад нэмж хариулъя. Саяын тэр гидрогеологийн дундах штабын зураглал хийсэн газар нутгийн хэмжээ 17,6 хувь гэж байгаа. 2018-2019 онд Говийн 3 сав газрын Говь-Алтай, Дорноговь аймгийн 5 сум, Сүхбаатар, Баянхонгор аймгийн 5, Сүхбаатар, Дорноговь аймгийн 5 сумын нийт 75 мянган км³ талбайд бол ийм хайгуул судалгааны ажил хийсэн байгаа. 2023 онд болохоор Өмнөговь аймгийн Манлай, Цогтцэций, Дундговь аймгийн Өлзийт, Дорноговь аймгийн Мандах сумуудад бол хийгдсэн. Тэгэхээр 1:2000 масштабын зураглалын ажлын төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх ажил бол улсын төсөв дээр 200-300 сая төгрөг л өмнө нь тавигдаж байсан. Ковид цар тахлын үед бол 2-3 жил энэ ажил хийгдээгүй тасарсан байгаа. Тэгэхээр сая сайд хэлсэн. Энэ ажлыг хийхэд жил 10 тэрбум төгрөг ер нь хэрэгтэй байж байж Монгол Улсын хэмжээний гүний усны нөөцийн судалгаа мөн гидрогеологийн масштабын дунд зураглал.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээгээд яриулчих.

Ц.Уранчимэг: Тойм судалгаа хийгдэнэ гэж үзэж байгаа. Орхон-Онги, Хэрлэн-Тооно төслийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон 2 усны том мега төсөл байгаа. Өчигдөр Засгийн газрын хурал дээр танилцуулга хийсэн.

Тэгэхээр Орхон-Онги төслийн ТЭЗҮ бол хуучирсан. Эрдэнэс Оюутолгой компаниас санхүүжилтийг нь гаргаад, тендер зарлаад ТЭЗҮ-ийг боловсруулаад, 2026 оны 6 сарын 30-нд хүлээлгэж өгөхөөр ийм гэрээ бол байгуулагдсан байгаа. Засгийн газраас шинэ.../минут дуусав/

Б.Бейсен: Тодруулъя гэсэн үү. 8 номер гүйцээж хариулъя. Минутагд багтаагаад гүйцээж хариулъя.

Ц.Уранчимэг: Хэрлэн-Тооно, Орхон-Онги төслийн хүрээнд бол ТЭЗҮ-ийг шинээр боловсруулахад сая гэрээ хийгдсэн. Хэрлэн-Тооно төслийн хүрээнд тодорхой санхүүжилт одоогоор бол байхгүй байна. Тэгэхээр Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсэг гарч байгаа. Энэ ажлын хэсэг дээр энэ чиглэлийн төр, хувийн хэвшлийн хүрээнд хийсэн бүх ТЭЗҮ, судалгаа шинжилгээ бүх асуудлуудыг танилцуулж, дараагийн шийдвэрийг гаргана. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг бол энэ суурь судалгаануудыг, усны чиглэлийн суурь судалгаануудыг зайлиггүй хийх хэрэгтэй. Мөн усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газраар батлуулах шаардлагатай. Тэр тусмаа говийн усан хангамжийн эх үүсвэр, хүн амын ундны усны асуудлыг стандартад нийцсэн шийдлүүд дээр яг энэ ажлын хэсэг дээр бас тодорхой ажлуудын дүгнэлт, зөвлөмж гаргаж, Засгийн газар дээр танилцуулахаар бэлтгэж байгаа.

Б.Бейсен: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Говьд гүний ус ашиглаж байгаа. Уур уурхайгаас жилд төлбөрт нь хэчнээн төгрөг орж ирдэг вэ.

Дараагийн асуулт болохоор Цагаан дэл уулын боомт, Наран сэвстэйн боомт нээнэ гэж Засгийн газар төлөвлөгөө гаргасан. Ажиллагаа явагдаад

эхэлчихсэн. Нээлгэхгүй гэдэг. Нээлгэхгүй гэдэг шалтгаан нь болохоор унаган байгаль, тэнд байгаа ан амьтан амьдрах газаргүй болно. Байгалийн үзэсгэлэнт төрх эвдэгдэнэ. Энэ бол Юнескод бүртгүүлэх гэж байгаа тийм унаган байгаль гэж нутгийн иргэд болоод эрдэмтэд яриад байдаг. Тэгэхээр би энийг сайдаас асуумааргүй байна. Яамныхнаас асуумаар байна. Үнэхээр тэнд боомт нээчих юм бол, Цагаан дэл уулын боомтыг нээчих юм бол, Наран сэвстэйн боомтыг нээчих юм бол тэр байгалийн унаган төрх алдагдаад тэнд байгаа ан амьтан үгүй болоод, бид нар байгаль экологийн хувьд алдагдал, газрын доройтол.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер. Төрийн нарийн бичгийн дарга.

Э.Баттулга: Усны нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу бол усны нөөц ашигласны 35-аас доошгүй хувийг буцаан зарцуулах ёстой байдаг. Тэгэхээр тухайн жилд ашиглаж байгаа хэмжээнээсээ хамаараад 35 хүртэлх хувийг бол энд буцаан улсын төсөвт төвлөрүүлээд, усны нөөц хамгаалахад зарцуулдаг гэсэн үг. Яг хэдэн төгрөг шаардлагатай вэ гэдэг дээр бас харилцан адилгүй байдаг л даа. Геофизикийн судалгаа, өрөмдлөгийн ажил, хими, физикийн шинжилгээ гээд янз янзын нөгөө тухайн газрын тогтоц байрлалаасаа хамаараад харилцан адилгүй байгаа. Нэгдсэн норматив бол одоохондоо байхгүй байна. Наран сэвстэй болоод Цагаан дэл боомт ... хэд орж ирдэг билээ Уранчимэг дарга аа.

Б.Бейсен: Асуусан асуултад тодорхой хариулаарай.

Э.Баттулга: Манай газрын дарга нар төлбөрийг нь тодруулж байгаарай.

Б.Бейсен: 4 номерт 1 минут нэмж өгье. Гүйцээгээд хариулчих.

Э.Баттулга: Өмнөговь аймгийн Цагаандэл болон Говь-Алтай аймгийн Наран Сүсэгтэйн боомтын асуудал яах аргагүй Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон. Боомтыг нээх асуудал яригдах үед мэдээж байгаль орчны үнэлгээ хийгдэж таарна. Тэгээд байгаль орчинд ямар төлөвлөлтөөр, ямар маршрут, ямар трассаар явахаасаа хамаараад нөлөөлөл нь харилцан адилгүй байна гэж харж байгаа. Тэгэхээр бид нар бол одоогийн байдлаар аль нэг боомтынх нь байгаль орчны үнэлгээний асуудал орж ирээгүй учраас шууд ийм тийм гэж бол хэлэх боломжгүй байна. Гэхдээ ялангуяа жишээлбэл Наран сэвстэйн боомт байгаа тэр Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэр Монголын Говийн их дархан цаазат газрын “А” хэсгийг дайрч өнгөрч байгаа. Энд нөгөө Мазаалай баавгай, Хавтгай, Тэмээ, нөгөө говийн 6 гэдэг ховордсон амьтад, нэн ховор амьтад бүгдээрээ тархац байдаг нутаг. Яг дундуур нь гарна гэвэл тараас нь тэгж тогтох юм бол нэн ховор амьтдын тархац нутаг байгаа.

Б.Бейсен: Усны төлбөрийн талыг хэн хариулах юм. 8 номер.

Ц.Уранчимэг: Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуулиар Өмнөговьос 2023 онд 33 тэрбум төгрөг бол төвлөрсөн байна. Үүний байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуулиараа 35 хувийг тухайн усыг хамгаалах, нөөцийг тогтоох судалгаа, шинжилгээнд зориулна гэсэн ангилалтай байдаг. Танд яг говийн бүсийн бүх аймаг сумаар нь ирсэн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн талаарх дүгнэлтийг танд албан бичгээр хүргүүлье.

Б.Бейсен: Замира гишүүн асуулт асууя. Замира гишүүний микрофон өгье. Ажиллахгүй байгаа юм байна.

С.Замира: 2 асуулт асуумаар байна. Энэ уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж байгаа байдал нь бол энэ тусгай

хамгаалалттай газруудад барилга ихээр баригдаад байна. Зөвхөн энэ Богд уулын ингээд жишээ болгож татаж авахад энэ чинь тусгай хамгаалалттай газар шүү дээ. Энд нөгөө аялал жуулчлалын энэ бааз байгуулна гэж зөвшөөрөл аваад, зориулалт бусаар орон сууц барьж байна. Энэ тал дээр авч байгаа арга хэмжээ байна уу 1 дүгээрт.

2 дугаарт аюултай энэ хог хаягдлыг дахин боловсруулалтад оруулах хогийн үйлдвэр дөнгөж 20 хувийг хангаж байгаа гээд сайд ярьж байна шүү дээ. Тийм ээ. Тэгэхээр үлдсэн 80 хувийг хангах хэмжээний хийгдсэн төсөл судалгаа байна уу. Тэрийг авах боломж байна уу. Баярлалаа.

Б.Бейсен: Сайд албаны хариулъя.

С.Одонтуяа: Би энэ хог хаягдлыг хариулъя. Манайхан нэмээд нөгөө тусгай хамгаалалтдаа хариулаарай. Энэ аюултай хог хаягдлынх биш ер нь ингээд нэг том хогийн үйлдвэрүүд дээр очоод үзэхээр маш орчин үеийн сайхан үйлдвэрүүд бол байна. Гэхдээ 20 хувь нь л хүчин чадлаар ажиллаж байна. Тэгэхээр эдгээр компаниудын тавьсан хүсэлтийг бид нар явал энэ байгууллага дүүргэлттэй сайн хүчин чадлаараа ажиллах вэ гэдэг дээр бид нар төлөвлөгөө боловсруулаад ажиллаж байгаа. Тэрний нэг нь энэ орж ирж байгаа ерөөсөө бүх тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлж байна.

2 дугаарт яг хогийн цэгтэй нь ойрхон газар олгож, энэ үйлдвэрүүдийг энэ бүтээгдэхүүнээр нь түүхий эдээр нь хангах асуудал дээр онцгой анхаарч байна. Маргааш байгаа Ногоон бонд гэж манай яг миний очиж үзсэн хамгийн том тэр хогийн.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номерт нэмээд хариулчих.

Э.Баттулга: Замира гишүүний асуусан Тусгай хамгаалалттай газар

нутаг ялангуяа энэ Богд уулын асуудлыг яаж шийдэх вэ гэж бид нар 3 үндсэн бодлогын хүрээнд энийг хумина, хязгаарлана гэж харж байгаа. Эхнийх нь энэ газрын төлбөр байгаа. Газрын төлбөр 1 га-д ноогдох газрын төлбөр энгийн болон эдэлбэр газрууд, бусад эдэлбэр газруудтай харьцуулахад хамаагүй өндөр байгаа. Тусгай хамгаалалттай газар нутгуудад жишээлбэл нэг га нь 2 сая төгрөгийн төлбөртэй байгаа.

2 дугаарт нь дотоод бүсчлэлийг өөрчлөх замаар энийг шийдэж болно гэж харж байгаа. Сүүлийн 2, 3 жилийн хугацаанд Богд Хан уулын дархан цаазат газрын дотоод бүсчлэлийг маш их хэмжээгээр хязгаарласан. Өөрөөр хэлэх юм бол хамгаалалтын бүсийг тэлээд хязгаарлалтын буюу энэ газар ашиглалттай байж болдог. Хуулиар зөвшөөрсөн энэ хэсгүүдийг боломжит хэмжээнд нь багасгаж байгаа.

3 дахь нь бол одоо энэ хууль, эрх зүйн орчны өөрчлөлтөөр газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд улсын төлөвлөгөөнд Засгийн газраас зөвхөн орсон байришилд.../минут дуусав/

Б.Бейсен: Замира гишүүн тодруулъя гэж байна.

С.Замира: Одонтуяа сайд яаманд дөнгөж очсон байгаа. Тэгэхдээ бол танд яаж байгаа биш шүү. Энэ яам дээр үеэс ажиллаж байгаа яам. Тэгэхээр нөгөө судалгаа асууж байгаа учир нь бүх юмыг төрд давахгүйгээр бид нар бас хөрөнгө оруулалт татах санаатай гадаадаас. Парламент хоорондын бүлгэмүүд байгуулагдаж байна. Тийм учраас тийм судалгаа бид нарт гаргаад өгчихвөл асуудал тавихад амархан байдаг байхгүй юу. Тэрний төлөө л би сая нөгөө төсөл байна уу гээд асуусан юм.

Тэгээд сая нөгөө тусгай хамгаалалттай газрын талаар ярьж байна шүү дээ. Тэгэхээр тэрний

татварыг нь ихэсгэлээ, нэмлээ гээд тэр газар чөлөөлөгдөхгүй нь ойлгомжтой. Тийм ээ. Уг нь энэ зөвшөөрөл олгох асуудлыг бол сүүлийн үед таслан зогсоож байгаа гэсэн тийм үү. Өөрийн чинь сүүлийн үгийг би сонссонгүй. Микрофон нь хаагдсан учраас. Тэрийг тодруулаад өгөөч.

Б.Бейсен: Сайд хариулъя. Тэгэхээр нэгдүгээрх нь бас Улсын Их Хурлын гишүүд гадаадад хүмүүстэй уулздаг, гадна, дотнын парламентын бүлгийн чиглэлээр, Байнгын хорооны чиглэлээр уулздаг. Тэгэхээр бид нар энэ сэдвүүд дээр та нарт бас бэлтгэл материалуудыг бас бэлдэж өгье. Ямар чиглэлээр яаж бас шаардлагатай байдаг юм. Ямарт нь бид нарт угаасаа хангалттай байдаг юм, хангалтгүй байдаг юм гэдэг ийм мэдээллийг бас бэлтгэж өгье.

2 дугаарт Богд уулын асуудал бол үнэхээр маш замбараагүй явж ирсэн юм билээ. Манайхаас аялал жуулчлал гэж авчхаад тэгээд нийслэл дээр очоод баахан байшин барих зөвшөөрлийг нь тэндээс очоод авчихдаг. Ингээд байшингаа барьчхаад бүгдээрээ энэ чинь нэг аялал жуулчлалын отог нэртэй, тэгээд ингээд зөвшөөрөл нь ч гардаггүй. Энийг бол бас нийслэлтэй хамтарч Засгийн газар дээр цэгцлэх асуудал байгаа. Одоо Засгийн газраар ерөнхий төлөвлөгөө батлагдаж байгаа. Энэ бүх манай тусгай хамгаалалттай газруудаас зөвхөн Засгийн газарт санал ирүүлж, тэр ерөнхий.../минут дуусав/.

Б.Бейсен: Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам. Зүгээр ер нь яамны нэршил ганц 2 яамдын нэршилүүд ер нь Засгийн газар кабинетууд нь солигдох болгонд сонгуулиас сонгуульд нэршилүүд нь дандаа өөрчлөгдөөд явдаг юм л даа. Тэгээд энэ удаа дахиад л Байгаль орчин, уур амьсгалын

өөрчлөлтийн яам гээд нэршилтэй болоод л сайд маань томилогдчихлоо. Тэгэхээр энэ өвөл агаарын бохирдол Улаанбаатар хотынхоо агаарын бохирдол, утаагаа яах юм бол. Нийслэлтэй ер нь хэр уялдаа холбоотой, төсөв хөрөнгө байдаг юм уу, үйл ажиллагаа байдаг юм уу үүгээрээ хэр холбогдож ажиллаж байгаа вэ гэдгийг 1 дүгээрт асууя.

2 дугаарт энэ аюултай хог хаягдлын хэмжээ сүүлийн 3 жилд энэ сайдын өгсөн мэдээллээр харахаар ер нь огцом өсөөд байна л даа. Огцом өсөөд байна. Бүр 2023 оны байдлаар 281 хувиар өссөн дүн мэдээтэй байна. Тэгэхээр энэ аюултай хог хаягдлыг тээвэрлэх, хадгалах, боловсруулах, экспортлох гээд л зөндөө ажлууд байгаа. Жишээ нь Налайхад байдаг тэр Нью Метэд билүү цахилгааны. Тэгэхээр тэр компанийн үйл ажиллагаа ер нь хэрхэн явж ирсэн юм. Төлөвшсөн юм уу. Өндөр хөгжилтэй дэлхийн улс орнууд жишээ нь хамгийн ойрын Япон зэргийн ийм орнуудтай Герман, Солонгос гэсэн ийм улс орнуудтай яг ийм аюултай хог хаягдлын чиглэлээр дахин боловсруулалт хийж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих, тэд нарыг сургах, суралцуулах энэ тал дээр 2025 онд яамнаас ер нь ямар бодитой ажлыг авч хэрэгжүүлэх вэ. Ер нь бол тэр сая ярилаа. Замира гишүүн асуулаа л даа. Бас л Богд уул гээд бүгдээрээ л ярьцгааж байна. Богд уулын асуудал энэ ам болгонд нь байж байгаа, тэр тухлаад суучихсан олон таун хаус, тэр хотхон, хороолол бүр ам бүрд нь л бараг байгаа шүү дээ. Одоо ер нь сул ам байгаа юм уу. Моджуулах, ойжуулах, төсөл хэрэгжүүлчихмээр тийм сул ой, ам ер нь байхгүй л юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ ойжуулах төслийн ажлын хөтөлбөрийн хүрээнд Богд уулын ойг нөхөн сэргээх, дахин ойжуулах төсөв энэ жилийн 2025 оны улсын төсөвт ер нь тусгайлан суусан уу. Ийм асуултууд асууя.

Б.Бейсен: 4 номер. Төрийн нарийн хариулъя.

Э.Баттулга: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ Засгийн газрын 2023 оны 396 дугаар тогтоолоор Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны хороог татан буулгаад, чиг үүрэг төсөв зүйлсийг нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар шилжүүлсэн байгаа. Гэхдээ мэдээж бид хамтарч ажиллаж байгаа. Энэ жил жишээлбэл орчны бохирдолтой тэмцэх ажилд тавигдсан зардлыг бүх эрхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаас Нийслэлийн Засаг даргад шилжүүлээд явж байгаа. Тэгэхдээ яам бол агаар орчны бохирдлын хяналт мониторингийнхоо ажлыг, ногоон зээлтэй холбоотой, ногоон санхүүжилттэй холбоотой асуудлуудаа бол ажлуудаа үргэлжлүүлээд, хэрэгжүүлээд явж байгаа.

Аюултай хог хаягдлын асуудлаар бол одоогийн байдлаар 12 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл авчихсан байж байна. Хог хаягдлын тухай хуулиар бол аюултай хог хаягдал ашиглах, тээвэрлэх, хил дамжуулан худалдахтай холбоотой харилцаа манай яамны чиг үүрэгт байдаг. Өнөөдрийн байдлаар бид ер нь аюултай хог хаягдлын түр хадгалах цэгүүдийг Сүхбаатар, Өмнөговь, Говь-Алтай, Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудаас бусдад нь байгуулчихсан. Ойрын үеийн хамгийн том зорилт Төв аймгийн Сэргэлэн сумд 20 га газарт газар төлөвлүүлээд авчихсан. Улсын хэмжээний аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламжийг барьж байгуулах ажил байгаа. Энэ бол концессын зүйлийн жагсаалтад орчихсон ийм төсөл. Юуны хувьд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтаар бол эмнэлгийн хог хаягдал, тэгээд автомашины тос тосолгооны материалууд, бусад аюултай хог хаягдлын ангилалд багтдаг энэ хог хаягдлуудыг тус бүрээр нь ялган хоргүйжүүлэх, аюулгүйжүүлэх энэ үйлдвэрүүд бол шат дараатай байгуулагдаж байна. Жишээлбэл, цахилгаан барааны, электрон барааны хог хаягдлыг бүрэн боловсруулж байна.

Эндээс катодын цэсийг нь ялгаж авч байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн холбогдолтой аюултай хог хаягдлыг бүрэн 2 аж ахуйн нэгж бүгдийг нь дахин боловсруулалт хийж байгаа. Бид бол дугуй гэдэг юм уу энэ бүх зүйлүүдийг ерөнхийдөө Монгол Улс дахин боловсруулах чиглэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар боломжийн хэмжээний амжилтад хүрчхээд байгаа гэж бид бол харж байгаа. Юун дээр Богд уулын ойжуулах дээр төсөв зардлын талаар Оюунсанаа дарга хэлэх үү.

Б.Бейсен: 2 номер. Ойн газрын дарга.

Б.Оюунсанаа: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Богд уулын хувьд мэдээж бид нар онцгойлон анхаарч байгаа. Ерөнхийдөө бас хөнөөлт шавжид өртсөн талбайнуудын бид нарт нарийвчилсан судалгаа байдаг. Өнгөрсөн жил бид нар бас хөнөөлт шавжид 10-аад жилийн өмнө өртөөд, доройтож үхэж хатсан ойн талбай дээр бол цэвэрлэгээний ажлыг хийсэн. 2024 он буюу энэ жил бид нөхөн сэргээлтийн ажлыг дөнгөж саяхан хийгээд, энэ цасны өмнө хий гээд дууссан байж байгаа. Ер нь уул уурхайн компаниуд дээр бас амлалтын хүрээнд тодорхой амнуудын тодорхой хэсгүүд дээр бид нар газруудыг зааж өгсөн байгаа. Нэг ёсондоо нэмж тэр саяын тэр отоглох цех байна уу, янз бүрийн зориулалтаар олгуулахгүйн тулд бид нар бол ингээд хязгаарлалтуудыг хийгээд, мод тарих ажлуудыг Богд уулын захиргаатай гуравласан, дөрвөлсөн хэлбэрээр ингээд байгуулаад тарилтын ажлуудыг хийгээд явж байгаа. Яг нийтдээ юу гэдэг юм хэдэн га талбай гэдэг дүнг бол танд бас нарийвчлан хүргүүлж болно. Хүргүүлчихье. Тэгээд яг одоогийн байдлаар энэ жилийн хугацаанд бол бид нар 2023, 2024 онд бүр онцгойлон.../минут дуусав/

Б.Бейсен: Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Бас л яах вэ бүдэг л хариулт сонсож байна л даа. Миний эхний сонирхсон асуудал энэ сонгуулиас сонгуульд Засгийн газар, кабинет бүрдэхэд харин энэ яамдын нэршил ер нь өөрчлөгдөөд байгаад би их гайхаад байгаа юм. Энэ нөгөө төрийн залгамж чанар гэдэг юм алдагдаж байна уу гэж харагдаж байгаа юм л даа. Ерөөсөө илт. Яагаад гэвэл тэнд ингээд л яам болгон л ингээд л бүтэц гарах тусам яамд ингээд шинээр байгуулагдах тутамд л нэг нэршил өөрчлөгдөөд л дагаад юм уу эсвэл алга болоод л тэрийг дагаад л агентлагууд доогуур нь бүх бүтцэд нь өөрчлөлт орчихдог. Төсөвт өөрчлөлт орчихдог. Төсөв хэмнэгдэнэ үү гэхээсээ илүү тэлээд байгаа байхгүй юу. Тэгэхээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам бол үйл ажиллагааныхаа яг чиглэлээр бодлогоор Нийслэлд энэ агаарын бохирдлыг шилжүүлээд ингээд орхичих биш.../минут дуусав/

Б.Бейсен: Үг хэлж байгаа юм байна. Санал хэлж байна. Ундраа гишүүн асуулт асууя.

А.Ундраа: Та бүхний өдрийн амгаланг айлтгая. 2 асуулт байна. Нэг нь усны чиглэлээр, нөгөөдөх нь агаарын бохир тогтолтой тэмцэх талаар.

Усны чиглэлээр бол энэ өнөөдрийн танилцуулгад дурдсан байна л даа. Баталгаат ундны усны хангамжийн асуудал. Тэгээд Улаанбаатар болон бусад суурин газруудад тэгээд хотын захын гэр хорооллуудад гээд ер нь усан хангамжийн нөхцөл байдал бол ихээхэн ялгаатай байгаа талаар. Тэгээд нөгөө саяхан бас нэг судалгаа харж байхад бол гэр хороололд байгаад иргэдийн хувьд бол дунджаар өдөрт 8 литр ус хэрэглэдэг. Орон сууцад байгаа иргэдийн хувьд өдөрт дунджаар 120 литр ус хэрэглэдэг гэсэн ийм тоо харж байсан. Тэгэхээр үүний усных нь хангамжийн асуудал бол даруй 15 дахин ялгаатай байгаа. Тэгэхээр мэдээж баталгаатай ундны усны

хангамжийг сайжруулах чиглэлээр ямар ажил хийгдэж байна. Ямар бодлого баримталж байна гэдэг асуулт асуумаар байна. Энэ бол зөвхөн Улаанбаатар хотын төдийгүй бусад суурин газруудад хамаатай асуудал. Тэгэхээр өөрөөр хэлбэл гэр хороололд амьдарч байгаа иргэдийн тухайд бол усны байнгын хомсдолд байна гэж хэлэхэд хилсдэхгүй. Тэгэхээр бид орон сууцжуулах барилга байгууламжийн нөхцөл байдлыг сайжруулах чиглэлээр жишээлбэл Монгол Улс үндэсний ногоон барилгын зэрэглэлийг саяхан баталсан. Тэгээд ногоон барилга гэж юуг хэлэх вэ гэдэг дотор бол усны хангамж, тэгээд тэр дундаа саарал усны хэрэглээ гэсэн энэ 2 зүйлийг бол оруулсан байгаа. Тэгэхээр орон сууцад амьдарч байгаа иргэдийн хувьд бол саарал усны хэрэглээ инженерийн дэд бүтэц байхгүй учраас саарал усны шугам байхгүй гэдгээрээ бид бол ундны усанд ашиглаж болох усыг мэдээж ариун цэвэрт буруу зорилгоор ашиглаад байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр яамны зүгээс ямар бодлого баримталж байна. Усны газрын дарга Батбаяр даргын өгсөн ярилцлагыг харж байхад бол ийм саарал усны шинээр ийм шугам сүлжээ байгуулах зураг төслийн шатдаа өөрчлөлт хийх шаардлагатай гэдэг байр суурь илэрхийлсэн байсан. Энийг бол та бүхэн дараа дараагийн бодлогод тусгаж байна уу.

2 дугаар асуулт бол агаарын бохирдолтой холбоотой. Агаарын чанарын нөхцөл байдал хүнд байгааг бол бүгдээрээ мэднэ. Тэгэхээр зөвхөн нийслэл гэхгүй бас аймгийн төвүүд ч гэсэн агаарын чанарын асуудал бол маш хүнд байна. Тэгэхээр бидний хувьд бол энэ түлш өөрчилж үзлээ, зуухаа өөрчилж үзлээ. Одоо дулаалгын асуудлыг бол заавал ярих хэрэгтэй. Тэгэхээр эрчим хүчний хэмнэлтийн асуудал л даа. Агаарын асуудал бол агаарын чанарын асуудал гар гараасаа ингэж зэрэгцэж барьж явах хэрэгтэй байгаа. Нөгөө талдаа бол бас ялангуяа Улаанбаатар хотын хувьд бол агаарын чанарт

нөлөөлж байгаа нэг томоохон хүчин зүйл бол бас утаанаас гадна автомашины нүүрсэн янданг олноор нь авч ингэж хууль зөрчин худалдаалдаг асуудал байгаа. Тэгэхээр энэ агаарын бохирдлын хувьд бол 60 хувь, утаанаас 40 хувь нь автомашинаас гэсэн ийм тоо байна. Энэ дээр ямар бодлого баримталж байна вэ гэдгийг яамнаас тодруулмаар байна.

Б.Бейсен: Сайд хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр усан дээр бэлдэж байгаарай. Агаарын бохирдол дээр өмнөх парламентад байхад Агаарын бохирдлын дэд хороо гэж Их Хурал дээр байсан. Энэ дэд хороог татан буулгасан санагдаж байна. Агаарын бохирдлын асуудал дээр бол үндэсний хороо бас татан буугдаад, нийслэлийн агаарын бохирдлыг нийслэл 100 хувь хариуцахаар, аймаг, хөдөө орон нутгуудын агаарын бохирдлыг манай яам хариуцах бас ийм чиг үүрэгт бол орсон. Мэдээж бид энэ яам бодлогоор энэ агаарын бохирдлыг бид нар бууруулах чиглэлээр ажиллах ёстой. Энэ дээр бол агаарын бохирдлыг бууруулах бол сая Ундраа гишүүн яг зөв хэллээ. Энэ гэр хорооллын утаанаас гадна автомашины утаа гэж байгаа. Тэгэхээр автомашины утааг бууруулах дээр албан даалгавар гарсан. Өөрөөр хэлбэл энэ евро 5 стандартын түлш рүү бид нар яаралтай шилжихгүй бол манайхаас өөр газар бараг евро 5 бас өөр юу бол хэрэглэхгүй байгаа. Тэгэхээр Агаарын бохирдлын хуульдаа бид нар ийм түлш хэрэглэнэ гээд заачихсан хэр нь өөрсдөө ингээд евро 5-ыг хэрэглэхгүй байгаад байх жишээтэй. Тэгэхээр ямар ч байсан эхний ээлжид би Нямбаатар даргад юу гэж албан даалгавар явуулсан бэ гэхээр ядаж эхний ээлжид нийтийн тээвэрт явж байгаа автобус төрийн албанд явж байгаа автомашин гэхээр нийлээд 3 мянга болж байгаа. Энэ 3 мянган автомашиныг эхний ээлжид энэ евро 5 руу шилжүүл гэдэг ийм зүйлийг бол бас албан даалгавар өгсөн. Энийг бол үе шаттай бид нар энэ стандарт руу шилжихгүй бол евро 2-ын евро 5-тай

харьцуулахад энэ бол асар их бохирдлыг үүсгэдэг ийм түлш өөрөө байж байгаа.

Гэр хороололд агаарын бохирдолтой тэмцэх дээр богино хугацаанд яаралтай хийх ажлууд байна. Дунд хугацаанд байна. Урт хугацаанд байна. Урт хугацаандаа бол бид нар мэдээж орон сууцжуулалт дээр бол нэлээд бас анхаарч байгаа. Дээрээс нь энэ дулаан алдагдалгүй пассив хаус сүүлийн үед пассив апартамент гээд гарчихсан энэ рүү бид нар бас хурдан шилжих чиглэлээр ажиллаж байна. Мөн гэр хорооллын энэ бүх айл чинь нэг зэрэг орон сууцад орчихгүй. Тэгэхээр гэр хорооллын айлын хашианд энэ нарны панелуудыг тавих энэ ажлыг бас туршилтаар эхлүүлээд явж байгаа. Өөрөөр хэлбэл та нар мэдэж байгаа. Хөдөө орон нутагт очиход айл гаднаа бүгдээрээ нарны юу тавьчихсан, салхин сэнс тавьчихсан хэрэглээд болоод байхад хотын гэр хороолол яагаад хэрэглэж болохгүй гэж. Тийм учраас сэргээгдэх эрчим хүч рүү шилжих 2 дахь давлагааг яаралтай хийе гээд энэ дээр эхний 100 айл туршилтаар панелуудыг тавьсан байгаа. Тэгэхээр одоо бид нар энэ айлуудад боломжийг нь өгч байна. Үүнээс та тог авбал бараг үнэгүй авч байна. Эндээс байвал агаарын бохирдол ингэж ингэж үүсэж байгаа юм гэдэг ийм соён гэгээрүүлэх тайлбарлах ажлыг бол зэрэг хийгээд явах ёстой.

Манай яамнаас бол бодлогын хүрээнд бид нар ямар ажлыг эхлүүлэх гэж байгаа вэ гэхээр ногоон эрчим хүчинд шилжинэ гээд яриад байдаг. Яг ингээд хүн айл гэр худалдаж авах, аж ахуйн нэгж очоод худалдан авах төхөөрөмж нь нэг дор байдаггүй. Тийм учраас бид нар смарт сити буюу энэ бүх ногоон технологи энэ бохирдол гаргадаггүй бүх технологиудыг нэг дор багтаасан ийм байнгын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах гэж байгаа. Энэ дээр бол аж ахуйн нэгжүүд ороод, 1 дүгээрт аж ахуйн нэгжүүдийгээ маш сайн дэмжих ажил болж байгаа. Энэ

бүтээгдэхүүнээс та сонговол та ногоон зээлд хамрагдана. Энэ бол утаа гаргадаггүй, энэ бол цэвэр технологийн бүтээгдэхүүн юм гэдгийг бид нар нэг дороос пассив хаус барих гэсэнд нь сургалтыг нь хийнэ. Гэрийн дулаалга байна. Цахилгааны төрөл бүрийн батарейнууд гарсан. Нарны.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер. Төрийн нарийн хариулья.

Э.Баттулга: Ундраа гишүүний асуусан энэ усны бодлоготой холбоотой асуултад хариулья. Бид ер нь хуримтлуулах бодлогыг барьж байгаа. Эхнийх нь бол. Хуримтлуулахдаа мэдээж гадаргын усыг хуримтлуулна гээд түрүүн сайд хэлсэн. Бүх аймаг сумд 333 хөв гээд санаачилга өрнүүлээд явж байгаа. Улсын төсвөөс ч гэсэн хөрөнгө мөнгийг нь тавиад 1 загварын зураг хийгээд явж байгаа. 2 дахь нь газрын доорх усыг зориудаар баяжуулах гээд мар гэдэг нэртэй ийм төслийг бид нар туршилтын төсөл хэрэгжүүлж үзээд болсон. Тэгээд үерийн уснаас ус ихтэй үед газарт хуримтлагдсан усыг газрын гүн рүү буцааж хийж хуримтлуулдаг ийм технологийг бол Монгол Улс хэрэгжүүлэх ийм чиглэлийг бариад явж байгаа.

2 дахь нь бол ус дахин ашиглах асуудал байгаа. Ус дахин ашиглах дээр бол Монгол Улс маш том дэвшилийг хийж байгаа нь одоо энэ мянганы сорилтын сангийн 2 дахь шатын компакт гэрээний хүрээнд хийж байгаа ус дахин ашиглах төсөл, ус гүн цэвэршүүлэх.../минут дуусав/

Б.Бейсен: Гүйцээж хариулья. 4 номер.

Э.Баттулга: Өнөөдөр жишээлбэл Улаанбаатар хотын 3, 4 дүгээр цахилгаан станц бол хөргүүрийн усаа дан технологийн усыг бол гүний усыг ашигладаг. Тэгэхээр эндээс бол төв цэвэрлэх байгууламжаас гарсан усыг

дахин боловсруулж, саарал ус болгоод энийгээ станцууд руу дамжуулах шугамаар хүргээд дахин ашигладаг болж байгаа. Саарал усны хувьд бол бараг гүний усны хэрэглээг 40 орчим хувиар багасгаж байгаа ийм том ахиц дэвшилтэй ажил болж байна.

Усны нөөцийн хувьд гэвэл Монгол Улс 2023 онд 679,1 мянган м³ ус ашигласан байгаа юм. Улаанбаатар хот баруун эх үүсвэрийг шинээр нэмж байгаа. Тэгэхээр бол Био, Сонгиньн чиглэлд бол Улаанбаатар хотын өсөн нэмэгдэх хэрэглээг ойрын жилүүддээ хангах шинэ эх үүсвэртэй болж байгаа гэсэн мэдээллийг бас гишүүнд өгье.

Б.Бейсен: Гишүүд асуулт асуугаад дуусаж байх шиг байна. Би нэг хэд хэдэн санал хэлээдэхье. Энэ Алтай Таванбогд, Хотон Хурга нуурын аялал жуулчлалын бүс нутаг байна л даа. Бэлчээр ихээр сүйтгэгдэж байна. Өндөр хүчдэл татаад ноднин ингээд энэ жилийн төсөвт тусгаад өндөр хүчдэл нь явж байгаа. Энэ асуудал дээр тэр аялал жуулчлалын отог, ариун цэврийн асуудал тун хүнд. Энэ жил 47 мянган дотоодын жуулчид, гадаад, дотоодын жуулчид очсон байна. Энэ асуудал дээр сайд бас анхаарал тавихгүй бол болохгүй бас тийм нөхцөл байгаа юм байна. Нөгөө талаар Тэрбум модны хүрээнд төсөв хэрэгжилт нь ямар байна. Түрүүн би танайд аудит хийгээрэй гэсэн. Маш их хэмжээний төсөв тавигдаж байгаа. Үүний хэрэгжилт дээр нь шалгалт хийсэн үү гээд, хийгээд цаашидаа энэ дээр хийхгүй бол бас мэдээлэл ирж байгаа. Ер нь үүний хэрэгжилт муу бас төсвөө ашиглаж байгаа гэдэг асуудал байгаа.

Усны асуудал дээр энэ Монгол Улсын цэнгэг усны бараг 20, 30 хувийг бүрдүүлдэг Ховд гол, Хар ус нуур гээд нуур байгаа. Тийм ээ. Гэтэл үүний тэр Ховд голын юуны хавцлын тэнд том хэмжээний алтны уурхай, баяжуулах үйлдвэр барьсан. Цианит ашиглаж байгаа юм. Үер буух юм уу, ямар нэгэн

юмаар газар бохирдож байна уу. Үер буугаад тэр нь хайлбал Ховд гол тэр чигээрээ бохирдоод, загас тэгээд л шувуу, хүн ам хордох, үхэх бүрэн боломжтой. Энэ дээр ерөөсөө Байгаль орчны яамныхан очсон уу. Би бүр газар дээр нь очоод үзсэн. Хятад эзэнтэй. Бүр цагдаагаас хүн авааччихаад хүчээр орсон Маш том үйлдвэр шүү. Алтны агууламж маш ихтэй. Алтан толгой нэртэй гээд би түрүүн бас хэлсэн. Яаж мэдэх вэ Монголынхоо энэ төсөвт ийм хямралууд их хэмжээний хөрөнгө оруулалт хийх орд байж мэднэ. Энэ дээр анхаарлаа хандуулна уу гэдгийг хэлмээр байна.

Дараа нь цаг агаарын асуудал дээр ЦУОШГ-аас цаг агаарын төлөв байдлыг хэд хоногоор, хэдэн сараар мэдээлдэг юм. Энэ ирэх 11 сард, 10 сарын сүүлийн 7 хоног байна, 11 сард хур тунадас, салхи шуурга хэр байх юм. Тэр талаар мэдээлэл байна уу. Энэ талаар асууя.

Тэгээд утааны асуудал гэхээр чинь ер нь утаа дээр зарж байгаа яах вэ цахилгаан тэгээд нөгөө юуны талын асуудал байх л байх. Утаа түлж байгаа газраас би гадаадын юунуудаас асуусан чинь утаа түлж байгаа дээр та нар энэ юу гал түлж байгаа утаа гарахгүй яадаг юм. Ер нь амархан устахгүй гэж байна. Хэчнээн зуух сольсон ч гэсэн. Бид газ хэрэглэж байж салсан гээд ярьж байгаа юм нөгөөдүүл чинь, европынхон. Тэгэхээр энэ асуудал дээр бас утааны бид нар шинжилгээ хийлгэх асуудал, одоо нүүрс түлж байгаа сайжруулсан түлш түлж байгаа дээр нь түрүүн нөгөө анагаах шинжлэх ухааны эрдэмтэн тэгж байна. Энэ дээрээ шинжилгээ хийлгээч. Сайжруулсан түлшинд хүхэр ашиглаж байгаа. Энэ чинь бид нар хүхрээ газар булдаг биз дээ. Энэ аюултай гэж байна. Тэгэхээр энэ дээр шинжилгээ хийлгэх талын асуудал дээр нэлээн анхаарах шаардлагатай байна. Тийм л санаа хэлье.

Тэгээд саяын хэдэн асуулт дээр хариулт авъя. 4 номер.

Э.Баттулга: Бейсен гишүүний асуултад хариулъя. Энэ Хотон, Хурган нуур, Бага түргэний хүрхрээ орчмын Алтай Таванбогдын Улсын тусгай хамгаалалттай газрын ачаалал бол сүүлийн жилүүдэд маш их хэмжээгээр нэмэгдэж байгаа. Тэгээд Баруун бүсэд хэрэгжиж байгаа манай тусгай хамгаалалттай газар нутгуудыг бэхжүүлэх ийм төслийн шугамаар бол техник, тоног төхөөрөмж, хэрэгслийн хангалт маш сайн нэмэгдсэн. Дээрээс нь сайдын тушаалаар Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх 1 удаагийн хураамжийн үйлчилгээний хураамжийн хэмжээ 300 төгрөгөөс 3 мянга болж нэмэгдсэн учраас дотоод нөөц бололцоогоороо энэ хог хаягдлын болоод нүхэн жорлонтой холбоотой асуудлуудаа шинэчлээд, сайжруулаад яваарай гэсэн чиглэлийг өгчихсөн байгаа.

Баян-Өлгий аймагт үйл ажиллагаа явуулдаг Эс Жи компанийн алтны үндсэн ордыг гишүүн ярьж байх шиг байна. Энэ орд бол үнэхээр цианит натри ашиглах энэ тусгай зөвшөөрөлтэй, алтны олборлолт явуулдаг аж ахуйн нэгж байгаа. 2024 онд манай салбарын хяналтын газраас ажиллах үед бол үйл ажиллагаа явуулаагүй байна. Одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулаагүй байна. Гэхдээ бид нар бас энийг Баян-Өлгий аймгийн Байгаль орчны газартаа чиглэл өгөөд бас хяналтыг тавиулъя.

Аудитын тухайд бол Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тавигдаж байгаа төсөв дээр дотоод аудит, хяналт шалгалтыг цаг тухай бүрд нь хийгээд явж байгаа. Яг Үндэсний Аудитын газраас хийдэг аудитын тухайд гэвэл Улсын Их Хурлаар дараа жил хийгдэх аудитын сэдвийг баталдаг учраас Байнгын хорооноос энэ асуудлаар санал тавих юм бол сэдэвт батлагдсаны хүрээнд хийгдэх болов уу гэж харж байна. Баярлалаа.

Б.Бейсен: Тэр төлбөрийн асуудал тэр нэг хүн юм уу, нэг машин юм уу. 1

хүн дээр 3 мянга юм уу. Энэ төлбөр нь арай бага юм шиг байх юм. Та нар хар л даа. Тэнн 00 байхгүй. Ер нь 5 мянга болоход буруудах юм байхгүй шүү дээ. Нэг хүн дээр. Нэвтэрч байгаа юман дээр. Энэ дээр бас бодож үзээрэй.

Гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу. Мөнхбаясгалан гишүүн, Замира гишүүнээр тасаллаа. Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Ажиглаад байхад байгаль орчны үнэлгээ хийдэг жишээ нь уул уурхай ч юм уу ямар нэгэн байгууламж барихдаа тэр нь нэг ийм 4 хувь цээж зураг аваад ир гэдэг юм шиг ийм бичиг баримтын бүрдүүлэлт төдий болж хувираад байгаа юм. Байгаль орчны үнэлгээ танай яамнаас гарч байгаа тэр бичиг баримт бол тухайн байгууламж баригдах уу, үйл ажиллагаа явагдах уу гэдэг дээр асар том ач холбогдолтой байх ёстой байхгүй юу. Жишээ нь тэр бонд нээх, баяжуулах үйлдвэр нээх энэ болгон дээр энэ маш чухал байх ёстой. Яагаад гэвэл дэлхий нийтийн чиг хандлага өнөөдөр байгаль экологид, ногоон зээлд, байгалийн унаган төрхийг тэр чигээр нь авч үлдэхэд л энэ зээл чиглэж байгаа. Дэлхий нийтээрээ. Гэтэл өнөөдөр манай дээр байгаль орчны үнэлгээ гэдэг нь зүгээр нэг ийм бичиг баримтын бүрдүүлэлт төдий. Нэг тийм юм байх ёстой гээд ингээд аваад тавьчихдаг. Ийм байлгамааргүй байна. Хүчтэй баймаар байна.

Дээрээс нь тэр говийн усны төслийг бид хэд 10 хэдэн жилийн дараа ингээд л бас яриад сууж байх вий дээ гэдэг айдас төрөөд байгаа юм. Тийм учраас энэ дээр хурдтай, зоригтой ажилламаар байна. Улс төрийн дэмжлэг хүчтэй үзүүлье. Дээрээс нь хэвлэл мэдээллийн дэмжлэг хүчтэй үзүүлье. Говийн бүсийн 5 гишүүн, 7 гишүүн ч хамтрах байх. Өшөө шаардлагатай бол бид юу хийх ёстойг хамтарч байгаад ярилцаад, Засгийн газар дээр ажлын хэсгийг бол нэлээн тулгаж шахалттай ажилламаар байна. Дээрээс

нь тэр говьд амьдарч байгаа хүмүүс өнөөдөр эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй ус хүртэж байна. Ууж байгаа гэдгийг бид нар ингээд хараад өнөөдөр энд тайван суугаад байж болохгүй. Тэр 10, 10 тэрбум төгрөг яг тавигдах юм болов уу. Хэрвээ тэр тавигдахгүй бол бид нар бас өөр арга зам руу шилжих хэрэгтэй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ бүхнийг хамтарч хиймээр байна.

Дээрээс нь тэр уур амьсгалын өөрчлөлт гэдэг чинь нөлөөллийн бүсэд амьдарч байгаа иргэдээ бид яах юм. Нүүлгэн шилжүүлээд л амархан 5, 10 төгрөг өгчхөөд нүүлгээд байх юм уу. Эсвэл тэнд нь хүн амьдруулах юм уу,. Амьдруулахгүй юм уу. Хэзээ нэгэн цагт 3 Сайхан уул гэж нэг сайхан уул байсан юм даа гээд яриад сууж баймааргүй байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид яг юу хийх юм. Энийгээ тодорхой болгож өгөөч ээ. Тэгээд хамтарч ажиллах хэрэгтэй байна. Цаг хугацаа хүлээхгүй. Тийм учраас хурдтай л хиймээр байна. Баярлалаа.

Б.Бейсен: Замира гишүүн үг хэлнэ.

С.Замира: Энэ уур амьсгалын өөрчлөлт гээд Тэрбум мод гээд яриад байгаа л даа. тэгээд Тэрбум модны төсөл гээд баахан мөнгө зараад, тэгээд энэ мөнгө зарахгүйгээр ажиллах боломж байгаа л даа. Мөнгийг нь бас яах вэ зарцуулж ч бас болно. Бидний үед бол энэ сургуулийн сурагчид мод тарьдаг байсан юм. Яг биологийн хичээл хими, биологийн. Тэгээд хөдөлмөрийн хичээл гээд ороход багш нь удирдаад сургууль болгон хажуудаа мод тарьж, бас өөр бусад талбайд мод тарьдаг байсан юм. Тэрийг Боловсролын яамтай хамтраад хэрэгжүүлбэл яасан юм бэ. Тэгэх юм бол сургуульгүй газар байхгүй шүү дээ. Сурагчгүй газар байхгүй. Бүх сум, баг бүх газарт байгаа. Хотод хангалттай байна.

Тэгээд 2 дугаарт болохоор шинээр гэр бүл болсон хүмүүст мод тарих талбай гээд гаргачихвал тэнд өөрсдөө хосоороо очоод мод тарихад мод нь

хажууд бэлэн байвал очно л доо хүмүүс чинь тэнд. Албан ёсоор талбай бэлэн болговол.

3 дугаарт төрсөн өдөр гээд яваад байна шүү дээ хүмүүс. Төрсөн өдрөөр бас ингээд мод тарих талбайтай болговол энэ газарт төрсөн өдрийн мод тарина. Тэгээд тэнд дурсгалын зураг, бас ингээд хүмүүсийг урамшуулсан юмтай байвал хажууд нь.

2 дугаарт бол энэ гялгар уут гээд нэг хортой юм байна даа манай энэ Монгол оронд. Хаана очвол гялгар уут. Тэгээд энэ дээр хэдэн жилийн өмнө нэг хэрэгжүүлж байсан даа. Цаасан уут гээд хэрэгжүүлж байгаад орхичихсон. Яг түүн шиг цаасан утаа дахиж хэрэглэж үзвэл яасан юм бэ. Энэ гялгар уутыг оруулах, гаргах ер нь төрийн бодлогоор зогсоочихов. Хамгийн хортой юм чинь энэ гэж байна шүү. Бүх газрын энэ хөрсийг бохирдуулаад байгаа.

Тэгээд утаа гээд хэдэн жил ярилаа л даа. Хэчнээн их наяд ч цацагдсан байх. Сая Одонтуяа сайтад бас нэг гоё санаа ярилаа л даа. Сэргээгдэх эрчим хүчээр яагаад гэр хорооллыг яаж болохгүй гэж. Цахилгаанаар хангаж, тэгээд дулаанаар хангаж аль болох хоргүй юмыг хэрэглэж бид нар энэ утаанаас салах хэрэгтэй л дээ. Таны тэр санааг дэмжиж байгаа шүү. Энийг албан ёсоор болгоод төр засагтай хамтраад нэг шийдвэр гаргавал. Баярлалаа. Амжилт хүсье.

Б.Бейсен: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны мэдээлэлтэй холбогдуулаад гишүүд үг хэлж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд ажлын хэсгийнхэнд баярлалаа.

15.00 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ